



ХАРИЛЦАА ХОЛБОО,  
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР



СТРАТЕГИ АКАДЕМИ

ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН  
ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН  
ХҮНИЙ НӨӨЦИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН  
ТАЙЛАН

№ХХМТГ/201804011

Улаанбаатар

2019

# АГУУЛГА

АГУУЛГА .....	i
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	ii
НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР.....	iii
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ .....	iv
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ.....	v
НЭГ. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА .....	1
1.1 Хэрэгжүүлэх шаардлага, үндэслэл.....	1
1.2 Хөтөлбөрийн зорилго, зорилт.....	2
1.3 Хамрах хүрээ .....	2
1.4 Хөтөлбөрийн арга, аргачлал.....	3
ХОЁР. СУДАЛГААНЫ БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА .....	4
2.1 Хууль эрх зүйн баримт бичгүүд .....	4
Бодлогын баримт бичиг .....	7
Харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудангийн салбарын стандартууд .....	9
2.2 ХХМТ-ийн салбарийн зарим бодлогын баримт бичгийн хүний нөөцийн шинжилгээ .....	10
ГУРАВ. ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ.....	15
3.1 Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага .....	15
3.2 Харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарын хүний нөөцийн байдал .....	17
3.3 ХХМТ-ийн салбарын хөрөнгө оруулалт .....	58
3.4 Салбарын хөгжлийн тулгуур хүчин зүйлс.....	64
ДӨРӨВ. ХХМТ-ийн САЛБАРЫН ОЛОН УЛСЫН ТӨЛӨВ БАЙДАЛ .....	73
4.1 Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын олон улсын төлөв байдал.....	73
4.2 Олон улсын ХХМТ-ийн салбарын хүний нөөцийн төлөв байдал.....	95
4.3 ХХМТ-ийн салбарын үнэ цэнэ .....	100
4.3.1 Технологийн салбарын олон улсын дэвшил / эдийн засгийн салбараар / .....	100
4.3.2 Олон улсад ХХМТ-ийн салбарын хүний нөөцийн тулгамдаж буй асуудлыг шийдэх арга зам .....	109
4.3.3 ХХМТ-ийн салбарын хүний нөөцийн асуудал: .....	125
ТАВ. ДҮГНЭЛТ .....	130
ЗУРГАА. САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	133
ХАВСРАЛТ .....	1
Судалгааны дата бүрдүүлэлт.....	15

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БСШУСЯ	Боловсрол, Соёл Шинжлэх Ухаан, Спортын яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн Газар
ЗУХАГ	Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар
ЗБХГ	Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газар
ЗЗҮТҮСГ	Зах зээл үнэ тариф, үнэлгээ судалгааны газар
ИДС	Их дээд сургууль
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МХХТХ	Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил
МТ	Мэдээлэл технологи
МТҮП	Мэдээллийн технологийн үндэсний парк
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
РДЗХГ	Радио давтамжийн зохицуулалт хяналтын газар
ХХМТГ	Харилцаа Холбоо, Мэдээллийн Технологийн Газар
ХХЗХ	Харилцаа Холбооны Зохицуулах Хороо
УИХ	Улсын Их Хурал
СХЗҮЗ	Стандартчлал Хэмжил Зүйн Үндэсний Зөвлөл

## НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

*Харилцаа холбоо* гэж цахилгаан холбоо, радио телевиз, шуудан, мэдээллийн технологийн бүх төрлийг хэлнэ (Харилцаа холбооны тухай хууль 3.1.10)

*Шуудан* гэж шуудангийн илгээмжийг хаягласан эзэнд нь хүргэх үйлдвэрлэл-технологийн иж бүрэн үйл ажиллагаа бүхий харилцаа холбооны төрлийг хэлнэ. (Шуудангийн тухай хууль 3.1.1)

*Технологи* гэж оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын харилцан уялдаат үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргуудын цогцыг хэлнэ. (Шинжлэх ухаан, технологийн тухай 3.1.1)

*Мэдээллийн технологи* гэдэг компьютер дээр суурилсан мэдээллийн систем, програм хангамж болон техник хангамжийн дизайн, хөгжүүлэлт, хэрэгжүүлэлт, хангамж болон удирдлагыг судлахыг хэлнэ. (Америкийн Мэдээллийн Технологийн Холбоо -ИТАА)

*Цахим хувьсгал* гэдэг нь бизнесийн стратеги, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааг технологийн 4 гол чиг хандлагатай (Клауд, Ухаалаг утас, Нийгмийн сүлжээ системүүд, Их өгөгдөл) нягт уялдуулан хийхийг хэлнэ.

*Дижитал эдийн засаг* гэдэг нь тоон технологид суурилсан програмчлагдсан хийгээд цахим үйлдвэрлэл, цахим үйлчилгээ, цахим менежмент, цахим маркетингийн үйл явцад тулгуурласан эдийн засаг бөгөөд Internet Economy, New Economy, Knowledge Economy, Smart Economy, үүнээс салбарлан 3D Printing Economy, Web Economy гэх зэргээр янз бүрээр нэрлэж байна.

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 3.1 ХХМТ-ийн салбарын байгууллагын өмчийн хэлбэр .....	18
Хүснэгт 3.2 ХХМТ-ийн салбар ба бүртгэлтэй ААН-д ажиллагчдын тоо .....	19
Хүснэгт 3.3 Програм хангамж үйлдвэрлэл, мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж буй хугацаа .....	19
Хүснэгт 3.4 Програм хангамж, мэдээллийн технологийн чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ын эзлэх хувь .....	19
Хүснэгт 3.5 Мэдээлэл, холбооны салбарын хуулийн этгээд, 2011, 2016 он, эдийн засгийн үйл ажиллагааны дэд салбараар .....	21
Хүснэгт 3.6 Харилцаа холбооны салбарын салбарын хүний нөөцийн судалгаа /2013-2018.06.30/- эх сурвалж: ХХЗХ .....	21
Хүснэгт 3.7 Дээд боловсролын салбарт ажиллагчдын тоо (өмчийн хэлбэр, байршлаар) .....	25
Хүснэгт 3.8 Их, дээд сургуулийн үндсэн багш .....	26
Хүснэгт 3.9 ХХМТ-ийн чиглэлээр боловсон хүчин бэлтгэдэг Их дээд сургуулийн багшлах хүчний судалгаа .....	26
Хүснэгт 3.10 Суралцагчдын тоо (сургуулийн өмчийн хэлбэрээр) .....	30
Хүснэгт 3.11 Суралцагчдын тоо (сургуулийн ангиллаар) .....	31
Хүснэгт 3.12 Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын мэргэжлийн чиглэлийн эзлэх хувь (сүүлийн 5 жилээр) /тоогоор/ .....	32
Хүснэгт 3.13 ХХМТ-ийн хөгжлийн индексийн үзүүлэлтээр дэлхийн шилдэг 20 улсын жагсаалт .....	38
Хүснэгт 3.14 Харилцаа холбоо болон медиа (communication and media) чиглэлийн дэлхийн их дээд сургуулиудын эрэмбэ, 2018 .....	39
Хүснэгт 3.15 Харилцаа холбооны инженер (telecommunication engineering) дэлхийн их дээд сургуулиудын эрэмбэ, 2018 .....	39
Хүснэгт 3.16 Сургалтын хөтөлбөрийн ерөнхий төлөвлөгөө .....	41
Хүснэгт 3.17 ХХМТ-ийн чиглэлээр боловсон хүчин бэлтгэдэг голлох 3 сургуулийн оюутнуудтай хийсэн ярилцлагын харьцуулалт .....	69
Хүснэгт 4.1 ХХМТ-ийн хөгжлийн түвшин дэлхийн хэмжээнд .....	74
Хүснэгт 4.2 Дижитал эдийн засаг ба нийгмийн индекс (DESI) .....	91
Хүснэгт 4.3 ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн хүйс, боловсролын түвшин, нас 2007-2017 он (хувиар) .....	98

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. 1 Тус салбарын 3069 байгууллагын сүүлийн 5 жилд төлсөн татварын хэмжээ.....	20
График 1. 2 Хөдөлмөр эрхэлж буй их, дээд сургууль төгсөгчдийн дундаж цалин мэргэжлийн чиглэлээр /2017/ .....	34
График 1. 3 Хөдөлмөр эрхэлж буй МБСБ төгсөгчдийн сарын дундаж цалин, мэргэжлийн салбараар .....	34
График 1. 4 Ажил хайгаад олдохгүй байгаа ИДС төгсөгчид мэргэжлийн чиглэлээр, хувиар.....	35
График 1. 5 Ажил хайгаад олдохгүй байгаа МБСБ төгсөгчид мэргэжлийн чиглэлээр, хувиар.....	35
График 1. 6 Нийт ИДС төгсөгчид эзлэх хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн чиглэлээр.....	36
График 1. 7 Мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт орлого / тэрбум төгрөг/ .....	59
График 1. 8 Мэдээлэл, харилцаа холбооны төсөвт төвлөрүүлсэн орлого / тэрбум.төг / .....	59
График 1.9 Мэдээлэл, харилцаа холбооны төсөвт төвлөрүүдсэн орлогын бүтцэд эзлэх хувь .....	60
График 1.10 Мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт хөрөнгө оруулалт /тэрбум.төг/.....	60
График 1. 11 Мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт хөрөнгө оруулалтын бүтцэд эзлэх хувь .....	61
График 1. 12 Дэлхийн мэдээллийн технологийн салбарын зарцуулалт, 2014-2019.....	74
График 1. 13 Дэлхий даяар ИТ-ийн үйл ажиллагааны зарцуулалт, 2015-2020 .....	75
График 1. 14 2016- 2027 он гэхэд дэлхий даяар их өгөдлийн орлого, томоохон сегментээр (тэрбум ам. Доллар).....	79
График 1. 15 Дэлхийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын 2005-2019 оны орлого (тэрбум евро) .....	82
График 1. 16 2010-2022 онуудад (сая нэгжээр) tablets, зөөврийн компьютер, ширээний PC-ийн тээвэрлэлтийн урьдчилсан мэдээ .....	83
График 1. 17 ХХМТ-ийн салбарын нийт технологийн зардал (ам. доллар) .....	84

# НЭГ. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Хэрэгжүүлэх шаардлага, үндэслэл

Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн байгууллагын үндэс суурь анх 1921 онд тавигдсан түүхтэй. Өнөөдөр харилцаа холбоо, мэдээллийн технологийн хөгжил нь дэлхий дахинд маш хурдацтай явагдаж байгаа төдийгүй улс орнуудын нийгэм, эдийн засаг, хүний хөгжил, эрх чөлөөний баталгаажуулалтын чухал хүчин зүйл болж байна. Дэлхийн улс орнууд 2000 оноос эдийн засгийн өсөлтийг хангах, нийгмийн хөгжлийн хурдасгагч үндсэн хэрэгсэл болох мэдээллийн технологийг ашиглан, мэдлэг оюунд суурилсан мэдээлэлжсэн нийгэм байгуулах зорилт дэвшүүлж хэрэгжүүлж эхэлсэн байдаг. Монгол Улсын хувьд ч дэлхийн хурдацтай хөгжлөөс хоцрохгүй хөл нийлүүлэн алхахын тулд ХХМТ-ийн дэд бүтцийг хөгжүүлэх, инновацид суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мэдээлэл хүртэх тэгш бус байдлыг арилгах, эрх зүйн тааламжтай орчинг бүрдүүлэх, ХХМТ-ийн мэргэжилтэй боловсон хүчний талаарх статистик мэдээллийн нэгдсэн бааз бий болгох, орчин үеийн шинэ хөгжил дэвшил, зорилт чиглэлд нийцсэн хүний нөөцийг бэлтгэх шаардлагатай байна. 2017 байдлаар Монгол улс ХХМТ-ийн хөгжлийн индексээр дэлхийн 176 орноос 91-д, дижитал өрсөлдөх чадварын индексээр 61-т, цахим засгийн хөгжлийн индексээр 92-т, цахим аюулгүй байдлын индексээр 103-т тус тус эрэмбэлэгдэж байна. Өдгөө Монгол Улсын ХХМТ-ын салбар нь ДНБ-ий 2,4 хувийг бүрдүүлж байгаа ба техник технологийн хурдацтай хөгжил, дэлхий нийтийн эрэлттэй холбоотойгоор энэхүү үзүүлэлт нь өсөх хэтийн төлөв ажиглагдаж байна.

2018 оны байдлаар БСШУСЯ-нд зөвшөөрөлтэй 96 их дээд сургууль, коллежид 155248 суралцагчид сурч байна. Дээрх сургуулиудын 40 орчим нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр боловсон хүчин бэлтгэдэг ба энэ онд 3606 буюу нийт суралцагчдын 2,3% ХХМТ-ийн чиглэлээр суралцаж байна. БСШУСЯ-аас гаргасан судалгаагаар энэ чиглэлээр суралцагчдын тоо сүүлийн 5 жилд тогтмол буурах хандлага ажиглагдаж байгаа. Үүнтэй холбоотойгоор ХХМТ салбарын хүний нөөцийн эрэлт үүсч байна гэж харж байна. Дэлхий нийтээр мэдлэгт тулгуурласан бүтээгдэхүүн, электрон хэлбэрийн ажил үйлчилгээг хөгжүүлэхийг чухалчлан авч үзэж байгаа энэ цаг үед мэдээллийн технологийн мэргэжилтнээр монгол төдийгүй дэлхийн олон орон дутагдаж байна. Манай орны хувьд ХХМТ-ийн ололт, амжилтыг нэвтрүүлэн түүнийг хөгжлийн тулгуур, тэргүүлэх чиглэл болгон мэдээлэлжсэн нийгмийг байгуулахын тулд чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэх нь нэн тэргүүний асуудал юм. Иймд энэ чиглэлээр үүсч байгаа хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн үндсэн шалтгааныг тодорхойлох, ХХМТ чиглэлээр хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэгдэж байгаа төгсөгчид болон тэдгээрийг хүлээн авах ажлын байрны эрэлт хоёрын зохистой харьцааны талаар нарийвчилсан судалгаа хийх бодит хэрэгцээ байгааг харж болно. Мөн мэдээлэл, харилцаа холбоо технологийн чиглэлээр их, дээд сургуульд элсэгчдийн тоог

нэмэгдүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, чадварлаг мэргэжилтэнг бэлтгэх хүчин зүйлсийг хөгжүүлэх ХХМТ-ийн эрдмийн зэрэг цолтой мэргэжилтнүүдийн тоо, эзлэх хувийг нэмэгдүүлэх ХХМТ-ийн боловсролын олон улсын стандартыг нэвтрүүлж, түвшин тогтоох тогтолцоог бий болгох шаардлага энэ чиглэлийн хүний нөөцийн нарийн тооцоо, судалгаа хийх үндэслэл болж байна.

## **1.2 Хөтөлбөрийн зорилго, зорилт**

### **1.2.1 Хөтөлбөрийн зорилго**

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн Харилцаа холбоо, мэдээллийн технологийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх болон төрөөс ХХМТ-ийн мэргэжилтэй боловсон хүчний талаарх бодлого боловсруулахад шаардлагатай статистик тоо баримт бүхий ХХМТ-ийн салбарын хүний нөөцийн мэдээллийн бааз бий болгоход оршино.

### **1.2.2 Хөтөлбөрийн зорилт**

ХХМТ-ийн салбарын хүний нөөцийн судалгаа хийх ажлын хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

1.2.2.1 Зорилт 1. ХХМТ-ийн мэргэжилтэй боловсон хүчний талаарх судалгаа хийх.

1.2.2.2 Зорилт 2. ХХМТ-ийн салбарт болон энэ чиглэлээр ажиллаж буй боловсон хүчний талаарх судалгаа хийх.

1.2.2.3 Зорилт 3. ХХМТ-ийн салбарын хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн талаарх судалгаа хийх

1.2.2.4 Зорилт 4. ХХМТ-ийн мэргэжилтэн боловсон хүчнийг бэлтгэдэг хүний нөөцийн талаарх судалгаа хийх

## **1.3 Хамрах хүрээ**

Монгол улсад ХХМТ-ийн салбарын хүний нөөцийн судалгааны мэдээллийн бааз үүсгэх ажлын хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- БСШУСЯ-ны зөвшөөрөлтэй ХХМТ-ийн чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг сургалтын байгууллагууд (их дээд сургуулиуд, сургалтын төвүүд), ААНБ болон ХХМТ-ийн салбарын үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагууд
- ХХМТ-ийн чиглэлээр дотоод, гадаадад суралцагч нар, тэдгээрийг бэлтгэдэг эрдэмтэн, багш боловсон хүчин болон энэ салбарт ажилладаг мэргэжилтэн, албан хаагч нар



- Олон улсын туршлагыг судлах: ХХМТ-ийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх ОУ-ын их дээд сургуулиудын сургалтын тогтолцоо хөтөлбөр, чиг хандлагыг тодорхойлохын тулд ХХМТ-ийн чиглэлээр тэргүүлэгч улс орнууд болон Харилцаа холбоо, хэвлэл мэдээлэл болон програм хангамж, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг дэлхийд тэргүүлэгч олон улсын их дээд сургуулиудын (АНУ, Англи, Швейцарь, Сингапур, БНХАУ, Канад, Австрали, Япон, Өмнөд Солонгос...) тоо баримт дээр тулгуурлан тодорхой тооны улсуудаар жишээ аван, түүврийн төлөөллийг хангах болно.

## **1.4 Хөтөлбөрийн арга, аргачлал**

### **1.4.1 Судалгааны арга**

Судалгааны ажлын хөтөлбөрийн зорилго, зорилт болон судалгааны дэвшүүлсэн асуудлын дагуу мэдээлэл цуглуулахад тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан хийж гүйцэтгэв.

Тоон судалгааны арга:

Үр дүн нь тоон хэлбэртэй байх ба хоёрдагч эх сурвалжаас авсан дата мэдээллүүдийг нэгтгэн, харьцуулах замаар үр дүнг тооцон гаргадаг. Үүнд:

Баримт бичгийн судалгаа: ХХМТ болон уг салбарын үйл ажиллагаа, боловсон хүчний талаарх холбогдох хууль эрхзүйн актуудын ( төрөөс баримтлах бодлого, хууль, дүрэм журам, стандарт, байгууллагын үйл ажиллагааны тайлан, төсөв санхүү) баримт бичгийн судалгааг хийж, ХХМТ-ийн салбарын хүний нөөцийн бодлогын талаарх хууль эрхзүйн орчинг тодорхойлох.

Статистик тоон мэдээллийн арга:

ХХМТ-ийн чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг их дээд сургуулиуд, ААНБ-ууд, түүнд суралцагсад, мөн олон улсад энэ чиглэлээр суралцагсад, ХХМТ-ийн салбарт ажилладаг мэргэжилтнүүд, ажлын байрны эрэлт хэрэгцээ, ХХМТ-ийн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэдэг багш, эрдэмтэд, сургалтын байгууллага зэрэг маш өргөн хүрээг хамарсан статистик тоон мэдээллүүдийг бүх эх сурвалжаас түүвэрлэн, ангилах, түүвэрчлэх, нэгтгэх, тусгай аргачлалаар тооцох замаар захилагчийн хүссэн дата мэдээллийн нэгдсэн санг үүсгэнэ.

Анкетийн арга: Судалгааны асуудал, хамрах хүрээнд урьдчилан боловсруулсан асуумжийн дагуу анкетын санал асуулгыг судалгаанд оролцогчдын тодорхой төлөөллөөс түүвэрлэн онлайнаар болон цаасаар авах.

Чанарын судалгааны арга:

Ярилцлага: Харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбар, системтэй холбогдох бүх төрийн байгууллага болон хувийн ААН-үүд, их дээд сургуулиудын мэргэжлийн экспертүүдээс ганцаарчилсан ярилцлага авах.

Карт хөтлөх арга: Судалгаанд хамрагдаж байгаа түүврийн төлөөлөл бүрээс тодорхой асуулга бүхий картыг бөглүүлж авах. Тухайлбал: ХХМТ-ийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх талаарх судалгааг хийхэд хэд хэдэн төрлийн карт бөглөж, мэдээллийн бааз бий болгох, архивлах, электрон сан үүсгэх боломжтой бөгөөд судлаач судалгаанд оролцогчдоос биечлэн асууж тодруулан, картыг бөглөх маягаар явагдана.

## **ХОЁР. СУДАЛГААНЫ БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА**

### **2.1 Хууль эрх зүйн баримт бичгүүд**

Монголын Харилцаа холбооны үүсэл хөгжлийн үндэс нь 1921 оны VII сарын 19-нд Ардын Засгийн газрын шийдвэр гарсанаар тавигдаж байжээ. Өнөөдөр Манай улсад Харилцаа холбоо, шуудан харилцааны системийг зохион байгуулж, үйл ажиллагаагаа явуулдаг Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг болох Харилцаа холбоо, Мэдээллийн Технологийн Газар<sup>1</sup>, Харилцаа холбооны Зохицуулах хороо<sup>2</sup>, Монгол шуудан ХК<sup>3</sup> зэрэг байгууллагууд тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.

Асар хурдацтай хөгжиж буй энэ салбарыг хөгжүүлэх, түүний ололт амжилтыг нийгэм, эдийн засгийн бүх салбарт үр ашигтай нэвтрүүлэх талаар нарийвчилсан судалгаа хийх, энэ салбарын хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилт, чиг хандлагыг зөв тодорхойлох явдал чухал болоод байна. Үүнтэй холбоотойгоор мэдээллийн технологийн салбарын хөгжлийн түлхүүрийг тодорхойлсон баримт бичгийг Монгол улсын төрөөс боловсруулан хэрэгжүүлдэг.

Монгол улс ХХМТ-ийн салбарын дэлхийн хэмжээний стандартыг хангахын тулд эрх зүйн орчны тогтолцоо, сүлжээ дэд бүтэц, үйлчилгээ, инноваци-судалгаа, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, өрсөлдөөн, мэдээллийн аюулгүй байдал, цахим засаглалыг хөгжүүлэх зорилго тавин ажилладаг. Монгол улсад Харилцаа холбоо,

---

<sup>1</sup>МУ-ын Ерөнхий сайдын 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 69 тоот захирамжаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар нэртэй болж, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөв.

<sup>2</sup>1999 онд Дэд бүтцийн хөгжлийн сайдын 79 тоот тушаалаар Харилцаа холбооны зохицуулах зөвлөл Шуудан цахилгаан холбооны газрын харъяанд бие даасан байдлаар зохион байгуулагдсан.

<sup>3</sup>2016 онд Монгол шуудан ХК болж зохион байгуулагдсан.

мэдээллийн технологи, улсын бүртгэл, хаягжилт, шуудангийн системийн талаар тусгасан хүчин төгөлдөр үйлчилж буй бие даасан болон холбогдох хууль, бодлого хөтөлбөр, дүрэм, журам, стандартуудыг батлан, тэдгээрийн хэрэгжилтийг тодорхой түвшинд ханган ажиллаж байна. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн талаар хууль эрх зүйн баримт бичгүүдэд хэрхэн тусгасныг авч үзье.

#### **ХХМТ-ийн салбарын үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомжууд:**

1. Харилцаа холбооны тухай хууль
2. Шуудангийн тухай хууль
3. Радио долгионы тухай хууль
4. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль
5. Цахим гарын үсгийн тухай хууль
6. Инновацийн тухай хууль
7. Шилэн дансны тухай хууль
8. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль
9. Патентийн тухай хууль
10. Төсвийн тухай хууль
11. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
12. Төрийн хяналт шалгалтын тухай хууль
13. Төрийн албаны тухай хууль
14. Хөдөлмөрийн тухай хууль
15. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
16. Төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль
17. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
18. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль

#### **Дүрэм журам**

1. Мэдээллийн технологийн үндэсний парк байгуулах тухай /ЗГ 2002.05.29 №107/
2. Улс хоорондын шуудангийн илгээмжийн гаалийн бүрдүүлэлтийн журам /СЭЗС, дбс 2004 №109/86/
3. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам /ТАЗ 2004.06.15 №18/
4. Зөвлөхөөс бусад үйлчилгээний тендерийн жишиг баримт бичиг /СС-ын 2007.06.22-ны 176 дугаар тушаал/
5. Тендер шалгаруулалтын явц, үр дүнг хянаж зөвшөөрөл огох журам /СС-ын 2007.05.25-ны 145 дугаар тушаал/

6. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн дүрэм /ЗГ-ын тогтоол 2009 151 дүгээр тогтоол/
7. Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам /ЗГХЭГ-ын дарга, сс 2010.01.28 30/20 дугаар тушаал/
8. Эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай /ТӨХ 2012.02.16 №44/
9. Эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай /ТӨХ 2012.02.16 №44/
10. Бараа нийлүүлэх тендерийн жишиг баримт бичиг /2012.03.29 №81/
11. Му-ын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай /УИХ 2012.09.18 №37/
12. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг төлөвлөх, тайлагнах журам /СС 2012.12.13 №264/
13. Тендерийн үнэлгээний заавар /СС 2012.09.28 №194/
14. Шуудангийн үйлчилгээний давуу эрхийн бүс, бүх нийтийн үйлчилгээний төрлийг шинэчлэн тогтоох тухай /ЕС-ын захирамж 2013.01.29 №24/
15. Бүсчлэлийн код батлах тухай /ЕС-ын захирамж 2013.06.27 №99/
16. Шуудангийн маркийн сэдвийн төлөвлөгөө батлах тухай /ЕС-ын захирамж 2013.09.23 №140/
17. Мэдээлэл өгөх үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам /ЗГ 2013.02.16 №54/
18. Худалдан авах ажиллагааны босго үнэ шинэчлэн батлах тухай /ЗГ 2013.03.02 №68/
19. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд хөрөнгө гаргах тухай /ЗГ 2013.03.02 №70/
20. Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам /СС 2013.03.29 №73/
21. Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах тухай /ЗГ 2013.06.15 №212/
22. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам /ЗГ 2013.08.02 №280/
23. Монгол улсын дипломат паспорт, буцах үнэмлэх олгох журам /ЗГ 2013 №320/
24. Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам /ЗГ 2013.09.21 №322/
25. Бэлэн бус торгуулийн системийн түр журам /ЗГ 2013.11.30 388/
26. Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам /ЗГ 2013.12.14 №410/
27. Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам /ЗГ 2013.12.14 №411/
28. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам /СС 2013.01.11 №07/
29. Ерөнхий гэрээ байгуулах журам /СС 2013.09.25 №213/

30. Гаалийн албан татвар, нөат-аас чөлөөлөгдөх тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалт батлах тухай /ЗГ 2014.06.14 №191/
31. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай /ЗГ 2014.10.11 №332/
32. Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам /ЗГ 2014.12.30 №405/
33. Эдийн засгийн ангилал батлах тухай /СС 2014.01.10 №5/
34. Төрийн үйлчилгээний цахим машины талаар авах зарим арга хэмжээний тухай №23
35. Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх журам /зг-ын 2011 оны 62 дугаар тогтоол/
36. Төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулах журам /ЗГ-ын 1997 оны 253 дугаар тогтоол/
37. Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, энэ талаар төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журам /ЗГ-ын 1995 оны 97 дугаар тогтоол/
38. Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт /ЗГ-ын 2009 оны 143 дугаар тогтоол/
39. Шагналын журам тэмдгийн загвар батлах тухай

### **Бодлогын баримт бичиг**

Харилцаа холбоо, мэдээллийн технологи өндөр хөгжсөн улс орнуудын туршлагыг судалж үзэхэд энэ салбарын талаар төр, засгийн зүгээс онцгой анхаарч тэргүүлэх чиглэлээ болгон тодорхойлон үе шаттай, олон талт арга хэмжээ хэрэгжүүлсэн нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байдаг. Өргөн уудам газар нутагтай, байгалийн эрс тэс уур амьсгалтай, хүн ам тархай суурьшсан манай улсын хувьд тус салбарыг амжилттай хөгжүүлж нийгэм, эдийн засгийн бусад салбарын хөгжлийг дэмжих явдал чухал ач холбогдолтой байна. Дор мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжүүлэх талаар төрөөс баримталж буй бодлогын баримт бичгийг дурдав.

#### **Хүснэгт 2. 1 ХХМТ-ийн салбартай холбоотой бодлогын баримт бичгүүд**

№	Баримт бичгийн нэр	Батлагдсан огноо
1	Монгол Улсад үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр 2008-2015	2007
2	Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө	2007
3	Үндэсний хөгжлийн цогц бодлого	2008

4	МУ-д интернет протоколд суурилсан телевизийн үйлчилгээг нэвтрүүлэхэд баримтлах чиглэл	2009
5	МУ-д хөдөлгөөнт телевизийн үйлчилгээг нэвтрүүлэхэд баримтлах чиглэл	2009
6	Монгол улсад интернет протоколд суурилсан телевиз (IPTV)-ийн үйлчилгээг нэвтрүүлэхэд баримтлах чиглэл	2009
7	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр	2010
8	Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх хөтөлбөр	2010
9	Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого	2010
10	МУ-д тоон радио өргөн нэвтрүүлгийг нэвтрүүлэхэд баримтлах чиглэл	2011
11	Монгол улсад телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системээр дамжуулахад баримтлах чиглэл	2011
12	Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ үндэсний хөтөлбөр	2011
13	Өрх бүрт шуудан хөтөлбөр	2011
14	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2012-2016	2012
15	ЗГҮАХ батлах тухай 2012-2016	2012
16	Монгол Улсын үндэсний хиймэл дагуул хөтөлбөр	2012
17	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	2012
18	Цахим засаг үндэсний хөтөлбөр	2012
19	Үндэсний радио давтамжийн зурвасын төлөвлөлтийг батлах тухай	2013
20	МТШХХГ-ын төрийн албан хаагчийн сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр	2013
21	Сүлжээний нэгдсэн төлөвлөлт батлах тухай	2013

22	МТШХХ-ны салбарын төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	2014
23	Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг ашиглах талаар төрөөс баримтлах бодлогын чиглэл	2015
24	Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийн тоон технологид шилжүүлэх баримтлах чиглэл	2017
25	“Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	2017
26	Мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөлийн зөвлөмж-02 20180118	2018
27	Мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөлийн зөвлөмж-03 20180208	2018

### **Харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудангийн салбарын стандартууд**

2018 оны байдлаар харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудангийн чиглэлээр 200 гаруй стандарт мөрдөгдөж байна. Монгол улсын мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарт сүүлийн жилүүдэд шинээр стандартыг боловсруулахаас гадна олон улсын стандартыг өөрийн орны нөхцөлд тохируулан үндэсний стандарт болгон нутагшуулах асуудал сүүлийн жилүүдэд нэлээд эрчимжиж байна. Шинэчлэгдсэн Харилцаа холбооны тухай хуулиар салбарын стандартыг боловсруулах, түүний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ХХЗХ-нд үүрэг болгосон билээ. Тус хороо нь энэхүү стандарт боловсруулах ажлыг харилцаа холбооны байгууллагууд, эрдэмтэд, инженер техникийн албадын хүрээнд зохион байгуулж, хамтран ажиллаж байгаа бөгөөд 2003 оноос эхлэн ХХЗХ-ны төсвөөр 100 гаруй стандартыг шинээр боловсруулан батлуулсан байгаа ч энэ салбарын хүний нөөцтэй холбоотой стандартууд төдийлөн их байгаа нь ажиглагдаж байна. ХХМТ-ын салбарт хэрэгжиж байгаа хүний нөөцтэй холбогдох стандартууд:

1. Шуудангийн ажлын байр
2. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний ажилтанд тавих шаардлага
3. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний ажлын байранд тавих шаардлага
4. Мэдээллийн технологийн инженерийн ур чадвар. Мэдээллийн технологийн нийтлэг мэдлэг

## 5. Мэдээллийн технологийн суурь мэдлэгийн шалгуур

### 2.2 ХХМТ-ийн салбарийн зарим бодлогын баримт бичгийн хүний нөөцийн шинжилгээ

ХХМТ-ийн салбарын хөгжил, гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч энэ талаар НҮБ-аас онцгойлон анхаарч түүний ивээл дор “Мэдээлэлжсэн нийгмийн асуудлаарх дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалт”-ыг 2 үе шаттайгаар зохион байгуулж эхний үе шатаас “Зарчмын тунхаг”, “Үйл ажиллагааны хөтөлбөр” гэсэн 2 баримт бичгийг баталж хэрэгжүүлсэн байна. Эдгээр баримт бичгүүдэд улс орон бүр мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжүүлэх талаар төрийн бодлогоо тодорхойлох, тус салбарын тогтолцоог боловсронгуй болгохыг улс орнуудын төр, засагт уриалсан билээ. Энэ уриалгын дагуу Монгол орон мэдээлэл, харилцаа холбооны технологийн ололт амжилт, түүний боломжид ихээхэн ач холбогдол өгч тодорхой үзэл баримтлал, хөтөлбөр, бодлогын баримт боловсруулан хэрэгжүүлж байна. Эдгээрээс ХХМТ-ийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах чиглэлээр тусгагдсан зүйл заалтууд болон хэрэгжүүлж буй зарим бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгээс авч үзвэл:

#### **Нэг. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр**

##### Төсөл, хөтөлбөрийн зорилго:

Монгол Улсын төрийн байгууллага, төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын цахим мэдээллийн сан, мэдээлэл түүнийг дэмжих дэд бүтцийн цахим аюулгүй байдлыг хангах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх замаар үндэсний аюулгүй байдал, иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулахад оршино.

Энэхүү хөтөлбөрийн зорилт 3-д тусгасан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээний соёл бий болгон төлөвшүүлэх, иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийн таатай орчин бүрдүүлэх” ажлын хүрээнд тодорхой ажлуудыг гүйцэтгэсэн байдаг. Тухайлбал:

- Мэдээллийн аюулгүй байдлын талаар мэргэшүүлэх сургалтын тогтолцоог бий болгох, төрийн байгууллага болон онц чухал объектод ажиллах мэдээллийн технологийн ажилтан, мэдээллийн аюулгүй байдлын ажилтан, систем администраторыг зохих сургалтад хамруулж, гэрчилгээжүүлэх ажлын явц хангалтгүй байгаа бөгөөд цаашид сургалтын хөтөлбөрийг тогтмол шинэчилж зохион байгуулах шаардлагатай байна.
- Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр багшлах, онц чухал дэд бүтцэд ажиллах нарийн мэргэжлийн ажилтныг гадаадад сургаж, мэргэшүүлэх, энэ чиглэлээр онлайн хэлбэрийн сургалтын ажлын эхлэл тавигдсан байдаг.
- Төрийн жинхэнэ албан хаагчийн шалгалтын тестэд мэдээллийн аюулгүй байдлын талаархи асуудлыг оруулсан бөгөөд энэ нь төрийн албан хаагчдын энэ



чиглэлийн мэдээлэл, мэдлэгийн ач холбогдлын талаар сурталчилж буй нэгэн хэлбэр юм.

- Зохиогчийн эрх, оюуны өмчийн эрхийг хамгаалах талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа бөгөөд энэ чиглэлээр бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээ аван ажиллаж байна.

Өнөөдөр Монгол оронд төдийгүй дэлхийн олон орон чадварлаг боловсон хүчний дутагдалд ороод байгаа билээ. 2016 оны судалгаанаас үзэхэд мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтний дундаж цалин 2011 оноос 2016 он хүртэл 33 хувиар өсч, 84,864 ам.доллараас 112,996 ам.долларт хүрсэн байна. Монголын мэдээллийн технологийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн удирдлагуудтай ярилцлага хийхэд мэдээллийн аюулгүй байдлын ажлын байранд 3 сая төгрөгийн цалин амлаад санал тавихад тохирох хүн олддоггүй байна. Манай орон мөн ХХМТ-ийн салбарын мэргэжилтэй боловсон хүчний хомсдлын нэгэн илрэл бөгөөд энэхүү хомсдолын улмаас манай бизнесийн болоод төрийн байгууллагууд гаднаас өндөр өртгөөр боловсон хүчин урьж ажиллуулах үзэгдэл элбэг болжээ. Энэ нь Монголын өнөөгийн хүний нөөцийн салбарын нэг чиг хандлага болоод байгаа юм. Цаашид мэдээлэл, харилцаа холбооны мэргэжлийн сургуульд мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр шинэ мэргэжил нээж, мэргэшсэн ажилтан бэлтгэх шаардлага байна.

### **Хоёр. Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого**

Өндөр технологийн аж үйлдвэрийн салбар нь Монгол Улсын хөгжлийг эрчимжүүлэх, мэдлэгт суурилсан эдийн засгийн үндсийг тавих гол салбарын нэг юм. Өндөр технологийн аж үйлдвэр гэдэгт: инновацийн дэвшилтэт ололтыг нэвтрүүлэх замаар нэмүү өртөг ихээр шингээсэн бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг, тухайн бүтээгдэхүүний нийт өртөгт түүнийг бий болгоход зарцуулсан судалгаа хөгжлийн зардал өндөр хувийг эзэлдэг эдийн засгийн салбарыг ойлгоно. Өндөр технологийн салбарт биотехнологи, нанотехнологи, мэдээллийн технологи, электроникийн салбар багтана.

Өндөр технологийн аж үйлдвэр нь: Монгол Улсыг хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, уул уурхайн олборлох үйлдвэрлэлд түшиглэсэн эдийн засгаас тэргүүний, дэвшилтэт мэдлэг, технологид суурилсан мэдлэгийн эдийн засагт шилжүүлэх гарц, аж үйлдвэрийн төрөлжилтийг эрчимжүүлэн үндэсний баялгийг богино хугацаанд эрс нэмэгдүүлэх, улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх арга зам, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар бүхий үндэсний боловсрол, судалгаа хөгжил, технологи, аж үйлдвэр, санхүү, борлуулалтын сүлжээг бий болгох үндсэн хүчин зүйл юм.

2010 оны байдлаар Монгол Улсын экспортын бүтээгдэхүүний 83.22 хувь нь технологийн багтаамжгүй, 15.12 хувь нь нам технологит, 0.02 хувь нь өндөр технологит бүтээгдэхүүн тус тус эзэлсэн байна. Үүнээс үзэхэд манай улсын эдийн засаг уул уурхай,

мал аж ахуйн түүхий эдийн нийлүүлэлт болон дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн хэлбэлзэлтээс хараат, эмзэг тогтворгүй байдалтай байгаа юм. Өндөр технологийн аж үйлдвэрийн салбар нь урт хугацаанд Монгол Улсын ирээдүйн тогтвортой хөгжлийг хангах тулгуур хүчин зүйл болох учиртай. Ийнхүү дунд хугацаанд биотехнологи, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлснээр хөдөө аж ахуйн түүхий эд, байгалийн баялагийн нөөц, боломжинд тулгуурласан эмийн болон биологийн идэвхт бодис, гадаадын өндөр технологийн үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмжийн сэлбэг эд, анги, програм хангамжийг үйлдвэрлэх, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий шинэ бүтээгдэхүүнийг бий болгож манай улсын эдийн засгийн өсөлтийг бодитой нэмэгдүүлэх бололцоотой юм.

Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр бодлого, стратегийг боловсруулж хэрэгжүүлж эхлээд байгаа хэдий ч үр дүн төдийлөн сайн харагдахгүй байгаа юм. Мөн өндөр технологийн чиглэлээр магистрын болон докторын сургалтад суралцагчдыг тэтгэлэгт хөтөлбөрт тэргүүн ээлжинд хамруулах, уг салбарт үйл ажиллагаа явуулдаг компанийн захиалсан чиглэлийн дагуу сургалтын төрийн сан, Инновацийн сангийн санхүүжилт, бусад тэтгэлгээр дэлхийн тэргүүлэх их сургуулиудад мэргэжилтэн бэлтгэх тухай асуудлыг энэ бодлогын баримт бичигт тусгасан байдаг.

Өндөр технологийн аж үйлдвэрийн салбарт шаардлагатай өндөр мэргэшсэн боловсон хүчнийг гадаадаас урьж ажиллуулах эрх зүй, эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна. Мөн энэ салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа дотоодын аж ахуйн нэгжийг, энэ чиглэлээр гадаадад сурч, ажиллаж байгаа монгол иргэдтэй холбоо тогтоох, хамтран ажиллах үйл ажиллагааг зохион байгуулж, гадаадад өндөр технологийн мэргэжлээр суралцаж төгсөгчдөд эх орондоо судалгаа, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь бүх талын дэмжлэг дутагдсаар байна.

## **Гурав. Цахим засаг үндэсний хөтөлбөр**

Хөтөлбөрийн зорилго:

Төрийн байгууллагыг холбосон мэдээллийн технологийн дэд бүтцийг байгуулан мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглах замаар төрийн бодлого боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, мэдээ, мэдээллийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэж, төрийн ой санамжийг төгөлдөржүүлэх, түүнд суурилсан цахим засгийн үйлчилгээг хөгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино. ХХМТ-ийн салбарын хамгийн гол тоглогч нь төр өөрөө байдаг. Иймд төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэж байгаа албан хаагчдыг чадавхижуулах нь мэдээллийн технологийн хөгжлийн бас нэгэн хурдасгуур болох юм. Цахим засаг хөтөлбөрийн 4 дүгээр зорилтод тусгаснаар “Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг

дээшлүүлэх, төрийн цахим үйлчилгээг ашиглах мэдлэг иргэдэд олгох” дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн:

Сургалтын өрөөг тохижуулан, компьютер, техник тоног төхөөрөмж, шаардлагатай бусад зүйлээр ханган, сургалтын үйл ажиллагааг явуулж байна. Жил бүр сургалтын төлөвлөгөөг батлан, иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн технологийн болон бусад чиглэлээр холбогдох сургалтыг зохион байгуулж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлж байна.

Технологийн мэргэжилтэн, мэргэжлийн багш нарын мэдлэг, ур чадварыг олон улсын түвшинд хүргэх, орон нутагт мэргэжлийн боловсон хүчнээр хангах ажлын хүрээнд:

Төрийн байгууллагад ажиллаж байгаа мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтний ур чадварыг сайжруулан, тогтвортой ажиллах урамшууллын механизм бий болгох асуудлаар тодорхой шийдэлд хүрээгүй байна. Хэрвээ энэхүү зорилтыг амжилттай хэрэгжүүлвэл мэдээллийн технологийн чиглэлийн ажилтны ажлын байрны баталгаа сайжирч цаашид мэргэжилтэй боловсон хүчний тоог нэмэгдүүлэхэд томоохон түлхэц болно гэж үзэж байна.

Цахим засгийн үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн судалгаа, шинжилгээний ажлын санхүүжилтгүйн улмаас хангалттай түвшинд явагдахгүй байна.

Цахим засгийн хөгжлийн түвшинг нэмэгдүүлэхийн тулд иргэдийн цахим боловсролын түвшинг дээшлүүлэх шаардлага зайлшгүй байна. Өмнөх жилүүдэд интернет хэрэглэгчдийг насны бүлгээр авч үзэхэд ихэнх нь залуучууд байсан бол одоо ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бага насны хүүхдийн интернетийн хэрэглээ тогтвортой өсөж байгааг дэлхийн бакнаас гаргасан судалгаанаас харж болно. Мөн гэрийн ажилтай эмэгтэйчүүд, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандсан цахим болон явуулын сургалт зохион байгуулах ажил хангалтгүй үр дүнтэй байна. Иймд төв суурин газар хийгээд хөдөө орон нутгийн иргэд болон төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалтыг төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, их, дээд сургуулиудтай хамтран зохион байгуулах, уг сургалтыг зохион байгуулах чадвартай боловсон хүчний тоог нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна. Техник технологийн эрчимтэй хөгжлийг дагаад түүний эцийн хэрэглэгчид нь мэдлэг, чадвар дутмаг байвал хөгжлийг бүрэн нэвтрүүлж чадахгүй билээ.

### **Дөрөв. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр**

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт ХХМТ-ийн чиглэлээр хийгдэх нийт 17 зорилт ажлыг хийхээр тусгасан байна. Эдийн засаг, нийгэм, боловсрол, эрүүл мэнд г.м төрийн бүхий л салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн ажлыг тусгасан байдаг. Мөн энэ салбарын сургалтын стандарт, хөтөлбөр, сурах бичгийн агуулга, чанарыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад хүргэх, орчин үеийн мэдээлэл, технологийн ололтод тулгуурласан насан туршийн боловсролын

тогтолцоог эрчимтэй хөгжүүлнэ гэж тусган ажиллаж байгаа хэдий ч боловсролын хөтөлбөрт өөрчлөлт хангалттай ороогүй байсаар байна. Жишээ нь: 3.3.7-д заасны дагуу өндөр технологийн 2000 энтерпренёр мэргэжилтнийг бэлтгэх ажлын хүрээнд 2017 оны 9 сард Нийслэлийн залуучуудын хөгжлийн газар, MKIT Educational center сургалтын төвтэй хамтран өдөрлөг зохион байгуулсан.

**Тав. “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө**

Бодлогын баримт бичгүүд хэрэгжсэнээр тодорхой салбар, байгууллагуудад шат дараалалтай ажлууд хийгдэж байгаа ба зарим томоохон үр дүнгээс дурьдвал: Үндэсний дата төв байгуулагдсан; Цахим үйлчилгээг бий болгох тухай хууль эрх зүйн орчин сайжирсан; Бүх нийтийг компьютержүүлэх хөтөлбөрүүд хэрэгжиж, компьютерийн хүрэлцээ хангамж сайжирсан; Интернетийн үйлчилгээ сайжирч, хямд үнээр интернет хэрэглэх боломжтой болсон; Төрийн байгууллагуудын веб порталын үйл ажиллагаа сайжирсан; Аймаг, нийслэл, дүүргийн бүртгэлийн үйл ажиллагааг онлайн сүлжээнд холбосон; Аж ахуйн нэгжүүд татварын тайлангаа цахим хэлбэрээр өгдөг болсон; Нэг цэгийн үйлчилгээг бий болгосон; Иргэдийн санал, гомдлыг утсаар болон цахим хэлбэрээр авч шийдвэрлэдэг болсон (11-11 төв) Улаанбаатар хотод болон 21 аймгуудад ТҮЦ машинуудыг ажиллуулж эхэлсэн; Монгол Улсын иргэний цахим бүртгэлийн санг цахим хэлбэрт хөрвүүлэх, бүртгэлийн нэгдсэн санд нэгтгэх ажлууд хийгдсэн байна. 2 Wwww.e-zasag.mn төрийн үйлчилгээний цахим системийн веб порталыг нээн ажиллуулж эхэлсэн; 2016 онд “Төрийн мэдээлэл солилцооны системийн талаар баримтлах бодлогын чиглэл” батлагдсантай холбогдуулан “ХУР” мэдээллийн системийг хэрэгжүүлсэн ба үүний үргэлжлэл болох Дан системийн нээлтийг энэ онд хийсэн. Төрийн бүх байгууллагууд уг системд нэгдэж, мэдээллээ солилцох боломжийг бүрдүүлснээр иргэд төрийн ямар ч үйлчилгээг нэг доороос авах боломжийг бий болгосон. Төрийн мэдээлэл солилцооны системийг технологийн шийдлийн хувьд нээлттэй эхийн платформ дээр суурилан хөгжүүлэлтийг хийж эхэлсэн. Мэдээлэл солилцооны системийн “Enterprise Service Bus” архитектурт тулгуурлан хөгжүүлснээр аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах ба төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцоход хурдан шуурхай, хялбар болно.

## **ГУРАВ. ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ**

### **3.1 Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага**

Мэдээллийн технологийн салбарын хөгжил, түүний гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаар төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого, энэ салбарыг бусад салбаруудад хэрхэн үр ашигтай нэвтрүүлэх талаар хийгдсэн нарийвчилсан судалгаа, хөгжлийн чиг хандлагыг зөв тодорхойлох явдал манай улс орны хувьд нэн түрүүнд тавигдаж байгаа асуудлуудын нэг юм. Сүүлийн жилүүдэд мэдээллийн технологи (МТ)-ийн зах зээлийн төлөвийг тодорхойлох хамгийн гол хүчин зүйл Digital Transformation буюу Цахим хувьсгал юм. Цахим хувьсгал дэлхий дахинаа 2020 он хүртэл эрчимтэй үргэлжлэх нь нэгэнт тодорхой байна. Магадгүй 2020 он гэхэд нийт бизнесийн байгууллагын 70%, 2025 он гэхэд 90% нь цахим хувьсгалд нэгдэж, шинэ эринд хөл нийлүүлэн ажиллаж эхлэхийг экспертүүд мэдээлж байна. Товчхондоо Цахим хувьсгал гэдэг нь бизнесийн стратеги, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааг технологийн 4 гол чиг хандлагатай (Клауд, Ухаалаг утас, Нийгмийн сүлжээ системүүд, Их өгөгдөл) нягт уялдуулан хийхийг хэлнэ. Аливаа ААН, байгууллагууд дээрх 4 гол хүчин зүйлийг ашиглан өөрсдийн хэрэглэгч, үйлчлүүлэгчээ илүү мэдрэх, тэдэнд илүү ойр байх боломж бүрдэх юм. Олон улсад аливаа шинэ бизнесийн санал санаачилга, ажил хэргийг эхлэхдээ “Mobile First”, “Клауд First” гэсэн зарчмыг стратеги томъёололдоо онцгойлон баримталдаг болжээ. Энэ нь ухаалаг утас гэсэн нэгэн шинэ суваг руу нэгдсэн нэг төвөөс (Клауд буюу төвлөрсөн асар том мэдээллийн дэд бүтэц) бизнесийн үйл ажиллагааг удирдан хүргэх тухай хэлэлцэж буй хэрэг юм.

Манай орны хувьд дээрх 4 үндсэн технологийн чиглэл харилцан адилгүй хөгжлийн болон хэрэглээний түвшинд байна. Жишээ нь: байгууллагуудын тухайд Cloud технологийн бүтээгдэхүүн үйлчилгээнд маш бага хамрагдсан байдалтай байна. Нийт бизнесийн байгууллагын 5 хүрэхгүй хувь нь Клауд технологийн хамгийн энгийн бүтээгдэхүүн үйлчилгээг, тухайлбал Microsoft-ийн Office 365 зэргийг хэрэглэж эхлэх төдий байгаа ба бусад гол шийдэл үйлчилгээнд хамрагдаж эхлээгүй байна. Өнөөдөр Клауд технологийн үйлчилгээг бүрэн утгаар нь үзүүлэх дотоодын компаниуд алга гэж хэлж болно. Клауд үйлчилгээ үзүүлэгч Amazon, Google, Microsoft, Oracle, Alibaba зэрэг гадны томоохон компаниудын хувьд Монголын харьцангуй жижиг зах зээлийг зорин сонирхох нь ач холбогдол бага байгаатай холбоотой байж болох талтай. Эдгээрээс дутахгүй бас нэг гол шалтгаан нь хэрэглэгч байгууллагуудын зүгээс энэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний үр ашгийг төдийлөн мэдэрч эхлээгүй байгаатай холбоотой. Харин Клауд технологитой харьцуулбал манай оронд ухаалаг утасны хэрэглээ болон нийгмийн сүлжээ системд холбогдсон байдал илүү сайн байна. Энэ нь хэрэглээ талдаа

сайн хөгжиж буй ч дотоодын нийгмийн сүлжээний систем байхгүй, гадны томоохон системийн албан ёсны төлөөлөл мөн байхгүй байгаа нь бизнес үр шимийг нь бүрэн хүртэх боломжийг хязгаарлаж байна.

Их өгөгдлийн хувьд манай оронд тоон мэдээллийн бааз суурь эхлэлийн шатандаа байна. Банк санхүү, зарим нэг томоохон уул уурхайн компаниуд, төрийн байгууллагуудыг эс тооцвол ихэнх байгууллагууд дөнгөж санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн систем төдийхнөөр зөөлөн дэд бүтэц болох програм хангамжийг нэвтрүүлэн хэрэглэж байгаа нь тоон мэдээллийн бааз суурь тааруухан байхад нөлөөлж байна. Нөгөө талаас дээр дурдсан дотоодын нийгмийн сүлжээ байхгүй байгаа нь хувь хүмүүсийн нэгдсэн идэвхтэй мэдээллийн суурь сан үүсгэх боломжийг алга болгож буй гол хүчин зүйл юм. Өөрөөр хэлбэл, Монголчуудын бүхий л хувийн мэдээлэл хаа нэгтээ гадны систем дээр түүх болон үлдсээр байна. Энэхүү өгөгдлийг бизнест ашиглах боломж нь тухайн гадны системийг хөгжүүлэгчдийн зүгээс Монголд хэрхэн хандахаас бүх зүйл хамаарахаар байгаа нь тодорхой. Мөн юмсын интернет буюу IoT дөнгөж эхний шатандаа явж байгаа зэрэг нь мэдээллийн хангалттай их өгөгдөл бүрдэхэд дөнгөж эхлэл төдий гэж дүгнэхэд хүргэж байгаа юм. Гэхдээ энэ байдал тун удалгүй арилах ба 2020 он гэхэд мэдээллийн хангалттай суурь баазууд бүрдэж эхлэхээр байна. Иймээс, одооноос байгууллага бүр өөрсдийн бодлого, чиглэлдээ мэдээллийг боловсруулах, үр дүнтэй ашиглах, түгээх стратегийг шингээж байх нь чухал гэж экспертүүд үзэж байна.

Хөгжлийн хандлага ба ХХМТ-н бизнест гарч байгаа өөрчлөлтүүд 2015-2020 онд үүлэн тооцооллын үйлчилгээнүүд хурдацтай өсөх, B2B буюу Бизнесээс Бизнес рүү хандсан МХТ-ийн шинэ бизнес илүү хурдацтай хөгжих хандлагатай байна. Телекомын уламжлалт суурь бизнесээс “гадагш хөдлөх” хэрэгтэй боллоо. Ингэснээр бизнесээс бизнес хооронд, хүн ба бизнесийн хооронд, эдийн засаг, нийгмийн илүү өргөн хүрээнд мэдээллийн технологи, харилцаа холбооны технологийг ашиглан бизнес хийж, үйлчилгээ өгч, хөдөлмөрийг хөнгөвчилж, бүтээмжийг дээшлүүлэн, өгөөжийг нэмэгдүүлж, эдийн засгийн хөгжлийг хурдасган, иргэд-хэрэглэгчдийн амьдралын чанарыг дээшлүүлэх боломж нэмэгдэж байна. Цахим худалдаа, төлбөр, цахим санхүүгийн үйлчилгээ, цахим эрүүл мэнд, цахим сургалт, ухаалаг төрийн цахим үйлчилгээ г.м электрон бизнесийн өргөн цар хүрээтэй зах зээл үйлчилгээ эрхлэгчдийн өмнө нээлттэй байна. Энэхүү зах зээлийг эзэмших боломжийг өндөр хурдны, өргөн зурвасын (ӨХӨЗ) сүлжээний хүртээмж, хөдөлгөөнт холбооны 3G-ийн нэвтрэлт, ухаалаг утасны өргөн хэрэглээ, хэрэглэгчдийн цахим боловсрол, туршлага олгох болно.

Өнгөрсөн таван жилийн хугацаанд Монголын мэдээллийн технологийн (IT) бараа бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ асар хурдацтай өсч, залуу болон дасан зохицох боломжтой хүн ам МТ-ийн бүтээгдэхүүнийг хувийн болон мэргэжлийн хэрэгцээнд ашиглах болсон. Монголын мэдээллийн технологийн салбарын сүүлийн үеийн судалгаагаар, Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) нь интернетийн үйлчилгээ

хэрэглэгчдийн тоо 2010 онд 200,000-аар өсч, 2016 оны 12-р сард 2.6 саяд хүрч, интернетийн нэвтрэлтийг 86 хувьд хүргэсэн байна. Монголын Хэвлэлийн Хүрээлэнгээс Facebook-ыг шалгах, мэдээ унших нь монголчуудын хувьд шилдэг хоёр онлайн үйл ажиллагаа юм. Монголчууд 2009 онд хүн амын мобайл, ухаалаг гар утасны хэрэглээ 60 хувь байсан бол 2015 онд 102 хувь болж өссөн байна. Харилцаа холбоо, интернет технологийн аль аль нь хурдацтай хөгжиж байгаа бөгөөд шинэ технологи нэвтрүүлэлт нь гар утасны хэрэглээ өсөхөд нөлөөлж байна. Монгол Улс нь 2011 онд байгуулагдсан 30 орны засгийн газар хоорондын Онлайн эрх чөлөөний эвсэл (FOC) -ийн гишүүн бөгөөд энэ нь дэлхий даяар интернетийн эрх чөлөөг хөгжүүлэх зорилготой байгуулагдсан.

### **Монголын технологийн хөгжлийн үе шат**

Монгол улс 2010 он хүртэл хатуу дэд бүтцийг сайн хөгжүүлсэн байдаг. Өөрөөр хэлбэл улс даяар шилэн кабел татаж, үүрэн холбооны операторууд сүлжээний өргөжилт, 3G, 4G- системүүдийг нэвтрүүлэн, гар утасны хэрэглээ эрс нэмэгдэж, ер нь ХХМТ-ийн дэд бүтэц, техникийн дэд бүтэц талаасаа 2000-2010 оны хооронд нэлээд сайн бэхэжжээ. Үүнтэй зэрэгцээд 2010 оноос хойш зөөлөн дэд бүтэц буюу програм хангамжийн хэрэглээ нэлээд идэвхжиж эхэлсэн. Өнөө цагт цогц ERP системийг сонирхдог байгууллагын тоо харьцангуй өсөж, энэ чиглэлийн дотоодын бүтээгдэхүүнүүд тухайлбал Green ERP 7 жилдээ зах зээлд багагүй хэрэглэгчидтэй болж амжилттай хөгжиж байна. Улсын секторын 50 гаруй газар, агентлаг өөрсдийн дотоод системтэй, иргэд аж ахуйн нэгжүүдэд зориулсан онлайн хувилбаруудтай болсон байна. Хэдийгээр 2010 оноос хойш програм хангамжийн хэрэглээ нэмэгдсэн ч цогц ERP систем ашигладаг компани цөөхөн хэвээр л байна. Дэлхийн хөгжлийг харвал Цахим хувьсгал руу орохоосоо өмнө эдгээр програмуудаа сайн ашигладаг болох нь том урьтал нөхцөл болдог аж. Энэхүү зөв дарааллаар хөгжихийн тулд 2020 он хүртэл Монголд програм хангамжийн хэрэглээгээ нэмэх үе шат явагдах шаардлагатай байна. Зөөлөн дэд бүтцээ ашиглаад сурчихвал дараа нь Цахим хувьсгал руу эрчимтэй орж, өргөжих боломжтой.

### **3.2 Харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарын хүний нөөцийн байдал**

Дэлхийн нийтээр мэдээллийн эринд шилжих үйл явц эрчимжиж мэдээлэлжсэн нийгмийг цогцлон байгуулж нийгмийн баялаг, үнэт зүйлсийг бүтээх эх сурвалж нь мэдлэг, мэдээлэл гэдгийг хүлээн зөвшөөрч улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт техник, технологийг өргөнөөр нэвтрүүлэх болсон. Үйлдвэржсэн нийгмээс мэдээлэлжсэн нийгэмд шилжин орж байгаа энэ үйл явц дэлхийн эдийн засгийн өсөлтөд нэгэн шинэ боломж, орчинг бий болгосон. Энэ зах зээлд эрэлт хэрэгцээ огцом өссөнөөр нийлүүлэлтийн хурд нь гүйцэхгүй хомсдол үүсэн мэдээллийн технологид суурилсан ажил үйлчилгээг импортлох явдал нэмэгдсэн. Энэ салбарт ажиллахад тодорхой мэдлэг чадварын түвшинд хүрсэн байх ёстой. Үүнийг улс орныхоо онцлог, нөөц бололцоог

харгалзан үзэж төр засгийн зүгээс оновчтой бодлого хэрэгжүүлэх нь чухал. Зөвхөн эрдэмтэн доктор, компьютерийн инженер, програм зохиогчдыг бэлтгэх биш зах зээлд, аж ахуй нэгжүүдэд ямар чиглэлийн мэргэжилтэн шаардлагатай эсвэл дутмаг байгааг нарийн судалсны үндсэн дээр олон төрлийн чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэх шаардлагатай. Манай орны хувьд ХХМТ-ийн ололт, амжилтыг нэвтрүүлэн түүнийг хөгжлийн тулгуур, тэргүүлэх чиглэл болгон мэдээлэлжсэн нийгмийг байгуулахын тулд чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэх нь нэн тэргүүний асуудал юм. Боловсролын системийг сайжруулан болон дэд бүтцүүдийг хөгжүүлэх зэрэг асуудлыг засгийн газрын оролцоогүйгээр шийдвэрлэн, мэдээлэлжсэн нийгмийг цогцлоох боломжгүйтэй адил мэдээллийн технологийн хүний нөөцийг хөгжүүлэлгүй мэдээлэлжсэн нийгмийг бүтээх аргагүй. Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн ур чадвар, нийлүүлэлт дутмаг байгаа нь хүний нөөцийн хөгжлийн хамгийн том асуудал болоод байгаа юм.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас гаргасан 2016 оны судалгаагаар (2017, 2018 оны статистик мэдээлэл олдсонгүй) нийт бүртгэл бүхий 3056 програм хангамж үйлдвэрлэл, мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуй нэгж үйл ажиллагаа явууж байгаагаас нийт аж ахуй нэгжийн 95.1%-г ХХК эзэлж байна. Гадаадын хөрөнгө оруулалттай компанийг нэмэгдүүлэн тооцвол энэ дүн 97% болно.

### Хүснэгт 3.1 ХХМТ-ийн салбарын байгууллагын өмчийн хэлбэр

<b>ӨМЧЛӨЛИЙН ХЭЛБЭР</b>	<b>ТОО</b>	<b>ЭЗЛЭХ ХУВЬ</b>
<b>ХХК</b>	2906	95.1%
<b>ХХК /ГХО/</b>	57	1.9%
<b>ТӨААТҮГ</b>	1	0.0%
<b>ТБ,АГ,УТҮГ</b>	6	0.2%
<b>ХХК /АУДИТ/</b>	3	0.1%
<b>ОНӨААТҮГ</b>	2	0.1%
<b>НҮТББ</b>	61	2.0%
<b>ХК</b>	2	0.1%
<b>САН</b>	4	0.1%
<b>ГҮТББ</b>	10	0.3%
<b>ЗБН</b>	4	0.1%
	3056	

#### **Салбарын ажиллагсдын мэдээ**

Тус салбарын байгууллагуудыг нийт ажилчдын тоогоор ангилбал дараах байдалтай байна. Эдгээр байгууллагууд нь НДШ төлдөг буюу НД-ын санд бүртгэлтэй байгууллагууд юм. Бусад 2280 байгууллага тус санд бүртгэлгүй буюу үүсгэн байгуулагдсан ч албан ёсоор ажиллагсдын тоо тодорхой бус байгаа юм.



Хүснэгт 3. 2 ХХМТ-ийн салбарын бүртгэлтэй ААН-д ажиллагчдын тоо

№	АЖИЛЧДЫН ТОО	БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙ НЭГЖИЙН ТОО
1	1-10 ажилтантай	714
2	11-50 хүртлэх ажилтантай	76
3	50-100 хүртлэх ажилтантай	11
4	101 ба түүнэс дээш ажилтантай	7
5	0 ажилтантай	315

Үйл ажиллагаа явуулж буй хугацааны хувьд авч үзвэл нийт байгууллагын 37% нь 6 жилээс дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй байгууллага харьцангуй цөөн байдаг байна.

Хүснэгт 3. 3 Програм хангамж үйлдвэрлэл, мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж буй хугацаа

Үйл ажиллагаа явуулж буй хугацаа	Тоо	Эзлэх хувь
1 жил	264	8.8%
2 жил	381	12.7%
3 жил	427	14.3%
4 жил	464	15.5%
5 жил	349	11.7%
6 жил	1106	37.0%

Програм хангамж үйлдвэрлэл, мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжийг төлж буй татварын хэмжээнд үндэслэн жагсаавал ашигт малтмал болон интернэт, харилцаа холбооны байгууллага өндөр байдаг байна. Энэ нь тухайн салбарын үйл ажиллагааны хэмжээнээс хамаарч байна.

Хүснэгт 3. 4 Програм хангамж, мэдээллийн технологийн чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ын эзлэх хувь


	ИДЭВХИТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ	ЭЗЛЭХ ХУВЬ /3069/
2012	750	24.4%
2013	917	29.9%
2014	977	31.8%
2015	944	30.8%

**2016****883****28.8%**

Хэдийгээр маш олон компани, аж ахуй нэгж энэхүү салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ч 2016 оны байдлаар нийт аж ахуй нэгжийн дөнгөж 28.8% нь идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. Өөрөөр хэлбэл програм хангамж үйлдвэрлэл, мэдээллийн технологийн үйлчилгээний салбарын байгууллагын тоо хэмжээ сүүлийн жилүүдэд буурсныг харж болохоор байна.

Тус салбарын 3069 байгууллагын сүүлийн 5 жилд төлсөн татварын хэмжээ: 2012 оноос хойш сүүлийн 5 жилд улсад төлсөн орлогын албан татвар жил дарааллан буурчээ. 2012-2016 онд 115 сая төгрөгнөөс 32,6 сая төгрөг болтлоо буурсан нь сүүлийн 5 жилд хамгийн доод үзүүлэлт болжээ.

График 1. 1 Тус салбарын 3069 байгууллагын сүүлийн 5 жилд төлсөн татварын хэмжээ



Сүүлийн 5 жил 1636 байгууллага /1035 нь Нийгмийн даатгалын санд бүртгэлтэй/ татвар төлж, 326,5 сая төгрөг улсын төсөв төвлөрүүлсэн бол үлдсэн 1434 байгууллага тус хугацаанд ямар татвар төлөөгүй байна. Тус салбарт нийт 6675 хүн ажиллаж байгаа бөгөөд эдгээрээс 827 нь тус салбарын инженер техникийн ажилтан эзэлж байгаа нь нийт ажиллагсдын 12.3% юм. Нийгмийн даатгалын санд бүртгэлтэй 1035 аж ахуй нэгж, бүртгэлгүй 2034 аж ахуй нэгж 2016 оны байдлаар улсын бүргэлтийн байгууллагад бүртгэлтэй байна.

Хүснэгт 3. 5 Мэдээлэл, холбооны салбарын хуулийн этгээд, 2011, 2016 он, эдийн засгийн үйл ажиллагааны дэд салбараар

Дэд салбар	2011		2016	
	Бүгд	%	Бүгд	%
Бүгд	1584	100	3185	100
Эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа	505	31.9	1196	37.6
Кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая үйлдвэрлэх үйл ажиллагаа	81	5.1	287	9.0
Өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагаа	138	8.7	209	6.6
Цахилгаан холбоо	197	12.4	283	8.9
Компьютерийн програмчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа	614	38.8	1006	31.6
Мэдээллээр үйлчлэх үйл ажиллагаа	49	3.1	204	6.4

Мэдээлэл, холбооны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд 2011 оны тооллогоос 1.6 мянган нэгж буюу 2.0 дахин нэмэгдэж, 3.2 мянга болжээ. Үүнд, компьютер програмчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагааны дэд салбарын нэгж 392 буюу 63.8 хувиар, эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагааны дэд салбарын нэгжийн тоо 691 буюу 2.4 дахин, кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая үйлдвэрлэх үйл ажиллагааны дэд салбарын нэгж 206 буюу 3.5 дахин нэмэгдсэн нь нөлөөллөө.

Мэдээлэл, холбооны салбарын хуулийн этгээдийг 2011 оны тооллогын дүнтэй харьцуулахад, эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагааны дэд салбарын мэдээлэл, холбооны салбарын нийт дүнд эзлэх хувь 5.7 пунктээр, кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая үйлдвэрлэх үйл ажиллагааны дэд салбарын хувь 3.9 пунктээр, мэдээллээр үйлчлэх үйл ажиллагааны дэд салбарын эзлэх хувь 3.3 пунктээр нэмэгджээ.

Хүснэгт 3. 6 ХХМТ-ийн салбарын хүний нөөцийн судалгаа /2013-2018.06.30/

Төрөл	2013	2014	2015	2016	2017	2018.06.30
Мэдээлэл холбооны сүлжээ	1481	1132	1276	1352	1371	1245
Суурин телефон холбоо	1217	1254	1046	1004	841	863
Үүрэн холбоо	1536	2154	2545	2449	2474	2529
Улс хоорондын яриа	47	50	150			0
Интернетийн үйлчилгээ	558	711	458	490	437	436
Ай ПиТи Ви			498	421	425	438
Кабелийн телевиз	647	457	625	405	567	578

Эфирийн телевизийн өргөн нэвтрүүлэг	1858	1422	2235	2197	1215	1325
Радио өргөн нэвтрүүлэг	132	191	171	213	178	129
Кабелийн суваг	628	802	895	560	646	872
Шуудан	1109	1148	1165	1176	1239	1291
Контентийн үйлчилгээ		65	63	67	99	103
Сансрын холбоо	146	154	30	28	27	48
Кабель шугам, угсралт	918	897	960	960	1000	
Төрийн байгууллага дахь ХХМТ-ийн салбарын боловсон хүчний тоо	-	227	235	246	248	256
<b>Нийт</b>	<b>10277</b>	<b>10437</b>	<b>12117</b>	<b>11322</b>	<b>10519</b>	<b>10 113</b>
	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018.06.30
Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	686	705	750	636	721	777
Радио давтамжийн тусгай зөвшөөрөл	356	376	339	271	221	198
Радио давтамжийн эрхийн бичиг	626	1061	688	610	534	606

эх сурвалж: ХХЗХ

**Аймгийн Засаг Даргын Тамгын Газар дахь харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр ажилладаг боловсон хүчний судалгаа**

№	Аймаг	ХХМТ чиглэлийн боловсон хүчний тоо	Дэлгэрэнгүй мэдээлэл
1	Архангай	3	IT инженер-1 Шуудан харилцаа холбооны ажилтан-2
2	Баян-Өлгий	1	Сүлжээний инженер, цахим засаглал, мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн
3	Баянхонгор	4	
4	Булган	5	Сүлжээний инженер-1 Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах алба-4

5	Говь-Алтай	3	IT инженер-1 Хэвлэл мэдээллийн ажилтан-2
6	Говьсүмбэр	1	IT инженер, мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн
7	Дархан-Уул	4	IT инженер, хэвлэл мэдээллийн ажилтан-3
8	Дорноговь	1	Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн
9	Дорнод	4	IT инженер, хэвлэл мэдээллийн ажилтан-3
10	Дундговь	1	IT инженер
11	Завхан	3	IT инженер-1 Хэвлэл мэдээллийн ажилтан-2
12	Орхон	4	Хэвлэл мэдээллийн алба -4
13	Өвөрхангай	4	IT инженер-1 Хэвлэл мэдээллийн ажилтан-2 Зураглаач-1
14	Өмнөговь	4	IT инженер-1 Хэвлэл мэдээллийн ажилтан-2, Менежер-1
15	Сүхбаатар	3	Шуудан харилцаа холбоо хариуцсан ажилтан-1 Мэдээлэл, технологи сүлжээ хариуцсан ажилтан-1 Хэвлэл мэдээллийн ажилтан-1
16	Сэлэнгэ	2	IT инженер-1 Хэвлэл мэдээллийн ажилтан-1
17	Төв	2	IT инженер-2
18	Увс	1	IT инженер-1
19	Ховд	3	Хэвлэл мэдээллийн ажилтан-2 IT инженер-1
20	Хөвсгөл	3	IT инженер-1 Хэвлэл мэдээллийн ажилтан-2
21	Хэнтий	1	Сүлжээний инженер-1
	<b>Нийт</b>	<b>57</b>	

21 аймгийн ЗДТГ-т харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр ажиллаж буй нийт 57 ажилтны 26 нь хэвлэл мэдээллийн ажилтан, 19 нь IT инженер, сүлжээний инженер, бусад нь шуудан харилцаа холбооны ажилтан, менежерүүд ажиллаж байна.

**Монгол улсын яамдад ажиллаж буй ХХМТ-ийн салбарын ажиллах хүчний судалгаа**

Д/д	Яамдын нэрс	Харьяалах газар, хэлтэс	Мэдээллийн технологийн ажилтны тоо
1	Сангийн яам	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	Мэдээлэл технологийн хэлтэс - 4 хүнтэй
2	Хууль зүй, дотоод хэргийн яам	Төрийн захиргааны удирдлагын газар	Мэдээллийн технологи, сүлжээ хариуцсан мэргэжилтэн - 2 хүнтэй
3	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	Мэдээллийн сүлжээ, цахим хуудас, компьютер, тоног төхөөрөмжийн ашиглалт хариуцсан мэргэжилтэн - 1 хүн, салбарын мэдээллийн технологийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн - 1 хүнтэй
4	Гадаад харилцааны яам	Төрийн захиргааны удирдлагын газар	Мэдээллийн технологи, сүлжээ хариуцсан мэргэжилтэн - 2 хүнтэй
5	Батлан хамгаалах яам	Төрийн захиргааны удирдлагын газар	Мэдээллийн технологи, сүлжээ хариуцсан мэргэжилтэн - 2 хүнтэй
6	Барилга хот байгуулалтын яам	Төрийн захиргааны удирдлагын газар	Мэдээллийн сүлжээ, техник хангамж хариуцсан мэргэжилтэн - 2 хүнтэй
7	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Төрийн захиргааны удирдлагын газар	Мэдээллийн технологи, сүлжээ хариуцсан мэргэжилтэн - 1 хүнтэй
8	Эрүүл мэндийн яам	Бодлого төлөвлөлтийн газар	Эрүүл мэндийн цахим мэдээллийн хэлтэс - 3 хүнтэй
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Төрийн захиргааны удирдлагын газар	Мэдээллийн технологи, сүлжээ хариуцсан мэргэжилтэн - 2 хүнтэй
10	Эрчим хүчний яам	Төрийн захиргааны удирдлагын газар	Мэдээллийн технологи, сүлжээ хариуцсан мэргэжилтэн - 1 хүнтэй
11	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	Төрийн захиргааны удирдлагын газар	Мэдээллийн технологи, сүлжээ хариуцсан мэргэжилтэн - 2 хүнтэй
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	Мэдээлэл технологи, бүртгэлийн мэргэжилтэн - 1 хүнтэй
13	Зам, тээврийн хөгжлийн яам	Төрийн захиргааны удирдлагын газар	Мэдээллийн технологи, сүлжээ хариуцсан мэргэжилтэн - 2 хүнтэй
<b>Нийт</b>			<b>25 хүн</b>

Монгол Улсын 13 яаманд ажиллаж байгаа ХХМТ-ийн салбарын орон тооны хувьд 1-2 хүртэлх ажлын байрыг эзлэж байгаа бөгөөд мэдээллийн технологи, сүлжээ

хариуцсан ажилтангууд давамгайлж байна. Мэдээллийн технологи, сүлжээ хариуцсан ажилтнуудын цалингийн албан тушаалын зэрэглэл нь ТЗ-7 бөгөөд 680,000 төгрөгөөс эхлээд 792,572 төгрөг хүртэлх цалинтай байна.

**Фокус бүлгийн ярилцлаганд оролцогч Б.М:** Мэдээлэл технологийн паркийн дундаж цалин нь 600,000-700,000 төгрөгний хооронд байдаг. Манай цалинг голоод ажилд орох хүсэлтэй хүмүүсийн тоо бага байдаг.

**Фокус бүлгийн ярилцлаганд оролцогч Д.Г:** Монголын цахилгаан холбооны дундаж цалин 700,000-850,000 орчим нэмэлт урамшуулал бас байдаг. Ажилчдын ажлын гүйцэтгэлийг дүгнэх дотоод журам гэж байдаг. Тэр журмын дагуу ажилчдынхаа ажлын гүйцэтгэлийг үнэлдэг.

### **ХХМТ-ийн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэдэг сургалтын тогтолцоо, чиг хандлагын талаарх судалгаа**

#### **Дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажиллагчид**

Нийт ажиллагчдын тоо. Дээд боловсролын сургалтын байгууллагуудад нийт 12,705 хүн ажиллаж байгаагийн 62.2 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд өнгөрсөн хичээлийн жилийн мөн үетэй харьцуулахад ажиллагчдын тоо 35 хүнээр (-0.3%) цөөрсөнөөс төрийн өмчийн сургуульд 130-аар буурсан бол, төрийн бус өмчийн сургуульд 95 хүнээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. 7 Дээд боловсролын салбарт ажиллагчдын тоо (өмчийн хэлбэр, байршлаар)

Хичээлийн жил	Ажиллагчдын тоо	Өмчийн хэлбэр		Байршил	
		Төрийн өмч	Хувийн өмч <sup>11</sup>	Хот	Хөдөө
<b>2013-2014</b>	13,212	8,534	4,678	11,436	<b>1,776</b>
<b>2014-2015</b>	13,360	8,547	4,813	11,614	<b>1,746</b>
<b>2015-2016</b>	13,057	8,456	4,601	11,351	<b>1,706</b>
<b>2016-2017</b>	12,740	8,281	4,459	11,156	<b>1,584</b>
<b>2017-2018</b>	<b>12,705</b>	<b>8,151</b>	<b>4,554</b>	<b>11,138</b>	<b>1,567</b>

Үндсэн багшийн тоо: Нийт ажиллагчдын 6,724 нь (52.9%) үндсэн багш юм. Өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад үндсэн багшийн тоо 193-аар, түүний дотор төрийн өмчийн сургуульд 213, гадаадын салбар сургуульд 3-аар тус тус буурсан бол, хувийн өмчийн сургуульд 23-аар нэмэгдсэн байна. Нийт үндсэн багшийн 62.9 хувь нь төрийн өмчийн, 36.8 хувь нь хувийн өмчийн, 0.2 хувь нь гадаадын салбар сургуульд багшилж байгаа нь өмнөх оны хичээлийн жилээс төрийн өмчийн сургуульд ажиллаж байгаа багшийн тоо 1.3 пунктээр, гадаадын салбар сургуульд ажиллаж байгаа

багшийн тоо 0.1 пунктээр тус тус буурсан бол хувийн өмчийн сургуульд ажиллаж байгаа багшийн тоо 1.3 пунктээр өссөн байна. Суралцагчдын тоо багассан нь үндсэн багшийн тоо буурахад нөлөөлсөн байх талтай.

Хүснэгт 3. 8 Их, дээд сургуулийн үндсэн багш

	Нийт	Төрийн	Хувийн	Гадаадын салбар
2013-2014	7,385	4,675	2,664	46
2014-2015	7,528	4,779	2,711	38
2015-2016	7,121	4,578	2,517	26
2016-2017	6,917	4,444	2,454	19
2017-2018	6,724	4,231	2,477	16

Нийт үндсэн багшийн 6.9 хувь нь дадлагажигч багш, 41.7 хувь нь багш, 29.6 хувь нь ахлах багш, 12.2 хувь нь дэд профессор, 9.6 хувь нь профессор багш байна. Үүнийг өмнөх онтой харьцуулахад дадлагажигч багшийн эзлэх хувь 0.4, профессор багшийн эзлэх хувь 0.1 пунктээр тус тус багасч, багшийн эзлэх хувь 0.1, ахлах багш 0.1, дэд профессор багшийн эзлэх хувь 0.2 пунктээр тус тус өсчээ.

Хүснэгт 3. 9 ХХМТ-ийн чиглэлээр боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулийн багшлах хүчний судалгаа

№	Сургууль		Нийт багшийн тоо	Доктор	Докторант	Магистр	Магистрант	Бакалавр
1	Батлан хамгаалахын их сургууль		16	2		14		
2	Дорнод их сургууль		15	1	6	4	4	
3	МУБИС-ийн мэдээлэл зүйн тэнхим		18	2		14		2
4	МУИС-ийн хэрэглээний шинжлэх	Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхим	53	20		29		4



	ухаан, Инженерчлэ лийн сургууль	Электроник, холбооны инженерчлэлийн сургууль	38	15		17		6
5	Соёл урлагийн их сургууль. Радио, телевиз, медиа урлагын сургууль			1		6		
6	Ховд Их сургууль		6	1		3	2	
6	Улаанбаатар их сургууль		15	3		12		
7	ХААИС Инженер, технологийн сургуулийн математик, физик, мэдээллийн тэнхим		10	2		8		
9	Хууль сахиулахын их сургууль		2			2		
10	ШУТИС Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль		21	7		14		
11	ШУТИС Мэдээлэл, холбооны технологийн сургууль		50	32	16			
12	ШУТИС Үйлдвэрлэлийн технологийн сургууль		25					
13	ШУТИС Эрчим хүчний сургууль		39	15		24		
14	МУИС Завхан		5			3		2
15	ШУТИС Дархан-Уул		6		6			
16	ШУТИС Орхон		8					
17	Мандах их сургууль		16	10	3	3		
18	Монголын үндэсний их сургууль							
19	Олон улсын Улаанбаатарын их сургууль		6	1	4	1		
20	Отгонтэнгэр их сургууль		3			3		
21	Санхүү эдийн засгийн их сургууль		10	1		7	2	
22	Сити их сургууль		3	1		2		

23	Улаанбаатар эрдэм их сургууль	2		1	1		
24	Хүмүүнлэгийн ухааны их сургууль. Мэдээлэл харилцаа, менежментийн сургууль	7			7		
25	Этүгэн их сургууль	27					
26	Соёл эрдэм дээд сургууль	3			3		
27	Хүрээ мэдээлэл, технологийн дээд сургууль	64					
28	Шинэ монгол технологийн дээд сургууль	3	1		1		
29	Эм ай Ю дээд сургууль	6	3		3		
<b>Нийт</b>		<b>495</b>	<b>121</b>	<b>36</b>	<b>189</b>	<b>8</b>	<b>18</b>

**Монгол улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл зүйн хичээл  
орж буй багш нарын тоо**

Д/д	Аймаг, нийслэл	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019
1	Архангай	20	23	20	20	20
2	Баян-Өлгий	23	25	26	27	25
3	Баянхонгор	18	18	17	16	14
4	Булган	11	9	11	11	10
5	Говь-Алтай	7	8	6	7	5
6	Дорноговь	17	15	17	17	17
7	Дорнод	21	19	17	18	17
8	Дундговь	10	9	10	11	11
9	Завхан	12	13	13	13	14
10	Өвөрхангай	26	26	24	23	23
11	Өмнөговь	11	12	11	8	11
12	Сүхбаатар	11	11	9	8	10
13	Сэлэнгэ	18	18	17	17	18
14	Төв	16	17	15	18	16
15	Увс	13	13	11	11	11
16	Ховд	13	14	14	14	13
17	Хөвсгөл	35	35	34	34	34
18	Хэнтий	11	14	13	12	13
19	Дархан-Уул	39	42	34	30	33
20	Улаанбаатар	251	265	267	265	259

21	Орхон	32	29	28	25	26
22	Говьсүмбэр	3	4	4	4	4
23	Бусад	4			4	4
Нийт		<b>622</b>	<b>639</b>	<b>618</b>	<b>613</b>	<b>608</b>

Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, Нийслэлийн боловсролын газрын захиалгаар Улаанбаатар хотын 9 дүүргийн 15 ЕБС-ийн багш, сурагчдын дунд сургуулийн орчин, материаллаг нөхцөл, сургалтын үйлчилгээнд тулгамдаж буй асуудлыг тодруулах зорилготой судалгааг Стратеги Академи ТББ 2016 онд хийсэн. Судалгаанд нийт 441 багш, 448 сурагч хамрагдсан. Уг судалгааны дүнгээс авч үзвэл:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн чадавх, нөөц бололцоо муу байгаагаас шалтгаалан боловсролын салбарт, тэр дундаа ерөнхий боловсролын сургуулийн хичээлд ашиглагдах лабораторийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бүрэн гүйцэд хангамж чаддаггүй нь дээрх судалгааны дүнгээр батлагдаж байна. Харин судалгаанд оролцсон сурагчид тоног төхөөрөмж зайлшгүй шаардлагатай дараах хичээлүүдийн техник хэрэгсэл сурагчдад хэр хүрэлцээтэй байгааг тодруулж асуухад:

№	Хичээл	Хүрэлцдэг	Хүрэлцдэггүй	Хариулаагүй
1	Хими	27.2	52.5	20.3
2	Физик	26.1	56.2	17.6
3	<b>Мэдээлэл зүй</b>	<b>67.6</b>	<b>23.9</b>	<b>8.5</b>
4	Хөдөлмөр	45.3	44.2	10.5

Хүснэгтээс харахад судалгаанд оролцсон сурагчдын **67,6%** нь мэдээлэл зүйн хичээл дээр шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь бусад хичээлийг бодвол харьцангуй хүрэлцээ сайтай, 23,9% нь хүрэлцдэггүй байна.

Сурагчдаар үнэлүүлсэн дээрх хичээл дээр ашиглагддаг тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хүрэлцээ нь судалгаанд хамрагдсан сургуулиудын нэр хүндээс шууд хамаарч дүн нь өөр гарч байв. Тухайлбал, **1, 23** гэсэн сургуулийн сурагчид 50-аас дээш хувь нь хүрэлцээтэй гэж үзсэн байхад Багахангай дүүргийн **Хангай цогцолбор**, Сонгинохайрхан дүүргийн **62-р** сургуулийн сурагчдын 50-аас дээш хувь хүрэлцдэггүй гэж хариулж байсан.

**Фокус бүлгийн ярилцлаганд оролцогч Д.М:** Би бол харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарт олон жил ажилласан. Сүүлийн 2-3 жил энэ чиглэлээр багшаар ажиллаж байна л даа. Ингээд ажиглаад байхад бодлогын түвшинд ямар арга хэмжээ авч байна гэдэг зүйл дээр ирдэг. Дунд сургуульд програм хичээл дээр юу заах вэ, ямар

төвшинд бэлтгэгдээд төгсөх юм, их дээд сургуульд ямар төвшинд заагаад төгсөх юм, ажлын байрууд ямар шаардлага тавих юм гэдэг нь тодорхой байх хэрэгтэй. Би компьютерийн хэрэглээ гэдэг хичээлийг ордог. 10 жилээс орж ирж байгаа хүүхдүүдийн тал хувь нь компьютер гэж юу вэ гэдэгээ мэддэг, тодорхой хэмжээнд хэрэглээний программ дээр анхан шатны ойлголттой орж ирдэг. Тал хувь нь болохоор хулганаа ч барьж чадахгүй, хэрэглээний програмын талаар мэдлэггүй хүүхдүүд орж ирж байгаа юм. Аль алинд нь мэдээлэл зүй гэдэг хичээл орсон байдаг. Та нар мэдээлэл зүйн хичээл дээр юу үзсэн юм бэ гэхээр тал нь болохоор энэ дэлгэц, энэ хулгана, энэ процессор гэдгийг заагаад өнгөрдөг. Сургуульд нэг ийм танхим бол байдаг. Гэхдээ компьютер дээр сууж үзээгүй гэдэг. Програмистийн чиглэлээр манайд элсэж байгаа хүүхдүүд өөрийгөө би бол компьютертэй сайн учраас програмист болно гэж орж ирдэг. Харамсалтай нь хичээлдээ сайн биш, тоглоомондоо гаршчихсан байдаг. Бараг донтолтын хэмжээнд оччихсон. Компьютерийн ангид орж ирж байгаа хүүхдүүдийн тал хувь нь донтолттой байна. Компьютерийн хичээл дээр хүүхдүүд фэйсбүүк, тоглоом тоглож байдаг. Хичээл орохын тулд сүлжээг хаах боломж байхгүй. Хэрэглээний програмыг заах гэхээр ерөөсөө сонирхдоггүй, утсан дээрээ тоглоомоо тоглодог.

Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын тоо: 2017-2018 оны хичээлийн жилийн эхэнд их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо 155,248 болж, өмнөх хичээлийн жилээс 1,890-ээр буюу 1.2 хувиар буурсан байна. Суралцагчдын тоо төрийн өмчийн сургуульд 2,325-аар буюу 2.6 хувиар, төрийн бус өмчийн сургуульд 2,201-ээр буюу 3.3 хувиар, гадаадын салбар сургуульд 52-оор буюу 16.4 хувиар тус тус буурчээ. Нийт суралцагчдын 89,473 буюу 57.6 хувь нь төрийн өмчийн, 65,628 буюу 42.3 хувь нь төрийн бус өмчийн, 147 буюу 0.1 хувь нь гадаадын салбар сургуульд сурч байна.

#### Хүснэгт 3.10 Суралцагчдын тоо (сургуулийн өмчийн хэлбэрээр)

	Суралцагчид (сургуулийн өмчийн хэлбэрээр)			
	Бүгд	төрийн	төрийн бус	гадаадын салбар сургууль
2013-2014	174,045	101,855	71,689	531
2014-2015	178,295	103,650	74,233	412
2015-2016	162,626	95,033	67,276	317
2016-2017	157,138	91,798	65,075	265
2017-2018	155,248	89,473	65,628	147

Нийт суралцагчдын 88.0 хувь нь их сургуульд, 11.6 хувь нь дээд сургуульд, 0.3 хувь нь коллежид, 0.1 хувь нь гадаадын салбар сургуульд суралцаж байна. Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад их сургуульд суралцагчдын эзлэх хувь 3.5 пунктээр өссөн бол, дээд сургуульд суралцагчдын эзлэх хувь 3.5 пунктээр, гадаадын салбар сургуулиудад суралцагчдын тоо 0.1 пунктээр тус тус буурсан бол коллежид

суралцагчдын эзлэх хувь хэвээрээ байна. Энэ нь их сургууль, дээд сургуулийн тооны өөрчлөлт, тухайлбал нилээд хэдэн дээд сургууль их сургуулийн ангилалд шилжсэнтэй холбоотой.

### Хүснэгт 3.11 Суралцагчдын тоо (сургуулийн ангиллаар)

	Суралцагчид (сургуулийн ангиллаар)				Гадаадын салбар сургууль
	Бүгд	Их сургууль	Дээд сургууль	Коллеж	
2013-2014	174,075	125,902	44,445	3,198	531
2014-2015	178,295	128,661	48,515	707	412
2015-2016	162,626	122,870	38,869	570	317
2016-2017	157,138	133,187	23,293	393	265
2017-2018	155,248	136,673	17,982	446	147

Тооны хувьд их сургуульд суралцагчид 3,486-аар, коллежид суралцагчид 53-аар тус тус өссөн бол, дээд сургуульд суралцагчид 5,311-аар, гадаадын салбар сургуульд суралцагчид 52-аар тус тус буурсан байна. Их сургуулиудын хувьд суралцагчдын тоо төрийн өмчийн их сургуульд 1,937-оор буурч, төрийн бус өмчийн их сургуульд 5,423-аар нэмэгдсэн бол дээд сургуульд суралцагчдын тоо төрийн өмчийн сургуульд 175-аар, төрийн бус өмчийн сургуульд 5,136-аар тус тус буурчээ.

### Суралцагчдын мэргэжлийн чиглэл

2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн бакалавр, магистрантур, докторантурт шинээр элсэгчдийн мэргэжлийн чиглэл, индексийг тодорхойлохдоо Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78 болон А/370 дугаар тушаалуудаар батлагдсан мэргэжлийн /хөтөлбөр/чиглэл, индексийг, 2014-2015 оны хичээлийн жилээс өмнө элсэн суралцаж буй суралцагчдын хувьд тэдгээрийг төгстөл нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн тогтоох тухай” 2010 оны 235 дугаар тушаалын дагуу тухайн сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд заасан мэргэжлийн /хөтөлбөр/ чиглэл, индексийг мөрдөхөөр болсон.

Шинэчлэн батлагдсан мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/, индекст хуучныг дүйцүүлэн багцалж авч үзвэл: нийт суралцагчдын 13.2 хувь нь боловсрол; 8.2 хувь нь урлаг ба хүмүүнлэг; 5.8 хувь нь нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй; 26.0 хувь нь бизнес, удирдлага, эрх зүй; 3.9 хувь нь байгалийн шинжлэх ухаан, математик, статистик; 2.3 хувь нь мэдээлэл, харилцаа холбооны технологи; 16.5 хувь нь инженерчилэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт; 2.2 хувь нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй; 13.3 хувь нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал; 3.6 хувь нь үйлчилгээ; 4.7 хувь нь бусад чиглэл (дээрх салбаруудад одоогоор хамааруулах

боломжгүй)-ээр тус тус суралцаж байна.

Эдгээр үзүүлэлт нь өмнөх оны түвшингээс урлаг, хүмүүнлэгийн эзлэх хувь 0.7, нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүйн эзлэх хувь 0.6, байгалийн шинжлэх ухаан, математик, статистикийн эзлэх хувь 0.3, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын эзлэх хувь 1.5 пунктээр тус тус өссөн бол боловсролын чиглэлийн эзлэх хувь 0.8, бизнес, удирдлага, эрх зүй 0.7, мэдээлэл, харилцаа холбооны технологи 0.4, инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт 1.1, хөдөө аж ахуй, ой, засагны аж ахуй, мал эмнэл зүй 0.4, үйлчилгээ 0.4 пунктээр тус тус буурсан байна.

Боловсролын олон улсын шинэчилсэн стандарт ангиллаар боловсролын салбарын мэргэжлийн чиглэлийг хуучин 8 бүлэгт хуваан ангилж байсныг илүү нарийвчлан 10 бүлэгтэй болгосон. Тухайлбал хуучнаар Нийгмийн шинжлэх ухааны бүлэгт орж байсан “Бизнес, удирдлага, эрх зүй”-г салгаж тусгай бүлэг болгосны дээр мөн Байгалийн шинжлэх ухааны бүлэгт байсан “Компьютерийн ухаан”-ыг Техник, технологийн бүлэгт байсан “Мэдээлэл, холбооны технологи ба систем”-тэй нийлүүлэн “Мэдээлэл, харилцаа холбооны технологи” гэсэн шинэ бүлэг нэмж гаргасан юм.

Хүснэгт 3. 12 Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын мэргэжлийн чиглэлийн эзлэх хувь (сүүлийн 5 жилээр) /тоогоор/

Мэргэжлийн чиглэл(хөтөлбөр)-ийн нэр	Нийт суралцагчдад тухайн мэргэжлийн чиглэлийн эзлэх хувь (%)				
	2013	2014	2015	2016	2017
01.Боловсрол	12.6	12.7	13.6	14.0	13.2
02.Урлаг, хүмүүнлэг	7.1	7.1	7.1	7.5	8.2
03. Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	7.5	7.0	6.3	5.2	5.8
04. Бизнес, удирдлага, эрх зүй	27.0	26.1	26.7	26.7	26.0
05. Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик	3.8	4.6	4.1	3.6	3.9
06. Мэдээлэл, харилцаа холбооны технологи	2.8	2.8	2.7	2.7	2.3
07. Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт	19.5	18.6	19.0	17.3	16.5
08. Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй	3.3	2.9	2.7	2.6	2.2

09. Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	11.0	11.6	11.8	11.8	13.3
10. Үйлчилгээ	5.1	4.0	4.0	4.0	3.6
11. Бусад	0.3	2.6	1.9	4.6	4.7
Нийт дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0

2017-2018 оны хичээлийн жилийн суралцагчдын мэргэжлийн чиглэлийг боловсролын зэргээр авч үзвэл: бакалаврын зэргээр суралцагчдын хувьд нийт суралцагчдын мэргэжлийн чиглэлийн хандлагатай ойролцоо байгаа бол магистрантурт суралцагчдын (35.3) хувийг бизнес, удирдлага, эрх зүйн мэргэжлээр суралцагчид эзэлж байгаа нь өмнөх оноос 3.3 пунктээр буурсан байна.

Докторантурт суралцагчдын 12.2 хувийг урлаг, хүмүүнлэг; 9.8 хувийг нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй; 21.0 хувийг бизнес, удирдлага, эрх зүйн мэргэжлээр суралцагчид бүрдүүлж байгаа нь өмнөх оноос урлаг, хүмүүнлэгийн салбар 2.6, нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй 0.9 пунктээр тус тус өссөн бол бизнес, удирдлага, эрх зүйн мэргэжлээр суралцагчид 1.1 пунктээр буурсан байна.

БСШУСЯ-аас 2018 оны байдлаар гадаадын их, дээд сургуулиудад харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр АНУ-д 37, Англид 3, Австралид 1, Канадад 2, Хятадад 8, Унгарт 7, ОХУ-д 17 нийт 75 хүн суралцаж байна. Энэ тоо нь зөвхөн БСШУСЯ-ны шугамаар суралцаж байгаа иргэдийн тоо юм. Бусад төрийн байгууллага, аж ахуй нэгжийн дэмжлэгтэйгээр болон хувиараа гадагшаа явж суралцаж байгаа иргэн бүрийг бүртгэдэг нэгдсэн систем байхгүй. Энэ төрлийн нэгдсэн мэдээлэл БСШУСЯ болон ГХЯ-д байхгүй гэсэн хариу өгсөн.


Мэдээлэл, холбооны салбарын ААН, байгууллагын сарын дундаж цалин 2017 оны байдлаар 865.8 мян.төг байна. ИДС төгсөгчдийн мэргэжлийн чиглэлээр сарын дундаж цалин, орлогын хувьд барилга архитектур 857.8 мянга, компьютер 829.7 мянга, тээвэр 826.3 мянга, үйлдвэрлэлийн технологи 771.6 мянган төгрөгийн дундаж цалинтай байна.

График 1. 2 Хөдөлмөр эрхэлж буй их, дээд сургууль төгсөгчдийн дундаж цалин мэргэжлийн чиглэлээр /2017/



МБСБ төгсөгчдийн мэргэжлийн чиглэлээр сарын дундаж цалин, орлогын хувьд уул уурхайн мэргэжлийн чиглэл 759.0 мянга, тээврийн салбарын мэргэжлийн чиглэл 688.0 мянга, барилгын салбарын мэргэжлийн чиглэл 636.3 мянган төгрөгийн цалин авдаг нь бусад салбартай харьцуулахад өндөр байгаа бол мэдээллийн технологийн салбарын дундаж цалин 538.9 мянган төгрөг гэсэн харьцангуй бага үзүүлэлт харагдаж байна.

График 1. 3 Хөдөлмөр эрхэлж буй МБСБ төгсөгчдийн сарын дундаж цалин, мэргэжлийн салбараар





Ажил хайгаад олдохгүй байгаа ИДС төгсөгчдийг эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр нь авч үзвэл 20.4 хувь нь багш, боловсрол судлал, 16.0 хувь нь бизнес удирдлага, 10.3 хувь нь үйлдвэрлэлийн технологи, 8.1 хувь нь бүх төрлийн инженер мэргэжлийн чиглэлээр төгсөгчид дийлэнх нь байна.

График 1. 4 Ажил хайгаад олдохгүй байгаа ИДС төгсөгчид мэргэжлийн чиглэлээр, хувиар



Мэдээллийн технологийн чиглэлээр МБСБ-д мэргэжил эзэмшсэн ажил горилогчдын хувьд хөдөлмөрийн зах зээд дээр гараад ажил хийх боломж харьцангуй бага байдаг нь доорхи судалгаанаас харагдаж байна.

График 1. 5 Ажил хайгаад олдохгүй байгаа МБСБ төгсөгчид мэргэжлийн чиглэлээр, хувиар




График 1. 6 Нийт ИДС төгсөгчид эзлэх хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн чиглэлээр

Мэргэжлийн чиглэл	2013 он	2014 он	2017 он
Багш боловсрол судлал	78.3	82.1	76.5
Урлаг	77.8	70.0	60.7
Хүмүүнлэгийн ухаан	54.5	59.0	60.6
Нийгэм, эдийн засаг	84.8	78.9	71.9
Мэдээлэл, сэтгүүл зүй	80.0	62.5	63.0
Бизнес удирдлага	77.8	67.0	64.0
Хууль эрхзүй	66.7	76.6	60.7
Биологи	68.9	63.0	67.5
Физик, хими, геологи, газарзүй	75.6	76.1	71.5
Математик статистик	80.0	73.7	71.8
Компьютер	73.3	72.2	70.9
Бүх төрлийн инженер	75.6	78.9	69.3
Үйлдвэрлэлийн технологи	68.9	50.0	68.7
Барилга, архитектур	93.3	80.2	83.2
ХАА, ой, загасны аж ахуй	79.5	66.5	64.0
Мал эмнэлэг	75.6	65.9	69.9
Анагаах ухаан	82.2	71.4	71.3
Нийгмийн халамж, хангамж	68.2	66.7	51.9
Биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ	62.2	70.2	56.9
Тээвэр болон бусад	85.0	74.5	72.7
Байгаль хамгаалал	63.6	60.8	61.9

Их дээд сургууль төгсөгчдийн мэргэжлийн чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийн хувийг 3 жилийн үзүүлэлтээр харвал, тогтмол 80-аас дээш хувьтай нь барилга, архитектурын чиглэл байна. Судалгааны 3 жилд нийт төгсөгчдийн 70-аас дээш хувь нь хөдөлмөр эрхэлсэн мэргэжлийн чиглэлүүдэд багш, боловсрол судлал, нийгэм, эдийн засаг, математик, статистик, анагаах ухаан орж байна. Судалгааны эхний жилийн хөдөлмөр эрхлэлттэй харьцуулахад жил дараалан буурч байгаа мэргэжлийн чиглэлүүдэд урлаг, нийгэм, эдийн засаг, бизнес удирдлага, математик статистик, компьютер, ХАА, ой, загасны аж ахуй, нийгмийн халамж, хангамж оржээ.

#### Дээд боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчид

Төгсөгчдийн мэргэжлийн чиглэл. Нийт төгсөгчдийн 15.0% нь боловсрол, 5.8% нь урлаг ба хүмүүнлэг, 36.6% нь нийгэм, эдийн засаг, мэдээлэл-сэтгүүл зүй, бизнес, удирдлага, эрх зүй, 4.0% нь байгалийн шинжлэх ухаан, 17.5% нь инженер, технологи, барилга-архитектур, 2.4% нь хөдөө аж ахуй, 12.6% нь эрүүл мэнд, нийгмийн халамж, 5.0% нь үйлчилгээний, 1.1% нь бусад салбарт хамаарч байна. Үүнийг өмнөх хоёр хичээлийн жилтэй харьцуулбал: инженер, технологи, барилга-архитектурын салбарын эзлэх хувь 12.7-17.5 хүртэл өсөж, бусад салбарын хувь ойролцоо түвшинд

байна.

Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал. 2016-2017 оны хичээлийн жилийн нийт төгсөгчдийн 32.2 хувь нь төгссөн даруйдаа ажлын байртай болсон гэсэн статистик мэдээ байна. Энэ үзүүлэлт өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад 1.3 пунктээр өсчээ. Докторантур төгсөгчид бараг бүхэлдээ (98.2%), магистрантур төгсөгчдийн 74.8 хувь нь ажлын байртай хүмүүс байгаа бол бакалаврын зэргээр төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал 26.9 орчим хувьтай байгаа нь нэгдүгээрт, зарим сургуулиуд төгсөгчдийн ажил эрхлэлтийн мэдээгээ бүрэн гаргаж чадахгүй байгаа, хоёрдугаарт, төгсөгчид төгссөн үедээ тэр бүр ажлын байртай болж амжихгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

### **Монголын ХХМТ-ийн мэргэжилтэй боловсон хүчний мэдлэг, чадварыг үнэлж буй өнөөгийн байдал**

Манай улсад ХХМТ-ийн чадвар, чадамжийг үнэлж буй байдлыг авч үзвэл:

1. “Олон улсын компьютерийн хэрэглээний гэрчилгээ”-ний шалгалт “Суурь”, “Дунд”, “Ахисан” 3 түвшний нийт 17модультай. ICDL модуль бүр хамгийн сүүлийн үеийн мэдээллийн технологийн ур чадвар, мэдлэгийг практиктай хослуулсан агуулгыг хөтөлбөртөө тусгадаг байна. Энэ шалгалт нь олон улсын стандартын шалгуур үзүүлэлтэнд суурилсан хэрэглэгчдийн компьютерийн хэрэглээний ур чадвар, мэдлэг, практикийг үнэлдэг шалгалт юм.
2. Мэдээллийн технологийн инженерийн шалгалт (МТИШ) нь 1969 оноос үүсэлтэй Япон улсын МТИШ-ын системд суурилдаг. Энэ нь МТ-ийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, МТ-ийн мэргэжлийн чиглэл бүрт шаардагдах чадварын түвшинг тодорхойлох, МТ-ийн инженерүүдийн ур чадварыг үнэлэх бодит шалгуурыг тогтоох улмаар сайн инженерүүдийн нийгэм дэх байр суурийг дээшлүүлэх зорилготой. МТИШ нь 4 түвшний 12 шалгалтаас бүрддэг.
3. Мэдээлэл технологийн практик ур чадварын олон улсын топсит /topcit/ шалгалтыг 2017 оны 05 дугаар сараас албан ёсоор зохион байгуулж эхэлсэн. Энэхүү шалгалтын онцлог нь энэ салбарт сурч байгаа оюутан, энэ салбарт ажиллаж байгаа албан хаагч болон програм хангамж, өгөгдлийн сан, мэдээллийн сан, мэдээллийн аюулгүй байдал, мэдээлэл технологийн бизнес, тенхологийн харилцан холболт, төслийн удирдлага зэрэг чиглэлүүдийн мэдлэг, практик ур чадвар үнэлэх зорилготой гүйцэтгэлийн үнэлгээний шалгалт юм. Инженерийн боловсролын шинэчлэлийн CDIО стандарт арга зүйг манай орноос ШУТИС анх 2015 онд уг санаачлалгын гишүүн орноор элсэж байсан.

Дэлхийн улс орнуудын хөгжлийг тодорхойлох нэг гол хүчин зүйл нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн хөгжил дэвшил байдаг. Дэлхийн улс орнуудын ХХМТ-ийн хөгжлийн индексийн 2017 оны үзүүлэлтээс авч үзэхэд Бүгд Найрамдах Солонгос улс (БНСУ) энэ жагсаалтыг тэргүүлсэн ба Ази тивийн төлөөлөл Хонгконг, Япон, Сингапур зэрэг улсууд эхний 20-д эрэмбэлэгдсэн байна. Уг хөгжлийн индекс нь ХХМТ-ийн хүртээмж, хэрэглээ, чадамж гэсэн гурван гол хэмжигдэхүүнээр илэрхийлэгддэг ба

үүнд тухайн улс орнуудын 100 оршин суугч тутам дах суурин утас, гар утасны хэрэглээ, захиалга, хувийн компьютер болон интернет ашигладаг өрх, хувь хүний хувь, тоо хэмжээ зэрэг олон шалгуур үзүүлэлтийн нийлбэр цогцоор тодорхойлогддог байна.

Хүснэгт 3. 13 ХХМТ-ийн хөгжлийн индексийн үзүүлэлтээр дэлхийн шилдэг 20 улсын жагсаалт

№	Улсын нэр	ХХМТ индекс	№	Улсын нэр	ХХМТ индекс
1	БНСУ	8.93	11	<i>Япон</i>	8.47
2	Дани	8.88.	12	<i>Финлянд</i>	8.36
3	Исланд	8.86	13	Австрали	8.29
4	Их Британи	8.75	14	АНУ	8.19
5	Швед	8.67	15	Герман	8.22
6	Люксембург	8.59	16	Шинэ Зеланд	8.14
7	Швейцарь	8.56	17	Франц	8.12
8	Нидерланд	8.53	18	Монакка	8.10
9	Хонгконг	8.52	19	Сингапур	8.08
10	Норвеги	8.49	20	Истон	8.05

эх сурвалж: [www.worldatlas.com](http://www.worldatlas.com)

ХХМТ-ийн салбарын хурдацтай хөгжлийг даган энэ салбарын чадварлаг мэргэжилтэй боловсон хүчинг бэлтгэх талаар дэлхийн улс орнууд ач холбогдол өгч анхаарлаа хандуулж байгаа нь зайлшгүй. Харилцаа холбоо, мэдээллийн технологи салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх нь маш өргөн хүрээтэй ойлголт ба үүнд шуудан харилцаа, радио телевиз, хэвлэл, компьютерийн шинжлэх ухаан, програм хангамж, мэдээллийн систем зэрэг олон төрлийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудыг хамруулах шаардлага гарч байгаа юм. Ерөнхийдөө ХХМТ-ийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх чиглэлийн хүрээнд дэлхийн их дээд сургуулиудын сургалтын чиг хандлага, хөтөлбөрийн хувьд авч үзэхэд Нэг. Харилцаа холбоо ба Медиа, сэтгүүл зүй, телевиз, шуудан харилцаа, Хоёр. Компьютерийн шинжлэх ухаан, програм хангамж, мэдээллийн систем гэсэн хоёр үндсэн чиглэлд хуваагдан мэргэжилтэй боловсон хүчинг бэлтгэж байна. Тухайлбал 2018 оны статистик үзүүлэлтээс харахад Харилцаа холбоо болон медиа чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчинг бэлтгэдэг дэлхийн топ их, дээд сургуулиудын жагсаалтаас Европ болон Америк





тивд орших их дээд сургуулиуд тэргүүлж байгаа бол энэ салбарын инженер техникийн мэргэжилтэй (Telecommunication engineering) боловсон хүчинг бэлтгэхэд Ази тив тэр дундаа БНХАУ-ын их, дээд сургуулиуд тэргүүлэх байр эзэлж байна.









Хүснэгт 3. 14 Харилцаа холбоо болон медиа (communication and media) чиглэлийн дэлхийн их дээд сургуулиудын эрэмбэ, 2018

Эрэмбэ	Сургуулийн нэр	Байршил
<b>1</b>	Амстердам Их сургууль	Нидерланд
<b>2</b>	Өмнөд Калифорни Их Сургууль	АНУ
<b>3</b>	Улс төрийн ШУ болон Эдийн засгийн сургууль	Их Британи
...	Англи, АНУ-ын их дээд сургуулиуд	
<b>12</b>	Нанян Технологийн их сургууль	Сингапур
<b>14</b>	Сингапурын их сургууль	Сингапур
<b>20</b>	Хонгконгийн Хятадын их сургууль	Хонгконг
<b>28</b>	Мельбурнын их сургууль	Австрали
<b>30</b>	Зүрчийн их сургууль	Швейцарь
<b>32</b>	Сөүлийн их сургууль	БНСУ
<b>32</b>	Архусын их сургууль	Дани

эх сурвалж: [www.worldtopuniversities.com](http://www.worldtopuniversities.com)

Хүснэгт 3. 15 Харилцаа холбооны инженер (telecommunication engineering) дэлхийн их дээд сургуулиудын эрэмбэ, 2018

Эрэмбэ	Сургуулийн нэр	Байршил
<b>1</b> 	<b>Цяньхуа их сургууль</b>	Хятад
<b>2</b> 	Шуудан, харилцаа холбооны Бээжингийн их сургууль	Хятад
<b>3</b> 	Нанян Технологийн их сургууль	Сингапур
<b>4</b> 	Шидан их сургууль	Хятад

5		Техасын их сургууль	АНУ
6		Колумбын их сургууль	Канад
7		Зүүн өмнөдийн их сургууль	Хятад
8		Ватерлүүгийн их сургууль	Канад
9		Сингапурын их сургууль	Сингапур
10		Шанхайн Жаотун их сургууль	Хятад
11		Шинжлэх ухаан, электрон, технологийн хятадын их сургууль	Хятад
12		<b>Шинжлэх ухаан, технологийн Хуажон их сургууль</b>	Хятад

эх сурвалж: [www.shanghairankings.com](http://www.shanghairankings.com)

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн хурдацтай өсөлтийнхөө нөлөөгөөр Бүгд Найрамдах Хятад Ард улсын Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар мөн адил өргөжин тэлж, хөгжиж байгаа нь тодорхой юм. Тиймээс ч энэ салбарын мэргэжилтэй боловсон хүчинг бэлтгэх сургалтын чиглэл, хөтөлбөрт хятадын их, дээд сургуулиуд ихээхэн анхаарлаа хандуулж, чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэж байна. Энэхүү судалгааны ажлын хүрээнд БНХАУ-д ХХМТ чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж байгаа Шинжлэх ухаан, технологийн Хуажон их сургууль, Бээжингийн технологийн их сургууль, Бээжин хотын Шуудан харилцаа холбооны их сургууль, Харбин Шинжлэх Ухаан Технологийн Их сургууль, МИРЭА Оросын технологийн их сургууль, Санкт-Петербургийн технологийн их сургууль, Туркийн Газы технологийн сургууль, Туркийн Осман-газы технологийн сургуулийг тус тус онцлон сургалтын хөтөлбөр, чиг хандлагын талаар судалсан болно.



### Шинжлэх ухаан, технологийн Хуажон их сургууль

БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн Хуажон их сургууль (Huazhong University of Science and Technology-HUST) 1952 онд анх байгуулагдсан, Хубэй мужийн Вухан хотод оршдог. Шинжлэх ухаан, технологийн Хуажон их сургууль философи, эдийн засаг, хууль, боловсрол, уран зохиол, түүх, инженер, хөдөө аж ахуй, эм зүй, менежмент болон урлаг уран сайхан гэх үндсэн 12 салбар мэргэжлээр 94 баклавр, 225 магистр, 184 докторын зэрэгтэй мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж байгаа юм. Хуажон их сургууль 35 гаруй улс орны 100 гаруй их дээд сургуультай гадаад хамтын

ажиллагаагаа явуулдаг ба жилд дунджаар 1600 гаруй эрдэмтэн, экспертүүд болон 140 гаруй улс орноос 3700 гаруй оюутнууд Хуажон их сургуульд хүрэлцэн ирж суралцаж, туршлага солилцдог байна.

Хуажон их сургууль нь Хятад улсдаа хамгийн олон оюутнууд элсүүлэн суралцуулж байгаа болон мөн түүнчлэн ХХМТ-ийн салбарын тэргүүлэх мэргэжилтэй боловсон хүчинг бэлтгэдэг байна. Тухайлбал Хятадын томоохон Huawei, TCL, Vivo, Oppo, ZTE зэрэг үүрэн телефоны компаниудын голлох, чадварлаг мэргэжилтэй боловсон хүчнүүд ихэвчлэн Хуажон их сургуулийн төгсөгч, суралцагч нар байдаг байна. Хуажон их сургуулийн ХХМТ-ийн салбарын мэргэжилтэй боловсон хүчинг Харилцаа холбоо, электроник мэдээллийн сургууль голлон бэлтгэж байна. Энэ салбар сургууль нь анх 1960 байгуулагдсан ба одоогоор 158 факультад 23 профессор, 64 ассистент профессорууд багшилж байна. Уг сургуульд одоогоор баклавр болон магистрийн програмд олон улсын 160 гаруй оюутнууд элсэн суралцаж, сургуулийн дотуур байрлан амьдарч байна.

Шинжлэх ухаан технологийн Хуажон их сургуулийн цахим хуудсаар зочлон дэлхийн хаанаас ч та англи хэл дээр тухайн сургууль болон сургалтын хөтөлбөр, суралцах орчин нөхцөлийн талаарх өөрийн хүссэн бүх мэдээллээ бүрэн авах боломжтой (<http://www.hust.edu.cn>)

Хуажон их сургуулийн Харилцаа холбоо, электроник мэдээллийн сургуулийн сургалтын ерөнхий хөтөлбөрийг ерөнхий төлөвлөгөөг доорх хүснэгтээр харуулав. /Мөн ОХУ-ын сургуулиуд, Туркийн сургуулиудын хичээлийн ерөнхий хөтөлбөрийг хавсралтаар оруулав./

Хүснэгт 3. 16 Сургалтын хөтөлбөрийн ерөнхий төлөвлөгөө

	Хичээл	Кредит	Нийт
<b>Үндсэн хичээл</b>	Гадаад хэл-анхан шат	4	7
	Хятадын талаарх танилцуулга	2	
	Олон улсын оюутнуудыг чиглүүлэх хичээл	1	
	Их өгөгдөл анализ	2	
	Компьютерийн сүлжээ	4	
	Сүлжээ болон мэдээллийн аюулгүй байдал	2	

<b>Мэргэжлийн хичээл</b>	Хөдөлгөөнт харилцаа холбооны систем	3	19
	Хиймэл оюун ухаан	2	
	Интернэт апплэйкишн	2	
	Электрон зар сурталчилгаа	2	
	Төслийн менежмент	2	
<b>Судалгаа шинжилгээ</b>	Судалгааны сэдвийн саналын танилцуулга	1	14
	Академик санал	1	
	Дипломын ажил	10	
	Инженерийн дадлага ажил	2	
<b>Нийт</b>			40

Дэлхийн улс орнууд өөр өөрийн орны хөгжлийн бодлогод тулгуурлан ХХМТ-ийн чиглэлийн боловсон хүчийн төлөвлөлтийг тооцоо судалгаатайгаар хийдэг. Мөн тухайн улсын зах зээлийн өсөлт хөгжлөөс хамааран их, дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрийн агуулга харилцан адилгүй байдаг. Тухайлбал:

1. ОХУ-ын эдийн засгийн эрчимтэй өсөлтийн нэг гол чиглэл нь харилцаа холбоо, мэдээллийн технологи юм. Газрын тос, байгалийн хийнээс гадна ОХУ-д ХХМТ-ийн салбар нь эдийн засгийн хөгжлийн хоёр дахь хөдөлгөгч хүч болж байна. 2000 оноос хойш энэ салбар ОХУ-ын эдийн засгийн дундаж үзүүлэлтээс дөрөв дахин хурдан өссөн байдаг. Орос улсын эдийн засгийн өсөлт нь шинэ дэвшилтэт технологиуд, ялангуяа шинэлэг дэд бүтцийг амжилттай хөгжүүлснээс шууд хамаарч байна гэж үзсэн байна. ОХУ-ын эрчим хүч, тээврийн системүүд орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан харилцан уялдаатай болж, улс орон даяар Smart Cities санаачлалыг нэвтрүүлж байна. Үүнтэй холбоотойгоор технологид төвлөрсөн дэд бүтцийг хөгжүүлэх, техник хэрэгсэлтэй ажиллах мэргэжилтэй боловсон хүчинг түлхүү бэлдэж байна. Оросын Холбооны Улсын ХХМТ-ийн чиглэлээр мэргэжилтэн бэлдэж буй Их, дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрөөс харахад математик, физик, хими, оптик тал дээр суурилан мэргэжилтэнгүүдийг бэлтгэж байна.



2. БНХАУ нь 2020 оноос эхлэн эдийн засгаараа тэргүүлж, 2030 онд дотоодын нийт бүтээгдэхүүн нь 64,2 их наяд ам.доллараар хэмжигдэх урьдчилан таамагтай байна. Харин Энэтхэг улсын эдийн засаг 2030 онд 46,3 их наяд ам.доллар болж АНУ-ыг давах тооцоо гарчээ. Харилцаа холбооны инженер техник, програм хангамж, мэдээллийн системийн чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчнийг бэлдэж буй Азийн томоохон сургуулиудыг жагсаалтыг БНХАУ-ийн сургуулиуд эзэлдэг. БНХАУ нь хэрэглээний програм хангамжийг түлхүү хөгжүүлэх чиглэлийн бодлого баримталдаг ба дэлхийн ухаалаг гар утасны технологийг ханган нийлүүлж байна. Технологийн боловсрол, аялал жуулчлал, худалдаа, өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг интернетэд холбох болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах тал руугаа түлхүү анхаарч ажиллаж боловсон хүчнээ бэлдэж байна.
3. Турк улсын харилцаа холбооны салбар нь тэргүүлэх салбаруудын нэг. Туркийн Засгийн газар нь Цахим-хувьсгал /бүртгэлийн цахим шуудан, цахим виз, цахим паспорт/ зэрэг бусад төслүүдэд чухал ач холбогдол өгч байна. Кибер аюулгүй байдлын сегмент нь корпораци болон засгийн газрын МХТ-ийн аюулгүй байдлын системүүд ихээхэн санхүүжилтийг татахын тулд хэвээр үлдэх төлөвтэй байна. Сүлжээний аюулгүй байдал, вирус, имэйл, вэбсайтын аюулгүй байдал, кибер засаглал, гэрчилгээ, хөдөлгөөнт аюулгүй байдал, системийн аюулгүй байдал, өгөгдөл, хэрэглээний аюулгүй байдал зэрэг сүлжээний аюулгүй байдлын тэргүүлэх чиглэлүүд нь зах зээл дээр тэргүүлэх чиглэлүүд болж байна. Туркийн Засгийн газар кибер аюул заналыг даван туулахдаа тоног төхөөрөмж, програм хангамжид зардлаа нэмэгдүүлсэн. Эдгээр хамгаалалтыг хэрэгжүүлэхийн тулд Хууль зүй, дотоод хэргийн яам, Туркийн Үндэсний цагдаа, Туркийн цэргүүд нь кибер аюулгүй байдлын технологийг шинэчлэж байна.
4. Монгол улсын хувьд харилцаа холбоо, мэдээллийн салбарт нийт 42 мэргэшлийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байна. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлдэж буй томоохон сургуулиудын нэг ШУТИС-ийн багш нарын үзэж байгаагаар бакалаврын түвшинд сайн мэргэжилтэн бэлдэж байгаа, магистр болон докторын ахисан шатны түвшинд төдийлөн сайн боловсон хүчин бэлдэж чадахгүй байгаа гэж дүгнэж байна ***/Цахим бодлогын түр хорооны хэлэлцүүлэг/.***

МУ-ын Засгийн газраас харилцаа, холбоо мэдээллийн технологийн чиглэлд баримталж буй бодлогыг авч үзвэл төрийн үйлчилгээг иргэдэд илүү дөхөм, амар хэлбэрээр хүргэх, мэдээллийн ил тод байдлыг бий болгох, утасгүй интернетийн хүртээмж, хурдыг нэмэгдүүлэх боломжийг бий болгох гэх мэт хэрэглээний түвшинд ХХМТ-ийн хөгжлийг түлхүү хандуулж байна гэж үзэж байна. Цаашид дэлхийн нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн МУ-ын ХХМТ-ийн салбарын хэтийн хөгжлийн чиг хандлагыг оновчтой тодорхойлох, бодлогын баримт бичгүүдийг боловсруулах;

харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн талаар цаашид баримтлах бодлого, чиглэлийг тодорхой болгох шаардлагатай байна.

### **Монголын ХХМТ-ийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэдэг сургуулиудын судалгаа**

2018 оны байдлаар БСШУС-ын яаманд бүртгэлтэй 100 орчим их дээд сургууль, коллеж байгаагийн 39 нь ХХМТ-ийн мэргэжлийн чиглэлээр боловсон хүчин бэлтгэдэг байна. 2018 оны байдлаар нийт их дээд сургууль, коллежийн 40.6 хувь нь ХХМТ-ийн чиглэлээр боловсон хүчин бэлтгэж байна. IT zone компаний хүний нөөцийн менежер П.Эрдэнэжаргалын дурдсанаар өнөөгийн байдлаар мэдээлэл технологийн салбарт хамгийн хүндрэлтэй байгаа асуудал нь програмистын эрэлт хэрэгцээ гэсэн байна. Манайд ХХМТ-ийн чиглэлээр боловсон хүчин бэлтгэж байгаа нийт сургуулийн 24 буюу 61.5 хувь програм хангамжийн чиглэлээр хүний нөөц бэлтгэдэг. Үүнээс үзэхэд энэ чиглэлээр боловсон хүчин бэлтгэж байгаа сургуулийн тоо хангалттай байгаа хэдий ч төгсөгчдийн тоо бага, чадварлаг боловсон хүчин бэлтгэгдэхгүй байгаатай эсвэл төгссөн чадварлаг ажилтнууд гадагшаа буюу өндөр хангамжтай байгууллагуудад орж байгаатай холбоотойгоор эрэлт үүсэж байна гэж харж болох юм.

**Фокус бүлгийн ярилцлаганд оролцогч М.М:** Манай байгууллагад дата анализ, data science чиглэлийн боловсон хүчин хэрэгтэй байгаа юм. Энэ чиглэлээр хүн авья гэхээр монголд энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа сургууль байхгүй бид нар математикаас нэг үзнэ, статистикаас үзнэ, ШУТИС-ээс харна, ХААИС-ийг харсан. Боломжтой гэсэн бүх сургуулиас дата анализ чиглэлийн мэргэжилтэн хайж үзсэн. Ингээд хамгийн дөхдөг нь математик програм суурьтай хүмүүс байдаг. Яг хоёуланг нь эзэмшсэн хүн хайхаар олдож өгдөггүй. Ийм мэргэжил нь байхгүй болохоор мэдээж хэрэг. Одоо хэр нь манайд энэ чиглэлээр төгсөж байгаа мэргэжилтэн байхгүй. Харин гадаадад энэ чиглэлээр төгсгөөд байдаг. Монголд хайхаар ерөөсөө олддоггүй. Хэрвээ бодлого байсан бол бид нар аж үйлдвэрийн 4-р хувьсгал, big data гээд явж байгаа бол энэ чиглэлийн боловсон хүчнийг аль хэдийн бэлтгэж эхэлсэн байх ёстой.

ХХМТ-ийн чиглэлээр боловсон хүчин бэлтгэдэг 39 их, дээд сургуулиудын хөтөлбөрийн дагуу ХХМТ-ийн салбарын 42 төрлийн мэргэжилтэй боловсон хүчинг Монгол улсад бэлтгэж байна.

#### **Монгол улсад ХХМТ-ийн чиглэлээр бэлтгэж буй мэргэжлийн жагсаалт:**

1. Мэдээллийн технологи
2. Програм хангамж
3. Мэдээлэл зүйн боловсрол
4. Мэдээлэл зүй
5. Компьютерийн програм хангамж
6. Компьютерийн сүлжээ
7. Компьютерийн ухаан
8. Мэдээллийн систем

9. Сүлжээний технологи
10. Электроник
11. Электрон системийн автоматжуулалт
12. Өгөгдлийн сангийн загварчлал удирдлага
13. Дуу чимээний технологи
14. Радио, дэлгэцийн техник, технологи
15. График дизайн/ медиа анимейшн
16. Математик программ хангамж
17. Мэдээллийн аюулгүй байдал
18. Харилцаа холбооны менежмент
19. Мэдээллийн системийн менежмент
20. Мэдээллийн системийн аюулгүй байдал
21. Цахилгаан холбоо
22. Утасгүй холбоо
23. Электрон системийн програм хангамж
24. Автоматжуулалтын систем
25. Холбооны сүлжээ, холболтын технологи
26. Оптик холбоо
27. Компьютерийн техник
28. Эмбэддэд систем
29. Телевизийн техник технологи
30. Компьютерийн график дизайн
31. Коммуникейшин дизайн
32. Системийн аюулгүй байдал
33. РТК-электроник
34. ЗПК-электроник
35. Цэргийн холбооны инженер
36. Зенитийн артиллери-электроник
37. Радиотехникийн команд
38. Холбооны техник, хэрэгсэл
39. Радио техник
40. Цэргийн удирдлагын автоматжуулалт
41. Цэргийн холбоо, цэргийн радио холбоо
42. Холбооны алба чиглэлээр мэргэжилтэн бэлдэж байна.

Мэдээллийн технологийн чиглэлээр суралцаж буй нийт суралцагдын 1905 буюу 28.7 % нь эмэгтэй бөгөөд энэ үзүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн ажиглагдаж байна.

2018-2019 онд ХХМТ-ийн чиглэлээр боловсон хүчин бэлтгэж байгаа сургуулиуд, суралцагчдын тоо, мэргэжлийн байдал болон боловсролын зэрэг, хүйсээр.

Сургуулийн нэр	Мэргэжлийн		Сургууль, мэргэжил /хөтөлбөр/-ийн нэр	Суралцагчид		
	зэрэг	индекс		бүгд	эм	
1.Батлан Хамгаалахын Их Сургууль	бакалавр (өдөр)	D061904	Системийн аюулгүй байдал	30	0	
		D103103	РТК-электроник	160	57	
		D103108	ЗПК- автоматжуулалт	30	0	
		D103106	Цэргийн холбооны инженер	140	113	
		D103104	Зенитийн артиллери- электроник	9	0	
		D103106	Цэргийн холбооны инженер	10	0	
	бакалавр (эчнээ)	D103108	Радиотехникийн команд	29	5	
		D103108	ЗПК- автоматжуулалт	11	4	
	магистрантур (өдөр)	E10310601	Холбооны техник, хэрэгсэл	6	3	
		E10310801	Радио техник	3	1	
		E10310602	Цэргийн удирдлагын автоматжуулалт	1	1	
		E861200	Цэргийн холбоо, цэргийн радио холбоо	1	1	
		E861600	Холбооны алба	1	1	
	<b>Дүн</b>				<b>431</b>	<b>186</b>
	2.Дорнод их сургууль (Дорнод)	бакалавр (өдөр)	D061204	Мэдээллийн технологи	4	0
3.Монгол Улсын Боловсролын Их Сургууль	бакалавр (өдөр)	D061302	Програм хангамж	105	33	
	магистрантур (өдөр)	E01140102	Мэдээлэл зүйн боловсрол	2	0	
		E141700	Мэдээлэл зүй	5	3	

	магистрантур (эчнээ)	E01140102	Мэдээлэл зүйн боловсрол	10	7
	магистрантур (гадаад)	E01140102	Мэдээлэл зүйн боловсрол	4	0
	<b>Дүн</b>			<b>130</b>	<b>43</b>
4.Монгол Улсын Их Сургууль	бакалавр (өдөр)	D480200	Компьютерийн програм хангамж	1	0
		D 061201	Компьютерийн сүлжээ	159	30
		D 061301	Компьютерийн ухаан	127	26
		D 061303	Мэдээллийн систем	161	70
		D 061304	Мэдээллийн технологи	175	56
		D 061302	Програм хангамж	333	106
		D 061903	Сүлжээний технологи	131	68
		D 071401	Электроник	235	40
		<b>Дүн</b>			<b>1322</b>
	магистрантур (өдөр)	E 06120101	Компьютерийн сүлжээ	29	8
		E 06130101	Компьютерийн ухаан	7	1
		E 06180102	Компьютер-хэл шинжлэл	3	2
		E 06130401	Мэдээллийн технологи	28	7
		E 06120102	Өгөгдлийн сангийн загварчлал удирдлага	4	0
		E 06130201	Програм хангамж	20	4
		E 07140101	Электроник	15	2
		<b>Дүн</b>			<b>106</b>
	докторантур (өдөр)	F 06120101	Компьютерийн сүлжээ	1	0
		F 06130101	Компьютерийн ухаан	8	4
		F 06130401	Мэдээллийн	4	1

			технологи		
		F 06130201	Програм хангамж	7	1
		F 07140101	Электроник	3	1
		<b>Дүн</b>		<b>23</b>	<b>7</b>
	<b>Нийт дүн</b>			<b>1451</b>	<b>427</b>
ISO 27001 нь мэдээллийн аюулгүй байдлын менежментийн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг практик стандарт юм. ISO 27001-ийг хэрэгжүүлснээр аливаа бизнесийн мэдээллийг хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохицуулалтын үүргээ биелүүлж, кибер аюулгүй байдлыг бий болгоход шаардлагатай арга хэмжээг авсан хэрэглэгч, сонирхогч талуудад баталгаа өгөх болно. Кибер аюулгүй байдлын тухай үндсэн ойлголтууд, тэдгээрийн мэдээллийн аюулгүй байдлын хүрээний бусад ойлголтуудтай хэрхэн уялдаатай байх зэргийг багтаасан ISO/IEC 27032:2012 Information technology -- Security techniques -- Guidelines for cybersecurity, олон улсын стандартыг эрх бүхий байгууллагаас 2012 оны 7 дугаар сараас батлан гаргасан байна.

Технологийн дэвшлийн салшгүй хэсэг кибер аюулгүй байдал юм. 2016 онд явуулсан бүх имэйлийн бараг нэг хувь нь ихэвчлэн хорлон сүйтгэх халдлага байсан нь сүүлийн жилүүдэд хамгийн өндөр үзүүлэлт юм. Ransomware халдлагууд нь бизнес болон хэрэглэгчид улам ихээр өртөж, хор хөнөөлтэй имэйлүүд их хэмжээгээр татан авч байна. 2017 оны 5-р сард их хэмжээний кибер халдлага нь 150 гаруй орны компаниуд, эмнэлгүүдэд томоохон саад тотгор учруулж, дэлхий даяар илүү их хамтын ажиллагааг уриалсан үзэгдэл болж байлаа. 2014 онд Global Cybersecurity Index (GCI) –ийг анх эхлүүлсэн бөгөөд зорилго нь кибер аюулгүй байдлын дэлхийн соёлыг бэхжүүлэх, ХХМТ-ийн салбарын нэгдлийг дэмжихэд оршино. Мөн дэлхийн хэмжээнд кибер аюулгүй

байдлын талаар цаашдаа баримтлах бодлого чиглэлийг тодорхойлох, ITU-ийн гишүүн улс орнуудын кибер аюулгүй байдлыг хангахад чиглэдэг.

## ГУРАВ. ИХ ӨГӨГДӨЛ


Дэлхийн улс орнуудад нийгэм, улс төр, эдийн засгийн бүхий л салбарт нь мэдээллийн технологи эрчимтэй нэвтэрч энэ нь хүмүүсийн ажил, амьдрал, дадал, зан төлөвт ихээхэн өөрчлөлтүүдийг авчирсаар байна. Мэдээллийн энэхүү эрин зуунд асар их хэмжээний мэдээлэл өдөр бүр үүсч байгаа ба цаашдаа ч энэ нь улам ихээр үүсэх нь илт байна. 2011 онд Гартнер (дэлхийн ХХМТ-ын судалгааны байгууллага) тэмдэглэхдээ их хэмжээний өгөгдөл нь мэдээллийн технологийн дэд бүтцэд виртуалчлалын дараа 2-рт орох гол чиг хандлага болно гэсэн байна. Их хэмжээний өгөгдлийн технологийг нэвтрүүлснээр үйлдвэрлэл, эрүүл мэнд, худалдаа, улсын удирдлага, хувь хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийж байгаа салбаруудад хамгийн их нөлөө үзүүлнэ гэж таамаглаж байна. 2013 оноос эхлэн их, дээд сургуульд өгөгдлийн болон тооцон бодох шинжлэх ухаан, инженерийн чиглэлээр хөтөлбөрүүд гарч тэдгээрт их хэмжээний өгөгдөл хичээл болж заагдах болжээ.

Big data бол том хэмжээтэй дататай харьцах тухай цогц ойлголт. Өөрөөр хэлбэл уламжлалт дата боловсруулах системүүдийн хэрээс хэтэрсэн асар том хэмжээний дата, түүнтэй холбоотой бүх ойлголтуудыг нэгтгэсэн ойлголт юм. Үүнд датаг шинжлэх, олж авах, боловсруулах, хайлт хийх, хуваалцах, түгээх, хадгалах, дамжуулах, визуалчлах, нууцлал зэрэг ойлголтууд багтана.

Мэдээллийн технологийн салбарт тэргүүлэгч IDC компаний судалгаанд 2005 оноос 2020 он гэхэд мэдээллийн хэмжээ 130 exabyte-аас 40,000 exabyte / Мэдээллийг хэмжих нэгж бөгөөд  $10^{18}$ -тай тэнцүү/ хүрнэ. Энэ хугацаанд 2 жил тутам мэдээллийн хэмжээ 2 дахин их болно. Мэдээллийн технологид оруулж буй хөрөнгө оруулалт 40%-аар өсөх ба үүний үр дүнд 1 gigabyte-д оруулж буй хэмжээ \$2.00-оос \$0.20 болж буурна. Мэдээллийн хадгалалтын удирдлага, аюулгүй байдал, их хэмжээний мэдээлэл, үүлэн тооцоололд оруулж буй хөрөнгө оруулалт ихээхэн хурдацтай өсөх болно гэжээ. Ийнхүү мэдээлэл асар их хэмжээгээр үүсэж байгааг судлаачид дараах үндсэн хүчин зүйлээр тайлбарлаж байна. Юуны өмнө 1990-ээд онд интернет үүсч компьютерууд хоорондоо холбогдсон, том дата төвүүд бий болсон явдал юм. Ухаалаг гар утас мөн нэг чухал хүчин зүйл болж байна. Ухаалаг гар утас хэрэглээнд нэвтэрснээр хүмүүс янз бүрийн аппликэйшн ашиглаж, өөр өөрийн мэдээллийг үүсгэж байна. Дараагийн нэг хүчин зүйл нь өнөөгийн интернетийн хөгжил буюу Эд юмсын интернет (Internet of Things-IoT) юм. Урьд нь интернетэд зөвхөн хүн л холбогддог байсан бол одоо бүх зүйл холбогддог болж байна. Алсын зайд байршиж байгаа төхөөрөмжүүд үүнд, орон сууцны хаалга, цонх, хөргөгч, галын систем зэрэг, бизнесийн хэрэглээнд машины арилжаа, зогсоолын сул талбайг тоолох, байгууллагын цагийн систем, гэрэлгээд л холбогдож байна. Объектыг утасгүй интернетийн сүлжээгээр алсаас удирдана, эд зүйл эргээд мөн мэдээллээ

илгээнэ. Эсвэл гудамжинд явж байгаа бүх машинууд машинаас машин холболт (vehicle to vehicle communication)-оор 0.1 сек тутамд өөрийнхөө явж байгаа хурд, хурдатгал, байршлаа эргэн тойрны 200 метрт дамжуулдаг болно. Замын хажуугаар системүүд тавьснаар нэгдсэн төв дээр бүх машины мэдээлэл очно гэх мэтчилэн олон зүйл мэдээллээр хэмжигдэж, удирдагдах юм. Өнөө үед их хэмжээний мэдээлэл асар хурдацтай өсч байгаа бөгөөд үүнд одоогоор ашиглаж байгаа өгөгдлийн сан, мэдээлэл боловсруулах хэрэгслүүд хүчин чадлын хувьд хангалтгүй болсон байна. Их хэмжээний мэдээлэлтэй ажиллах, түүнд шинжилгээ хийхэд шинэ технологи, арга хэрэгслүүд шаардагдахын зэрэгцээ үүнд нийцсэн дэвшилтэт технологиуд ч гарсаар байна. Их хэмжээний өгөгдөлд ач холбогдол өгдөг салбар бол харилцаа холбооны салбар юм.

График 1. 14 2016- 2027 он гэхэд дэлхий даяар их өгөгдлийн орлого, томоохон сегментээр (тэрбум ам. доллар)



Энэ статистик нь 2016- 2027 он хүртэлх гол том сегментүүдээр дэлхийн томоохон мэдээллийн зах зээлийн орлогыг харуулж байна. 2018 онд мэдээллийн их өгөгдлийн програм хангамжийн зах зээл нь 14 тэрбум доллараар үнэлэгдэж байгаа бөгөөд зах зээл нийтдээ 42 тэрбум ам.доллар байх болно. Их өгөгдөлтэй холбоотой зарим баримтууд:

- Датаны багтаамж, хэмжээ эрс нэмэгдсэн. Сүүлийн хоёр жилд үүссэн датаны хэмжээ түүнээс өмнөх хүн төрөлхтний түүхийнхээ туршид бий болгосон датанаас илүү гараад байна.

- Датаны өсөлт маш их эрчимтэй явагдаж байгаа ба 2020 он гэхэд манай дэлхийн хүн бүр, секунд тутамд 1.7 мегабайт дата үүсгэж байхаар судалгаа гарчээ.
- Тэр үед өнөөгийн дижитал ертөнцийн нийт дата 4.4 Зеттабайтаас 44 Зеттабайт буюу 44 их наяд Гигабайт болж нэмэгдэнэ.
- Бид секунд бүрт шинэ дата үүсгэж байдаг. Жишээ нь бид секунд бүрт 40,000 хайлт хийдэг (зөвхөн Google), ингэснээр жилд 1.2 их наяд хайлтад хүрч байгаа юм.
- 2015 оны наймдугаар сард, анх удаа 1 тэрбум хүн нэг өдөр Фэйсбүүкт орсон байна.
- Фэйсбүүк хэрэглэгчид минут тутамд дунджаар 31.25 сая мессэж илгээж, 2.77 сая видео үзэж байна.
- Видео болон фото контентын хэрэглээ үсрэнгүй нэмэгдэж YouTube сүлжээнд минут бүрт 300 цагийн видео бичлэг нэмэгдэж байна.
- 2015 оны дүнгээр, дэлхий дээр 1 их наяд фото зураг үүсгэгдэн, тэдний олон тэрбум нь онлайн сүлжээнд тавигдаж байна. 2017 онд нийт фотоны 80 хувь нь ухаалаг утсаар үүсгэгдэх болно.
- Энэ жил 1.4 тэрбум ухаалаг гар утас үйлдвэрлэгдэж зах зээлд хүрсэн ба тэдгээр нь бүгд бүх төрлийн дата бүрдүүлэх мэдрэгчүүдтэй гарч байна. Үүнд хэрэглэгчийн өөрийн гараар үүсгэх датаг тооцоогүй болно.
- 2020 онд 6.1 тэрбум ухаалаг гар утасны хэрэглэгч манай дэлхий дээр бий болно.
- Ирэх таван жилийн хугацаанд манай дэлхий дээр 50 тэрбум ухаалаг төхөөрөмж бий болж төрөл бүрийн дата цуглуулах, шинжлэх, дамжуулах үүрэгтэй ажиллах болно.
- 2020 онд бүх датаны гуравны нэг нь Клоуд орчинд хадгалагдана.
- Төвлөрсөн биш (distributed) тооцоолох арга бодит хэрэглээ болно. Google-ын нэг хайлтын хүсэлтэнд 0.2 секундээс богино хугацаанд хариу өгөхийн тулд 1,000 компьютер зэрэг боловсруулалт хийдэг.
- Ийм тооцоолох аргад зориулагдсан нээлттэй эхийн Hadoop програмын эрэлт жил бүр 58 хувь нэмэгдэж 2020 он гэхэд \$1 тэрбумын зах зээлтэй болохоор байна.
- Big Data-г зөв ашигласнаар өнөөдрийн эрүүлийг хамгаалах салбар жилд \$300 саяыг хэмнэх боломжтой. Энэ нь эрэгтэй, эмэгтэй, хүүхэд зэрэг хүн бүрийн эрүүл мэндийн зардлыг жилд \$1,000-аар бууруулсантай дүйцэхээр байна.
- Цагаан Ордон одоогоор нийт \$200 саяыг Big Data төслүүдэд оруулаад байна.
- Өнөөдрийн байдлаар үүсч байгаа нийт датаны дөнгөж 0.5 хувь нь боловсруулагдаад байгаа нь энэ шинэ салбар хэр их ирээдүйтэйг харуулж байна.

Монголын бизнесийн төлөөлөгчдийн үзсэнээр Big Data төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд энэ талын мэдлэгтэй маркетер, менежер болон шинжээч зэрэг мэргэжилтнүүд хангалтгүй байдаг гэжээ. Үнэндээ гүнзгий нарийн, эсвэл урьдчилан таамаглах шинжилгээ хийж буй эдгээр мэргэжилтнүүдийн ажлын чанараас Big Data

төслүүдэд оруулж буй хөрөнгө оруулалтын үр өгөөжийг олох хурдац шууд хамаардаг. Бизнес компаниуд Big Data төслүүдийг нэвтрүүлэхэд нарийн хэцүү гэж үзэхээс гадна хүрсэн үр дүнг үнэлэх, цуглуулсан мэдээллийн үнэ цэнийг мэдэхэд төвөгтэй гэж харж байна. Хэдийгээр хүндрэлүүд байгаа ч Gartner-ын судалгаагаар 2012 онд дэлхийн томоохон компаниудын 58% нь Big Data төслүүдэд хөрөнгө оруулалт хийж байсан бол энэ тоо 2013 онд 68% болж өсчээ. Big Data төслүүдийг нэвтрүүлж буй компаниудад харилцаа холбоо, банк, үйлчилгээний салбарын тэргүүлэх компаниуд орсон байна.


Их хэмжээний өгөгдөлтэй ажиллах дэд бүтцийг байгуулах, түүнд тулгуурласан хэрэглээг хөгжүүлэхийн тулд мэдээллийн технологийн болон боловсролын салбарт хөгжлийн урт хугацааны, тууштай бодлого баримтлах нь зүйтэй байна. 2018 онд мэдээллийн аюулгүй байдлын олон улсын байдлын судалгаагаар (GSISS), автоматжуулалт болон робот ашигладаг байгууллагуудын удирдагчид мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь өндөр ач холбогдолтой бөгөөд кибер халдлагад өртөмтгий гэжээ. 2018 оны судалгаанд хамрагдсан 122 орны 9,500 гаруй гүйцэтгэх захирлуудын 46 хувь нь мэдээллийн ерөнхий аюулгүй байдлын стратеги байхгүй гэжээ. 48 хувь нь ажилчдын аюулгүй байдлын мэдлэг олгох сургалтын хөтөлбөр байдаггүй, 54 хувь нь хариу үйлдэл үзүүлэхгүй гэсэн байна. "Олон тооны байгууллагууд өөрсдийн дижитал эрсдэлийг үнэлж, зайлшгүй шаардлагатай үед уян хатан байдлыг бий болгоход анхаарлаа төвлөрүүлэх шаардлагатай байна" гэжээ

## ДӨРӨВ. ХӨДӨЛГӨӨНТ БАЙДАЛ

Монголд гэхэд хүн амын 70 орчим хувь нь интернэт ашигладаг гэсэн судалгаа байдаг. Үүнийгээ дагаад бизнес эрхлэгчид онлайн систем рүү шилжиж үйл ажиллагаагаа онлайнгаар явуулж, зар сурталчилгаа, рекламаа цахим хуудсуудад тавих хандлага нэмэгдсээр байна. Утасгүй хөдөлгөөнт сүлжээний ерөнхий зорилго нь утсан сүлжээний хязгаарлагдмал байдлаас ангижирч утсан сүлжээ байрших боломжгүй хэсэгт хямд зардлаар интернэтийн эрх чөлөөг эдлэх юм. Утасгүй сүлжээ нь агаараар өгөгдлийг дамжуулах, хүлээн авдаг ба үүндээ радио давтамжийн технологийг ашигладаг. Өнөөдөр хүн бүр өөрийн гэсэн компьютер ухаалаг утсаараа утасгүй сүлжээгээр дамжуулан интернэтэд холбогдох боломжтой болжээ.

2019 он гэхэд дэлхий даяар ХХМТ-ийн зах зээл, үүнд ТВ болон видео үйлчилгээнүүд үнэ цэнэтэй байх болно гэж таамаглаж байгаа ба нийт үнэ цэнэ нь 4.4 их наяд еврогоос илүү байна .

График 1. 15 Дэлхийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын 2005-2019 оны орлого (тэрбум евро)




МТ-ийн үйлчилгээний зах зээлд бизнесийн үйл ажиллагааны үйлчилгээ, хэрэглээний үйлчилгээ, дэд бүтцийн үйлчилгээ ордог бөгөөд тэдгээрийн ихэнх нь аутсорсинг үйлчилгээ үзүүлдэг компаниудад байдаг. 2017 онд аутсорсинг үйлчилгээгээр дэлхий даяар 88.9 тэрбум ам.доллар зарцуулсан байна. МТ-ийн аутсорсинг хийхэд зориулагдсан томоохон зах зээл нь эрүүл мэндийн салбар бөгөөд 2015 онд дэлхийн хэмжээнд 40 тэрбум доллараар үнэлэгдэж байжээ. Энэтхэгийн Тата Зөвлөх (Tata Consultancy Services) үйлчилгээний компани нь энэ чиглэлийн дэлхийн хамгийн том үйлчилгээ үзүүлэгч байгууллага бөгөөд 2015 онд ойролцоогоор 14,5 тэрбум АНУ-д долларын орлогыг олж байжээ.

2018 онд ИТ үйлчилгээний зарлага нь дэлхий даяар нийтдээ 987 тэрбум доллар байсан. Дэлхий даяар мэдээллийн технологийн өргөн хэрэглээний зах зээл 2017 онд 3.5 их наяд ам.долларт хүрсэн ба нийт зах зээлийн дөрөвний нэгээс илүү хувийг ИТ үйлчилгээнд зарцуулсан байна. МТ-ийн зах зээлийн өсөлтийн хувьд үйлчилгээнүүд тогтвортой өсөж байгаа ба аж ахуйн нэгжийн програм хангамжийн зарцуулалтын өсөлт мөн нөлөөлж байна. Өнгөрсөн жилийнхээс ИТ үйлчилгээний зардлыг 5.5 орчим хувиар нэмэгдүүлнэ гэж тооцоолж байна.



График 1. 16 2010-2022 онуудад (сая нэгжээр) tablets, зөөврийн компьютер, ширээний PC-ийн тээвэрлэлтийн урьдчилсан мэдээ




Энэ статистик нь 2010-2017 он хүртэлх tablet, зөөврийн компьютер, ширээний компьютерийн тээвэрлэлтийн тоон мэдээллийг харуулж байна. 2022 онд 134,1 сая tablet-ийг дэлхий даяар тээвэрлэхээр төлөвлөж байна. Credit Suisse компанийн хийсэн судалгаагаар зөөврийн компьютерийн тээвэрлэлт тогтмол буурч байна гэжээ. Зөөврийн компьютеруудаас олсон орлогын хэмжээ 2010 оны оргил үеэс эхлэн буурч байгаа нь зөөврийн компьютерийн дундаж үнэ буурсантай холбоотой. Өмнөх тооцоогоор 2015 он гэхэд зөөврийн компьютеруудын борлуулалтын дундаж үнэ 2005 онтой харьцуулахад 65 хувиар буурсан байна. Үүний зэрэгцээ, таблет-н зах зээл хурдацтай өсөхийн хэрээр ширээний компьютерийн сегмент ирэх хэдэн жилийн хугацаанд нэр хүнд алдагдах төлөвтэй байна. Суурин компьютерийн борлуулалт 2016 онд ачуулсан 134 сая ширхэгээс буурах төлөвтэй байна. 2015 онд дэлхийн хүн амын 13.8 хувь нь таблет төхөөрөмжтэй байсан бөгөөд энэ нь 2018 он гэхэд бараг 18 хувиар өсөх төлөвтэй байна.

Дэлхийн МХТ-ийн салбарын зардал 2018 онд 4.57 их наяд ам.долларт хүрсэн бөгөөд 2022 он гэхэд 6 их наяд ам.доллараар өсөх төлөвтэй байна. 2021 онд санхүүгийн үйлчилгээний компаниудын мэдээллийн технологийн зарлага 500 тэрбум доллар хүрэх төлөвтэй байна. Нийт салбарын зардлын 3,99 их наяд долларын зарцуулалт нь уламжлалт ИТ технологи (үүл, хөдөлгөөнт, нийгмийн болон аналитик) бол бусад шинэ

технологуудаас үүсэлтэй 830 тэрбум долларыг IoT болон робот / drone-нисгэгч технологийн салбарт зарцуулна гэсэн тооцоолол хийжээ.

ХХМТ-ийн зардал 2018 онд 4.81 их наяд ам. долларт хүрч, харилцаа холбооны салбарт 1.43 их наяд нь, МТ-ийн үйлчилгээний салбарт 1 их наяд зарцуулна .

График 1. 17 ХХМТ-ийн салбарын нийт технологийн зардал (ам. доллар)



2014-2019 оны дэлхийн технологийн зах зээлийн зарцуулалт: 2018 онд дэлхийн технологийн зарцуулалт 3,212 тэрбум ам.доллор байна. Дэлхийн технологийн зах зээл нь харилцаа холбооны үйлчилгээ, технологийн аутсорсинг, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, технологийн зөвлөгөө, системийн интеграцийн үйлчилгээ, програм хангамж, харилцаа холбооны тоног төхөөрөмж, компьютерийн тоног төхөөрөмж зэргээс бүрдэнэ.


2021 онд санхүүгийн үйлчилгээний компаниудын мэдээллийн технологийн зардлаас хамгийн өндөр хувийг банкны салбарын мэдээллийн технологийн зарцуулалт эзэлж байгаа бөгөөд 288 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна.

#### **2017-2018 оны Ази Номхон далайн бүсийн технологийн зах зээлийн төлөвлөлт**

Бүс нутгийн технологийн зарцуулалт 2017 онд дунд хугацааны өсөлтийг харуулах бол 2018 онд бараг 6% -ийн өсөлттэй байна. Ази Номхон Далайн бүсийн хувьд ерөнхийдөө төлөв нь технологийн болон бараа үйлчилгээний салбарт зарцуулах бизнесийн болон засгийн газрын зардлыг орон нутгийн валютаар 2017 он гэхэд 3.3%, 2018 онд 5.7% -иар өснө гэж таамаглаж байсан. Ази номхон далайн бүсийн технологийн худалдан авалт 738 сая ам.доллар бөгөөд 2016 оныхоос 5.5 хувиар өссөн. Ази номхон

далайн бүсийн технологийн бараа үйлчилгээний засгийн газар болон бизнесийн салбарын худалдан авалт

Ази Номхон Далайн бүсийн техник тоног төхөөрөмжийн, үйлчилгээний худалдан авалт (ам.доллар)



Програм хангамж, үйлчилгээний үзүүлэлт 2017 онд тогтмол байсан бол 2018 онд 5.7% - д хүргэнэ.

Ази Номхон далайн бүсийн техникийн бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалт

	2013	2014	2015	2016*	2017*	2018*
Computers and peripheral equipment	5%	4%	5%	1%	3%	6%
Communications equipment	10%	9%	8%	0%	2%	6%
Software	2%	3%	4%	7%	7%	8%
Tech consulting services	0%	3%	2%	7%	7%	7%
Tech outsourcing	3%	5%	3%	8%	8%	7%
Hardware maintenance	-1%	0%	1%	0%	-1%	2%
Telecommunications services	10%	6%	8%	-1%	0%	4%
<b>Total tech purchases without telecom</b>	<b>5.5%</b>	<b>5.1%</b>	<b>5.6%</b>	<b>2.2%</b>	<b>3.3%</b>	<b>5.7%</b>

Эх сурвалж: Forrester forecast


Япон улс нь технологийн салбарын хамгийн том зах зээл хэвээрээ байгаа хэдий ч бусад орон мөн хурдан өсөлттэй байна. Ази Номхон Далайн орнуудын томоохон зах зээлүүдийн нэг нь технологийн салбар бөгөөд эдгээр улсуудын эдийн засгийн өсөлтийг харуулах хандлагатай байна. Гэхдээ технологийн зах зээлийн хэмжээ, бүтцийг эдийн засгийн байдал, технологийн үр ашгийн түвшнээр тодорхойлно.

Австрали, Япон, Сингапур, Өмнөд Солонгос зэрэг улсууд өндөр хөгжилтэй эдийн засагтай бөгөөд бизнесийн болон засгийн газрын үйл ажиллагаанд технологийн хэрэглээ ихтэй байдаг. Эдгээр орнуудад технологийн зарцуулалт ДНБ-ний 3% -иас илүү хувийг эзэлж байна. Сингапураас бусад Хятад, Зүүн өмнөд Азийн Үндэстнүүдийн Холбоо (АСЕАН) улс орнууд эдийн засаг нь хөгжөөгүй ба технологийн үр ашгийн түвшин өндөр биш байна.

Японы удаан өсөлттэй технологийн зах зээл нь Ази тивийн хамгийн томд тооцогддог боловч энэ нь урт удаан хугацаанд үргэлжлэхгүй юм. Япон улс 2017 онд 248 тэрбум ам.долларыг технологийн бараа, үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөжээ. Энэ бүсийн орнуудтай харьцуулахад хамгийн өндөр зарцуулалт байжээ. Дотоодын томоохон ханган нийлүүлэлт нь технологийн үйлчилгээ үзүүлэгчдэд шинэ орлогын урсгалыг бий болгож, робот, автоматжуулалтаар дамжуулан үйлчлүүлэгчиддээ үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах төлөвтэй байна. Техникийн аутсорсинг нь ойролцоогоор 3% -иар өсөх ба Японы технологийн зах зээлийн хамгийн том хэсэг хэвээр байх болно; 2018 онд технологийн зөвлөх үйлчилгээ 2% -иас 3% хүртэл өснө. Програм хангамжийн зардал бага зэрэг нэмэгдэх ба компьютер, харилцаа холбооны тоног төхөөрөмжид зарцуулах зарцуулалт буурч, цахилгаан холбооны зардал жигд өсөлттэй байна.

АНУ-ын харилцаа холбооны үйлчилгээ нь тус улсын МТ-ийн зах зээлийн 30 хувийг төлөөлнө гэж үзэж байна. Дэлхийн мэдээллийн технологийн зах зээл дээр харилцаа холбооны үйлчилгээний зарцуулалтыг 41% -д хүргэнэ гэж таамаглаж байна.

#### АНУ-д мэдээллийн технологийн зах зээлийн гол сегментүүд, 2015-2016





Эх сурвалж: IDC; CompTIA

АНУ-ын Холбооны Засгийн газрын мэдээллийн технологийн зарлага өсч байна. 2011-2014 онуудад нийтдээ \$ 73- \$ 76 тэрбум ам.доллар зарцуулсан бол 2015 онд 80 тэрбумыг зарцуулсан байна. 2017 оны төсвийн жилд засгийн газар нь МТ-ийн зарцуулалтад 81.6 тэрбум доллар төсөвлөжээ.

2016 оны байдлаар дэлхийн нийгмийн сүлжээний ашиглалтын үзүүлэлтээр Исланд, Новеги, Англи зэрэг орнууд эхний 3 улсад эрэмбэлэгдэж байсан бол мэдээллийн технологийн ашиглалтын үзүүлэлтээр Сингапур, Финлянд, Швед улсууд эхний байрыг эзэлж байжээ. (Эх сурвалж: Дэлхий эдийн засгийн форум 2016 /139 орон хамрагдсан)

**Монголын ХХМТ-ийн салбарын хөгжлийн үзүүлэлтийг олон улсын болон Ази, Номхон далайн бүсийн зарим орнуудтай харьцуулан судалж үзвэл:**


2016 онд Математик, шинжлэх ухааны боловсролын чанарын үзүүлэлтээр Тажикистан, Турк, Хятад зэрэг улсуудтай харьцуулахад харьцангуй өндөр буюу 4.71 гэсэн үзүүлэлттэй байна [1 = туйлын муу, хамгийн чанар муу; 7 = маш сайн, дэлхийн хамгийн шилдэг нь].




Математик, шинжлэх ухааны боловсролын чанарын ранкаар Тажикистан 2012-оос 2016 он хүртэлх математик, шинжлэх ухааны боловсролын чанарын зэрэглэлээр 139 улсаас 41, Монгол улс 34-р байранд орсон. 2016 онд математик, шинжлэх ухааны

боловсролын чанарын зэрэглэлээр Сингапур 1-т орсон бол Өмнөд Африк нь хамгийн муу буюу 139-р байранд оржээ.

Боловсролын тогтолцоо өрсөлдөөнт эдийн засгийн хэрэгцээг хангаж байна уу? гэсэн үзүүлэлтээр 2016 онд Зүүн Ази, номхон далайн орнуудаас Хятад улс нь 3.92, Монгол 3.04 үзүүлэлттэй байсан бол, сонгогдсон улс орнуудын дотор Малайз нь 5.44 индекс (1-7) -д хамгийн өндөр үзүүлэлттэй байхад Мьянмар нь 2.55 индекс (1-7) -д хамгийн бага үзүүлэлттэй байна.




Боловсролын системийн чанараар 2016 онд Монгол улс 139 орны 111-т жагсаж байна. Швейцарь 1-т ордог бол Парагвай улс хамгийн бага нь 139-т бичигджээ.




### ХХМТ-ийн салбарт дэмжлэг үзүүлдэг засгийн газар

2016 онд Монгол улс нь МХХТ салбарт дэмжлэг үзүүлдэг гэсэн үзүүлэлтээр 4.18 байсан бол Ази, номхон далайн бүсийн орнуудаас Малайз 5.79 буюу хамгийн өндөр үзүүлэлттэй, Мьянмар улс 2.99 буюу хамгийн бага үзүүлэлттэй байна.



2016 онд Арабын Нэгдсэн Эмират улс нь ХХМТ-ийн салбарыг дэмжих байдлаараа 1-р байранд жагсаж, Венесуэл улс нь хамгийн муу буюу 139-т жагссан. Монгол улсын хувьд 139 улсаас 56-д жагсаж байжээ.



Сүлжээний бэлэн байдлын индекс

Энэ үзүүлэлт нь хүрээлэн буй орчин, боловсрол, эрчим хүчний хэрэглээ, эрүүл мэндийн дэвшил, иргэний идэвхитэй оролцоонд үзүүлэх нөлөө зэргээс шалтгаалан ХХМТ-ийн хөгжилд эерэгээр нөлөөлж буй байдлыг үнэлэх зорилготой юм. Мөн энэхүү индекс нь боловсролын салбарт ХХМТ-ийг ашигласнаар гарч болох боломжит үр ашгийг ямар хэмжээнд байгааг үнэлдэг /2016 оны байдлаар/.

<b>RANK</b>		<b>VALUE</b>
1	Сингапур	6.2
2	Араб	6.1
3	Нидерланд	6.1
4	Өмнөд солонгос	6.0
5	Англи	5.9
6	Истони	5.9
7	Америк	5.7
8	Норвеги	5.7
9	Австрали	5.7
10	Катар	5.6
57	Монгол	4.3

Энэ үзүүлэлт нь патент, шинэ бүтээгдэхүүн түүний үйл явц, зохион байгуулалтын хэв маягийн хэлбэрт технологийн болон технологийн бус шинэчлэлийг бий болгож чадсанаар МХТ-ийн өрсөлдөх чадвар хэрхэн өөрчлөгдөхийг үнэлдэг. Үүнээс гадна эдийн засгийг ерөнхийд нь хэрхэн эрчимтэй болгож буйг хэмжинэ.

<b>RANK</b>		<b>VALUE</b>
1	Финлянд	6.2
2	Швецарь	6.1
3	Швед	6.1
4	Израйл	6.0
5	Сингапур	5.9
6	Нидерланд	5.9
7	Америк	5.7
8	Норвеги	5.7
9	Люксембург	5.7
10	Герман	5.6


Сүүлийн үеийн шинэ техник технологи ашиглах боломжийн индексээр Финлянд улс тэргүүлдэг бөгөөд Монгол улс нь 139 орноос 88-д эрэмбэлэгдэж байна.



RANK		VALUE
1	Финлянд	6.2
2	Америк	6.1
3	Норвеги	6.1
4	Швед	6.0
5	Англи	5.9
6	Исланд	5.9
7	Швецарь	5.7
8	Израйл	5.7
9	Араб	5.7
10	Нидерланд	5.6

Дэлхийн эдийн засгийн форууаас гаргадаг Дэлхийн мэдээллийн технологийн тайланд дурдсанаар харилцаа холбоо, мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтаас эдийн засагт үзүүлэх нөлөөллөөр Финланд, Швейцарь, Швед, Израиль, Сингапур, Нидерланд, АНУ зэрэг улсууд тэргүүлж байна. Эдгээр долоо нь ХХМТ-ийг эртнээс хэрэгжүүлсэн бөгөөд энэ салбарын эдийн засгийн ач холбогдлыг сайтар ойлгодог ба ХХМТ-ийг үр дүнтэй болгох явдлыг гол чиг баримжаагаа болгодог.

Хүснэгт 4. 2 Дижитал эдийн засаг ба нийгмийн индекс (DESI)




Эх сурвалж: DESI report 2018-Human capital

2018 оны Дижитал эдийн засаг ба нийгмийн индексээр Финлянд, Нидерланд, Швед, Их Британи, Люксембург, Дани зэрэг улсууд хамгийн өндөр оноо авсан. Румын, Болгар, Грек, Итали улсууд хамгийн бага үзүүлэлттэй харагдаж байна. "DESI"-ийн шалгуур үзүүлэлт нь "үндсэн ур чадвар, хэрэглээ", "дэвшилтэт ур чадвар, хөгжил" гэсэн хоёр дэд хэмжүүртэй. 2017 оны мэдээллээс үзэхэд Нидерланд, Швед, Люксембург нар үндсэн ур чадвар, хэрэглээний хэмжүүрээр шилдэг юм. Финлянд, Ирланд, Швед, Их

Британи улсууд нь хөгжлөөрөө хамгийн өндөр буюу дэвшилтэт ур чадвар, хэрэглээний үзүүлэлтээр шилдэг нь юм. Мөн 2017 онд Европын нийт хүн амын 81% нь долоо хоног бүр, 72% нь өдөр бүр буюу тогтмол интернет хэрэглэдэг байсан бол үүнийг жилийн өмнөхтэй харьцуулбал 79%, 71% -тай байжээ. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү интернет хэрэглэдэг (хамгийн багадаа долоо хоног: 82% vs. 79%, өдөр бүр эсвэл бараг: 74% vs. 71%), ялгаа улам багасах хандлагатай байна.


Боловсролын түвшин доогуур, бага орлоготой хүмүүс, ахмад настан, тэтгэвэрт гарсан эсвэл идэвхи багатай хүмүүс харьцангуй бага интернет хэрэглэдэг. Гэвч эдгээр бүлгүүдийн интернетийн хэрэглээ нэмэгдэх хандлагатай байна.



2017 онд ЕХ-ны хүн амын 43% нь дижитал ур чадварын түвшин хангалтгүй байсан. 17% нь бага эсвэл огт интернет хэрэглэдэггүй байсан. Энэ нь 2016 онтой харьцуулбал 2 пунктээр сайжирсан гэсэн үг юм. Мөн дижитал ур чадварын түвшин нь хөдөөд (49%) буюу хотын оршин суугчидтай (63%) харьцуулахад харьцангуй бага байна. ЕХ-ы гишүүн орнуудын хувьд энэ үзүүлэлт ялгаатай хэвээр байна. Болгар, Румын улсуудад 29% байхад Люксембург хотод 85%, Нидерландад 79% гэсэн үзүүлэлттэй байна.

2017 онд ЕХ-ны ажиллах хүчний 10% нь дижитал ур чадваргүй байсан бөгөөд тэдний дийлэнх нь интернэт ашигладаггүй байсан байна. 35% нь ажлын байранд тавигдах наад захын дижитал ур чадварыг эзэмшээгүй байжээ.

Digital skills of the EU labour force, 2017 (% individuals, by skills level)\*



Source: Eurostat

■ No skills or no internet use ■ Basic ■ Low ■ Above basic

### Эх сурвалж: DESI-н тайлан 2018 - Хүн капитал

ЕХ-ны идэвхитэй ажиллах хүчний (ажил эрхэлдэг, ажил эрхэлдэггүй) тоон ур чадваргүй хүний тоо 2016 онд 11% байснаа 2017 онд 10% болж буурсан байна. Румын (26%), Болгар (25%), Португал (18%) зэрэг гишүүн орнуудад харьцангуй өндөр хувьтай байгаа нь өнгөрсөн оныхтой харьцуулахад хамгийн их сайжирсан үзүүлэлт юм. Нөгөөтэйгүүр Люксембург, Нидерланд, Финланд, Швед зэрэг орнуудад ажиллах хүчний ихээхэн хэсэг нь (82%- 89%) дижитал тоон ур чадвартай, хагас буюу түүнээс дээш нь үндсэн ур чадвараас дээгүүр байна. Дижитал ур чадвар нь зөвхөн хөдөлмөрийн зах зээлийг үнэлэхэд нөлөөлөх төдийгүй шинээр гарч ирж буй техник технологийн давуу талыг ашиглахад чухал ач холбогдолтой юм.

ЕХ-ны ICT салбарын мэргэжилтнүүдийн хөдөлмөр эрхлэлт 2015-2016 оны хооронд 500,000-аар өсч, 8.2 сая хүн ажилд оржээ. Гэсэн хэдий ч, ХХМТ-ийн мэргэшсэн ур чадварыг харгалзаагүй байна. Энэ нь нийт ажил эрхлэлтийн 3.7 орчим хувьтай тэнцэж байна. Эдгээр үзүүлэлтүүд өмнөх жилийнхээс (7.7 сая ба 3.5%) харьцуулахад сайжирсан нь сүүлийн жилүүдэд ажиглагдсан эерэг хандлага (2011-2016 оны хооронд) юм.

2016 онд ЕХ-д ажилласан бүх ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн 83 хувь нь эрэгтэйчүүд байсан бол бараг 62 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байсан. ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн тоо хамгийн их улсууд нь Их Британи (1.6 сая), Герман (1.5 сая), Франц (1.0 сая). 2016 онд ЕХ-ны улсуудын ААН-үүд ХХМТ-ийн чиглэлээр мэргэжилтэн ажилд авахаар эрэлхийлэхэд, 41% нь сул орон тоог нөхөхөд хүндрэлтэй байсан гэжээ. Сүүлийн жилүүдэд эерэг хандлага ажиглагдаж байгаа хэдий ч ЕХ-ны ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн эрэлт, нийлүүлэлтийн хоорондын зай улам бүр өргөжин тэлж байгаа ба ХХМТ-ийн мэргэшлийн чадавхын тал дээр дутуу хэвээр байна



### Дижитал эдийн засаг ба нийгмийн индекс 2018 - Үндсэн зарчим

Дани, Швед, Финланд, Нидерланд нь Европын холбооны хамгийн дэвшилтэт дижитал эдийн засагтай улсууд бөгөөд дараа нь Люксембург, Ирланд, Их Британи, Бельги, Эстони зэрэг улсууд багтана. Румын, Грек, Итали улсууд DESI дээр хамгийн бага үнэлгээг авсан. 2017 онд бүх гишүүн улсуудын DESI үзүүлэлт сайжирсан ба Ирланд, Испани улсууд хамгийн их хөгжсөн байна (ЕХ-ны дунджаас 3.2 ба дээрх улсууд бараг 5 оноонд хүрсэн). Дани, Португалийн хувьд өсөлт бага 2 буюу 2-оос доош оноотой байна.

### Дижитал эдийн засаг ба нийгмийн индексийн гол үзүүлэлтүүд-2018

**Холболт:** Холболтын чиглэлээр Голланд болон Дани улс хамгийн өндөр үзүүлэлттэй бол Грек, Хорват, Итали улсууд хамгийн муу гүйцэтгэлтэй байсан. Тогтмол өргөн зурвас нь Европод 98%, Европын айл өрхүүдийн 80% нь хурдан өргөн зурваст (хамгийн багадаа 30 Mbps) холбогдсон. Хамгийн багадаа 58% хүртэл хувь нь 100 Mbps өндөр хурдны холболттой байна. ЕХ-ны хүн амын дунджаар 91% 4G гар утасны сүлжээг ашигладаг. Өндөр хурдны хэрэглээг өргөжүүлж одоогоор нийт айл өрхийн 15% нь жилийн өмнөхөөс хоёр дахин их болж өссөн. Энэ тоог 2020 он гэхэд 50% -иас багагүй байлгах зорилттой байна.

**Хүний нөөц:** Хүний нөөцийн үзүүлэлтээр Финланд, Нидерланд, Швед хамгийн өндөр оноо авсан бол Румын, Болгар, Грек, Итали хамгийн бага оноо авсан. Европын нийт хүн амын 81 хувь нь тогтмол (наад зах нь долоо хоногт нэг удаа) онлайн ашиглаж байгаа ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 хувиар өсчээ. Евро бүсийн 43% нь дижитал үндсэн ур чадваргүй хэвээр байна. ЕХ нь Шинжлэх ухаан, технологи, инженер, математикийн (STEM) төгсөгчдийн тоогоор бага зэрэг сайжирсан байна (2015 онд төгсөгчдийн 1000 хүн тутмын 19,1 нь 20-49 насныхан байсан бол 2013 онд 18.4 байжээ).

2016 онд ЕХ-нд 8.2 сая ХХМТ-ийн мэргэжилтэн байгаа ба энэ тоо 3 жилийн өмнө 7.3 сая байсан.

Интернетийн хэрэглээ: Интернетийн хэрэглэгчдийн идэвхээр хамгийн өндөр нь Дани, Швед, Нидерланд улсууд юм. Харин хамгийн идэвхи муутай нь Румын, Итали, Болгар улсууд байна. Онлайнар мэдээ унших (72%), видео эсвэл аудио дуудлага хийх (46%), нийгмийн сүлжээ ашиглах (65%), онлайн худалдаа хийх (68%), онлайн банкны үйлчилгээ (61%) байсан ба сүүлийн хоёр жилд бага зэрэг өсөлттэй байна.

Дижитал технологийг ашиглалт: Технологийн интеграцийн хувьд Дани, Финлянд, Ирландад хамгийн дэвшилтэт, Румын, Польш, Болгар улсад хамгийн бага хөгжсөн. Европын бизнесийн салбарын тоон технологийг нэвтрүүлэх үйл явц эрчимтэй явагдаж байна. Тухайлбал: бизнесийн програм хангамж, цахим мэдээллийн солилцооны хэрэглээ ( 2013 онд 26%, 2017 онд аж ахуйн нэгжийн 34%), цахим нэхэмжлэх илгээх (2013 онд 10%, 2016 онд 18%) харилцагч, түншүүдтэйгээ хамтран ажиллах зорилгоор нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах(2013 онд 15% байсан бол 2017 онд 21%).

Дижитал төрийн үйлчилгээ: Дижитал төрийн үйлчилгээгээр ЕХ-ы шилдгүүд нь Финланд, Эстони, Дани улсууд байхад Грек, Унгар, Румын улсууд хоцорч байна. Европын онлайн төрийн үйлчилгээний чанар сайжирч өмнөх үнэлгээнээс 5 оноогоор нэмэгдсэн, бизнесүүдэд зориулсан үйлчилгээ 2, онлайн үйлчилгээний гүйцэтгэл 2 оноогоор тус тус нэмэгдсэн байна.

#### **4.2 Олон улсын ХХМТ-ийн салбарын хүний нөөцийн төлөв байдал**

Өнөө үед мэдээллийн технологийн хурдыг гүйцэх бодит шаардлага тулгарч байна. Гэхдээ зөвхөн тоног төхөөрөмж, системд найдаад орхих биш инженер мэргэжилтнүүд бэлтгэх шаардлагатай байна. ХХМТ-ийн хүний нөөц нь тоон технологид суурилсан инновацийн хөдөлгөгч хүч болдог бөгөөд орчин үеийн эдийн засгийн өрсөлдөх чадварын чухал хэсэг гэж үзэж болох юм. Хэдийгээр МТ-ийн мэргэжилтнүүд хөдөлмөрийн зах зээлд хэмжээний хувьд бага боловч ажил эрхлэлт нь сүүлийн 10 жилийн хугацаанд эдийн засгийн үйл явдлын давтамжтай харьцуулахад тэсвэртэй байсаар байна.

#### **Европ дахь харилцаа холбоо, мэдээллийн технологийн (ICT) мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээний сүүлийн үеийн байдал.**

Шинэ технологи, тоон технологийг нэвтрүүлэх нь ихэвчлэн "үйлдвэрлэлийн дөрөв дэх хувьсгал" гэж нэрлэгддэг ба хүмүүсийн амьдарч, ажиллах, бие биетэйгээ харилцах замаар нийгэмд нөлөө үзүүлдэг. ХХМТ-ийн салбар нь Европын Холбооны (ЕХ) хөдөлмөр эрхлэлтийн хэв маяг болон үйлдвэрлэлийн арга барилд чухал өөрчлөлт оруулж байгаа бөгөөд бодлого боловсруулагчид, судлаачид нь ХХМТ-ийн


мэргэжилтнүүдэд зориулсан ажлын байрны хөгжлийг судлах сонирхолтой байгаа бөгөөд улс орны давуу байдлыг ХХМТ-ий салбарын хөгжил тодорхойлно гэж үзэж байна.

Европын холбооны ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн тоо 2007 оноос хойш 36.1% - иар өссөн нь 2017 онтой харьцуулахад (3.2%)-р өссөн байна. 2017 онд ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн ихэнх нь эрэгтэйчүүд байсан ба эмэгтэйчүүдийн эзлэх хувь 17.2 хувь болж өмнөх жилийнхээс 5.3 пунктээр буурсан байна. 2017 оны байдлаар Европын холбооны ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн тавны гурав (62.3%) дээд боловсрол эзэмшсэн гэсэн судалгаа байдаг.

### Европын холбооны улсуудын ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн тоо

2017 оны судалгаагаар 8.4 сая хүн Европын холбооны /ЕХ/ 28 улсад ХХМТ-ийн мэргэжлээр ажиллаж байжээ. Хамгийн их тоо буюу 1,6 сая мэргэжилтэн нь Английн Нэгдсэн Вант Улсад ажилладаг бөгөөд энэ нь ЕХ-28-ийн ХХМТ-ийн салбарын нийт ажиллах хүчний тавны нэг буюу 19.4% юм. Герман 1.6 ( 18,6% ) сая буюу хоёр дахь томоохон хүний нөөцтэй улс юм. Мөн ЕХ-28 улсын ХХМТ-ийн мэргэжилтнүүд бүхэлдээ дэлхийн нийт ажиллах хүчний 3.7 хувийг эзэлж байсан.

ЕХ-ны улсуудын ХХМТ-ийн салбарын мэргэжилтнүүдийн эзлэх хувийг дэлхийн нийт ажил эрхлэлттэй харьцуулсан хувь



Эх сурвалж: Eurostat


Дэлхийн нийт ажиллах хүчний тоотой харьцуулахад Финланд нь нийт ажилчдын хамгийн өндөр хувийг эзэлдэг ба 368.2 мянга нь нийт ажиллагсдын 6.8% - ийг, дараа нь Швед улсад 333 буюу дэлхийн нийт ажил эрхлэлтийн 6.6% -ийг эзэлж

байна. 2017 онд Эстони, Их Британи, Люксембург, Нидерланд зэрэг улсууд харьцангуй өндөр үзүүлэлттэй бүртгэгдсэн бөгөөд тус бүр нийт ажиллагсдынхаа дор хаяж 20 хүн тутмын нэг нь ХХМТ-ийн мэргэжилтэн байна гэжээ.

ЕХ-ы улсуудын ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээний ерөнхий өсөлт

Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд ЕХ-ы улсуудын ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн тоо дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үр дагавар, хөдөлмөрийн зах зээлийн байдалд сөргөөр нөлөөлсөн бөгөөд нийт ажил эрхлэлтэнд ХХМТ-ийн салбарын мэргэжилтнүүдийн эзлэх хувь 2007 онд 2.8%, 2017 онд 3,7% -иар буурчээ.


ХХМТ-ын мэргэжилтнүүд, 2007-2017



Эх сурвалж: Eurostat

ХХМТ-ийн салбарын ажиллагчдын тоо 2007-2017 он хүртэл 36.1 хувиар өссөн нь нийт ажил эрхлэлтийн хувьд (3.2%) өсөлттэй харьцуулахад 10 дахин их байна.

ХХМТ-ийн салбарын мэргэжилтэн, нийт ажил эрхлэлтийн хувь, ЕХ-28, 2007-2017



Эх сурвалж: Eurostat

ХХМТ-ийн мэргэжилтнүүдийг хүйсийн харьцаагаар авч үзвэл ЕХ-28-д МХХТ-ийн дийлэнх нь эрэгтэйчүүд байна. 2017 онд эрэгтэйчүүдэд ногдох ХХМТ-ийн хөдөлмөрийн зах зээлд эзлэх хувь 82.8 хувьтай байсан ба энэ нь 2007 онтой харьцуулахад 5.3 пунктээр өссөн байна. 2017 онд Унгар улсад 10 мэргэжилтэн тутмын 9 нь (91.1%), Чех улс (90.7%) нь эрэгтэйчүүд байв. ЕХ-ны гишүүдийн дийлэнх олонхид нь МХХТ-ийн 10 мэргэжилтэн тутмын 8 нь эрэгтэйчүүд ажиллаж байна.

Хүснэгт 4.3 ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн хүйс, боловсролын түвшин, нас, 2007-2017 он (хувиар)

	Distribution by sex				Distribution by education level				Distribution by age			
	Men		Women		Tertiary education		Non-tertiary education		15-34 years		35-74 years	
	2007	2017	2007	2017	2007	2017	2007	2017	2007	2017	2007	2017
<b>EU-28</b>	77.5	82.8	22.5	17.2	54.8	62.3	45.0	37.5	42.5	36.5	57.5	63.5
Belgium	84.1	81.8	15.9	18.2	76.5	75.7	23.5	24.3	41.2	34.0	58.8	66.0
Bulgaria	72.8	73.5	27.2	26.5	59.9	67.3	40.1	32.7	56.8	50.0	43.2	50.0
Czech Republic	70.3	90.7	29.7	9.3	33.2	55.9	66.8	44.1	46.2	38.4	53.8	61.6
Denmark	76.8	80.0	23.2	20.0	46.9	55.6	51.8	41.6	34.5	31.5	65.5	68.5
Germany	78.3	83.4	21.7	16.6	52.1	50.1	47.9	49.8	37.4	35.9	62.6	64.1
Estonia	63.6	80.6	36.4	19.4	53.8	58.8	46.2	41.2	51.5	52.8	48.5	47.2
Ireland	76.9	79.2	23.1	20.8	81.4	83.2	17.1	14.6	57.4	35.1	42.6	64.9
Greece	75.2	89.1	24.8	10.9	57.1	65.3	42.9	34.7	51.5	34.7	48.5	65.3
Spain	81.7	83.9	18.3	16.1	78.9	80.7	21.1	19.3	56.9	35.5	43.1	64.5
France	82.9	80.4	17.1	19.6	77.7	78.7	22.3	21.3	44.3	36.9	55.7	63.1
Croatia (*)	79.8	87.0	20.2	13.0	46.6	54.7	53.4	45.3	49.4	43.3	50.6	56.7
Italy	83.2	84.5	16.8	15.5	27.2	34.1	72.8	65.9	38.1	23.9	61.9	76.1
Cyprus (*)	78.1	85.4	21.9	14.6	85.9	81.6	14.1	18.4	66.6	43.5	33.4	56.5
Latvia	67.0	78.7	33.0	21.3	58.3	68.9	41.7	31.1	71.8	54.4	28.2	45.6
Lithuania (*)	70.8	74.3	29.2	25.7	58.2	63.4	41.8	16.6	42.9	53.7	57.1	46.3
Luxembourg	83.8	87.5	16.2	12.5	54.4	55.3	45.6	24.1	32.3	35.8	67.7	64.2
Hungary	67.1	91.1	32.9	8.9	39.4	63.6	60.6	36.4	49.8	35.5	50.2	64.5
Malta	77.3	89.4	22.7	10.6	30.2	54.2	69.8	45.8	63.0	60.1	37.0	39.9
Netherlands	84.6	83.4	15.4	16.6	52.6	59.6	47.1	40.1	37.4	34.7	62.6	65.3
Austria	78.3	84.4	21.7	15.6	37.7	63.2	62.3	36.8	47.3	40.9	52.7	59.1
Poland	68.3	85.2	31.7	14.8	54.3	70.6	45.7	29.4	57.1	51.0	42.9	49.0
Portugal	81.1	85.6	18.9	14.4	34.1	49.6	65.9	50.4	59.3	40.1	40.7	59.9
Romania	70.3	74.3	29.7	25.7	51.7	68.1	48.3	31.9	48.3	47.3	51.7	52.7
Slovenia	74.8	83.9	25.2	16.1	45.0	64.6	55.0	35.4	46.5	35.6	53.5	64.4
Slovakia	65.6	86.3	34.4	13.7	33.3	62.9	66.7	37.1	57.4	44.6	42.6	55.4
Finland	76.9	78.2	23.1	21.8	55.9	64.9	44.1	35.1	43.7	27.8	56.3	72.2
Sweden	79.0	79.1	21.0	20.9	44.7	58.6	55.0	41.1	34.1	31.4	65.9	68.6
United Kingdom	76.4	82.4	23.6	17.6	58.9	64.7	40.5	35.2	34.8	36.4	65.2	63.6
Iceland	75.4	83.6	24.6	16.4	46.1	61.3	53.6	38.7	39.7	42.3	60.3	57.7
Norway	84.7	80.5	15.3	19.5	60.9	63.2	39.1	36.8	37.1	31.8	62.9	68.2
Switzerland	82.4	85.0	17.6	15.0	58.0	63.7	41.9	36.2	44.7	36.2	55.3	63.8
Turkey	79.4	90.0	20.6	10.0	52.9	53.5	47.1	46.5	67.1	64.0	32.9	36.0

Эх сурвалж: Eurostat

2017 онд Болгарын эмэгтэйчүүдийн 26.5 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байсан ба энэ нь ЕХ-ы гишүүн орнуудын дунд хамгийн өндөр хувийг эзэлж байна. Мөн Румын, Литва. Мөн Финлянд, Латви, Швед, Ирланд, Дани зэрэг улсуудын МТ-ийн салбарын нийт ажиллагчдын дөрөвний нэгийг эмэгтэйчүүд эзэлж байна. 2017 онд Нэгдсэн Вант улс (286 мянга), Герман (258 мянга) -д эмэгтэй МХТ-ийн мэргэжилтнүүд ажиллаж байсан нь нь эмэгтэй ажил эрхлэлтийн хамгийн өндөр түвшин юм.

ЕХ-ны бус орнуудын дунд нийгдсэн судалгаагаар 2017 онд ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн дунд жендэрийн ялгавартай хандлагыг Туркт улсад бүртгэжээ (ХХМТ-ийн ажиллах хүчний 10.0 хувийг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд 90.0 хувийг эзэлж байв). Ажиллах хүчний жендэрийн хуваарилалт нь ЕХ-28-тэй харьцуулахад харьцангуй төстэй байсан бөгөөд Швейцарь, Исланд, Норвеги улсуудын МХТ-ийн мэргэжилтнүүд 85.0%, 83.6% 80.5 хувийг эрэгтэйчүүд тус тус эзэлж байна.




### МХТ-ийн мэргэжилтнүүд боловсролын түвшингээр

2017 онд ЕХ-28 дахь МХТ-ийн мэргэжилтнүүдийн тавны гурав (62.3%) нь боловсролын түвшин гуравдагч түвшинд /tertiary level/ хүрсэн байна (Зураг ). Боловсролын гуравдагч шатны ХХМТ-ийн салбарын мэргэжилтнүүдийн тоо 2007 онд 54.8% байсан ба сүүлийн арван жилд хамгийн их өссөн үзүүлэлт байна. Өөрөөр хэлбэл, 2007-2017 оны хооронд 7.5 пунктээр өссөн нь мэргэжилтнүүдийн боловсролын түвшин өндөр түвшинд хүрч байгааг харуулж байна. ЕХ-ны гишүүн орнуудын дунд ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн боловсролын түвшин дээгүүр орнуудад Литва, Ирланд, Кипр, Испани зэрэг орж байгаа ба энэ нь 5 хүн тутмын дөрөв нь дээд боловсролтой байна. 2007-2017 оны хугацаанд хийсэн шинжилгээний дүнгээр Словак, Австри, Литва, Унгар, Мальта, Чех зэрэг улсуудын боловсролын түвшин гуравдагч түвшний боловсролтой МХТ-ийн мэргэжилтнүүд 20 гаруй хувиар нэмэгдсэн байна. 2017 онд ЕХ-ны бус гишүүн орнуудын ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн дийлэнх нь гуравдагч шатны боловсролыг бүрэн эзэмшсэн бөгөөд Швейцарь (63.7%) хамгийн их хувийг эзэлж, Турк (53.5%) дээд боловсролтой хүмүүсийн хамгийн бага хувийг эзэлж байна.

### ХХМТ-ийн мэргэжилтнүүд насны бүлгээр

ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн насыг 15-34 насны хүн амыг 35-аас дээш насны хүмүүстэй харьцуулан судалсан. Хөдөлмөр эрхлэх дээд нас нь 74 жил байна гэж үзсэн. 2017 онд ЕХ-28 дахь МХТ-ийн мэргэжилтнүүдийн бараг гуравны хоёр (63.5%) нь 35-аас дээш насны хүмүүс ба ахмад насны бүлэгт МХТ-ийн мэргэжилтнүүдийн эзлэх хувь 2007-2017 онуудад 6.0 хувиар өссөн.

Зураг 7: ХХМТ-ийн мэргэжилтнүүдийн насны хуваарилалтаар, 2017 (%)



2017 онд ЕХ-ны гишүүн орнуудаас Итали (76.1%), Финланд (72.2%), Швед (68.6%), Дани улын 68.5%-ийг 35 болон түүнээс дээш насны бүлгийнхэн эзэлж байна. Үүний зэрэгцээгээр, Мальта, Балтийн гишүүн орнууд болон Польшид МХТ-ийн мэргэжилтнүүдийн дийлэнх нь 15-34 насныхан байсан. Гишүүн бус орнуудын дотор Турк улс 2017 онд 64.0% нь 15-34 насныхан байв. ЕХХБ-ын /Европын чөлөөт худалдааны нийгэмлэг/ гишүүн орнуудын ихэнх нь ЕХ-ны гишүүн орнуудад ажиглагдсанчлан МХТ-ийн мэргэжилтнүүд насны ангилалаар ижил төстэй загвар байсан бөгөөд 35- аас дээш насныхан 68,2%-ийг эзэлж байна.

**АНУ-д МТ-ийн салбар нь жижиг бизнесээс бүрддэг гэжээ. 2015 онд 375,000 IT салбарын компаниудын 97.7% нь 100-аас цөөн ажилтантай байжээ.**

### **4.3 ХХМТ-ийн салбарын үнэ цэнэ**

#### **4.3.1 Технологийн салбарын олон улсын дэвшил / эдийн засгийн салбараар/**

Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд мэдээллийн технологи дэлхий даяар эрчимтэй өөрчлөгдсөн. Өнөөдөр МТ нь бараг бүх салбаруудын үндсэн бүрэлдэхүүн хэсэг болж байна. Энэ салбар сүүлийн жилүүдэд хурдацтай өсч байгаа бөгөөд шинжээчдийн үзэж байгаагаар энэ өсөлт тогтвортой хэвээр байх төлөвтэй байна. Мянга мянган ажлын байрыг МТ-ээс бий болгосон бөгөөд өнөөдөр хүн бүр мэдээллийн технологи ач холбогдлыг өндөр болж, өнөөгийн амьдралын бүхий л талбарт чухал үүрэг гүйцэтгэж байна.

1820 оны үед хүн төрөлхтөн 35 орчим л насалж, дэлхийн нийт хүн амын 94 хувь нь нэн ядуу түвшинд амьдарч, 20%-аас ч бага нь бичиг үсэг тайлагдсан байв. Харин өнөөдөр хүн төрөлхтөн амьдрах хугацаагаа 70 ба түүнээс дээш жилээр таамаглаж, 80-аас дээш хувь нь бичиг үсэг тайлагдсан байна. Эдгээр хөгжил дэвшлийг технологигүйгээр төсөөлөх аргагүй бөгөөд технологи аж үйлдвэрлэлийн үеэс өнөөгийн мэдээллийн эринд ч үргэлжлүүлэн хөгжсөөр байна. Дэлхийг цаашид илүү ихээр өөрчилж, хүн төрөлхтний амьдралыг хялбарчлах олон гайхалтай технологиуд бий болно.

Нийгмийн салбарт салбарт гарч буй технологийн дэвшил

Хиймэл оюун ухаан: Хиймэл оюун ухаан нь сүүлийн 10 жилд шинэ алгоритмууд, дата цуглуулгын их өсөлт, компьютерийн хүчин чадлын нөлөөтэйгээр хурдтай хөгжиж буй юм. Хиймэл оюун ухаан (олон улсад AI хэмээн товчилдог бөгөөд цаашид AI гэж бичнэ) бүх л салбарт байх бүрэн боломжтой. Жишээлбэл, гэрэл зурагт AI техникийг урлагийн зориулалттайгаар нэвтрүүлснээр гэрэл зургийг өгөгдсөн уран зурагруу хувиргах боломжтой. “Google”-аас дата төвийг удирддаг хүчний систем AI-ийг үүсгэсэн бөгөөд ингэснээр эрчим хүчинд зарцуулдаг сая сая ам.долларыг хэмнэх боломжтой болжээ. “AI” нь хүмүүс биднийг байнга давтдаг оюун санааны үүргээс чөлөөлөх

чадвартай. Яг л аж үйлдвэрийн үе биднийг давтамж бүхий биеийн үүргээс (машин бидний ажлыг хийдэг болж эхэлсэн үе) чөлөөлсөнтэй ижил.

Зарим хүн AI хүний ажлыг булаана гэж санаа зовдог. Гэсэн ч түүхээ сөхвөл шинэ технологи ажлыг багасгаж оронд нь шинэ, бас орлох илүү дээр ажлуудыг бий болгосоор ирсэн байдаг. Жишээ нь: Хувийн компьютерийн дэвшлийн ачаар бичээчийн ажил үгүй болж, харин график дизайнерууд гарч ирнэ. Өнөөдөр сая сая хүн апп хөгжүүлэгч, ride-sharing жолооч нар (Uber-р жишээ авч болно), дроны оператор, нийгмийн сүлжээний маркетерүүд, гэх зэрэг арван жилийн өмнө байх нь атугай бий болсон байхыг нь төсөөлөхөд ч бэрх байсан ажлын байрууд бий болсон.

Виртуал ба бодит орчин: Компьютерийн процессор нь хүчин чадал ихтэй, хурдтай илүү итгэл үнэшил бүхий виртуал, эсвэл бодит байдлыг бий болгох боломжтой. Facebook, Google, Apple, Microsoft зэрэг компани VR, AR-ийг илүү тав тухтай, сонирхолтой, мөн боломжит болгохоор тэрбум тэрбум долларын хөрөнгө оруулалт хийж байна. Хүний нийгэм гараас гарт дамжсан аливаа харилцаан дээр хөгжиж ирсэн ч орчин үеийн харилцаа улам бүр зайнаас зай руу шилжин цахимжиж байна. Хүмүүс хязгааргүй хэрэглээгээ дэлхийн нөгөө өнцгөөс ч гэсэн хангадаг болжээ. Үүнтэй холбоотойгоор Virtual Reality буюу VR гэдэг ойлголт гарч иржээ. Энэ нь програм хангамжийн тусламжтай бүтээгдсэн хэрэглэгчидэд бодитой мэт харагдах хиймэл бодит орчин бөгөөд хүний харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүрэх гэсэн таван мэдрэхүйг бодит мэт мэдрүүлэхийг хэлнэ. ВВС-ээс виртуал бодит байдал-ын зарим хэрэглээг онцолсон байна. Тухайлбал :

Аутизмын ойлголт: Судлаачдын үзэж байгаагаар аутизмын талаар сонсож байсан хүмүүсийн дөнгөж 16% нь энэхүү өвчнийг юу болохыг мэддэг Англид аутизмтай 4 хүн дутмын нэг нь олон нийтийн газар очиж үзэхийг мөн тэнд бусад шиг ижил тэгш эрхтэйгаар байхыг хүсдэг. Тиймээс Английн Үндэсний Аутизмын Нийгэмлэгээс гадаад орчин бодит амьдралтай танилцахад нь зориулж аутизмтай хүмүүсд зориулсан тусгай кино энэ зун хийжээ. Үүний ачаар аутизмтай бяцхан хүү худалдааны төвөөр хөндлөнгийн хараа хяналтгүй, өөрийн мэдрэхүүндээ хөтлөгдөн бодит орчинд явж буй мэт мэдрэгжийг өгөх байдлаар нийгмийн харилцаанд орох боломжтой болж байгаа юм.

Виртуал бүтээгдэхүүн: Виртуал бодит байдал нь бүтээгдэхүүнээ борлуулах түгээмэл хэрэгслийн нэг болж байна. Жишээ нь: IKEA-аас бүрэн тавилагатай гал тогооны өрөөг виртуал бодит байдал-аар харах боломжтой аппликэйшн гаргасан байна. Хэрэглэгч өөрийн хүссэн өнгө дизайнаар тавилгын сонголт хийж бодит төсөөллийг авах боломжтой юм.

Виртуал мэс засал: Виртуал бодит байдлыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн томоохон салбар бол эрүүл мэндийн салбар юм. Мэс заслыг алсын зайнаас удирдах болон мэс засал хийхээс айдаг эмч нарыг бодит байдалд дасгах зорилгоор хэрэглэж

байна.Энэ нь мэс заслын эмчийг бэлдэх зардалыг багасгахаас гадна нэгэн зэрэг богино хугацаанд олон эмчийг хамруулж чадаж байгаа нь ирээдүйтэй бизнес төдийгүй эрүүл мэндийн салбарт гарсан томоохон шинэчлэлт болоод байна.

“Дэлхийгээс ангараг руу аялал” хийх виртуал аялал-ын программыг хийж, түүнийгээ аппликэйшн болгож [Google Cardboard](#) -оор ашиглах боломжтой байдлаар Google компани 2015 оны 9 сард Английн ерөнхий боловсролын сурагчдын хичээлийн хөтөлбөрт нэвтрүүлжээ. Үүгээр ч зогсохгүй технологийн энэ салбарт гарааны бизнесээ эхлүүлж буй компаниуд ирээдүйд хүүхдүүд боловсролыг бодит мэдрэмжээр хөгжилтэй байдлаар олж авна гэж үзэж байна.

Даяарчлагдсан эрин зууны хурд хүчинд “биет” мөнгө ч түрэгдэж, цаашид байх уу үгүй юу гэдэг дээрээ нэгэнт тулж ирэхэд ойртжээ. Мөнгө зөвхөн цаасаар эсвэл зоосоор илэрхийлэгдэхээ больж, сүлжээгээр урсаж, бас орлосон янз бүрийн төлбөрийн хэрэгслүүд гарч ирэх болжээ. Сүүлийн үед виртуал мөнгө гэх ойлголт манайд нэвтэрч эхэлсэн ба виртуал мөнгө гэдэг нь програм зохиогч, хөгжүүлэгчдийн гаргасан, виртуал орчинд ашиглагддаг, нэгдсэн зохицуулалтгүй, дижитал буюу тоон мөнгө юм. Одоогоор Монгол Улс энэ төрлийн мөнгийг хүлээн зөвшөөрч албан ёсоор баталгаажуулаагүй байна. Мөн Монгол Улсад виртуал мөнгөтэй холбоотой хууль, эрх зүйн аливаа зохицуулалт байхгүй учир виртуал мөнгийг эзэмшиж, ашиглахтай холбоотой эрсдэл үүсэж болзошгүй учраас иргэд энэ тал дээр хняуур хандаж байна. Хэдийгээр хөгжлийн шийдлүүд бидний хязгааргүй хүслийг хангахад оршдог ч нөгөө талдаа үүнээс болж хохирч болох эрсдэлүүд бий учраас виртуал мөнгөний харилцаанд болгоомжтой хандах хэрэгтэй аж. Виртуал мөнгө нь төлбөр, мөнгөн гуйвуулга зэрэг санхүүгийн үйлчилгээг хүргэх уламжлалт аргаас эрс ялгаатай. Энэ нь мөнгөн хөрөнгийг илүү хурдан, эдийн засгийн хэмнэлттэйгээр шилжүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой зэрэг давуу талтай мэт харагддаг.

Virtual Reality-гийн дараагын үе шат нь AR юм. Augmented Reality буюу AR гэдэг нь програм хангамжийн тусламжтай бүтээгдсэн аливаа графикыг бодит байдалтай хослуулсан хагас бодит орчин юм. Энэ нь ухаалаг утас, таблет, компьютер зэрэг төхөөрөмжийг ашиглан хэвлэмэл материалыг аудио, видео болон 3D хөдөлгөөнт дүрслэлээр баяжуулан харахад компьютерийн дүрслэлүүд нь бодит ертөнцийн нэг хэсэг болон харагддаг технологи юм. Ийм системүүд ялангуяа техник, технологи өндөр хөгжсөн улс орнуудад улам эрчимтэй нэвтэрч, өдөр тутмын өргөн хэрэглээ нь болж байна. Техник технологийн өндөр хурдацтай өнөөгийн хөгжлийг даган мобайл төхөөрөмжүүд нь улам хүчирхэгжиж хүмүүсийн бүхий л төрлийн хэрэглээг хялбарчилж байна. Гар утас ашигладаг нийт хүн амын 30 хувь нь долоо хоногт ядаж нэг удаа AR технологийг ашигладаг. Энэ байдлаараа 2017 он гэхэд 2,5 тэрбум гаруй AR програм татаж авсан бөгөөд тэдгээрийн дийлэнх нь тоглоом байжээ.

## Инженерийн салбарт гарч буй технологийн дэвшил

Өөрөө удирдлагатай машин: Өөрөө удирдлагатай машинууд нь хүн машиныг жолоодохоос илүү эрсдэл багатай гэгдээд байна. Дараагийн 3–5 жилийн хугацаанд эдгээр нь илүү аюулгүй, бас хүмүүс голчлон өөрөө удирдлагатай машиныг унахыг илүүд үзэх төлөвтэй. ДЭМБ-аас мэдэгдсэнээр жилд 1.25 сая хүн авто тээврийн ослоос үүдэлтэй шалтгаанаар нас бардаг байна. Тэдгээрийн тэн хагас нь явган хүн, унадаг дугуй, мотоцикл машинд мөргүүлсэн тохиолдол байдаг. Түүнчлэн 15–29 насны залуучуудын нас баралтын шалтгаан нь авто машины осол болдог.

20 дугаар зуунд машин бидний амьдралыг өөрчилсөнтэй адил өөрөө жолоодлоготой машин ч мөн адил 21 дүгээр зууны томоохон хувьслын нэг байх нь гарцаагүй. Ихэнхи тохиолдолд хотуудын ашиглах боломжтой зай талбайн 20–30 хувийг машиныг байрлуулахад ашиглачихдаг ба ихэнхи машиныг ашиглах хугацааны 95 хувь нь зогсоол дээр өнгөрдөг байна. Өөрөө жолоодлоготой машиныг цаг үргэлж хэрэглэх боломжтой (гар утасны аппликэшний тусламжтайгаар) буюу зогсоолын хэрэгцээг эрс бууруулна. Өөрөө удирдлагат машинууд бие биетэйгээ холбоотой байх бөгөөд ингэснээр осол аваар гарах эрсдэл, замын түгжрэл ч мөн багасна.

Супер нүдний шил: Фэйсбүүк компанийн ахлах судлаач Майкл Абрашийн үзэж байгаагаар өнөөдрийн хүмүүсийн зүүдэг шиг нүдний шил нь ирээдүйд хүчтэй тооцоолох машин болж, харсан текст бүрийг хэл хооронд орчуулж харуулдаг, орчны таагүй дуу чимээг дардаг, нялх хүүхэд рүү харахад л биеийн халууныг нь хэмжиж харуулдаг супер нүдний шил болох юм байна. VR (Virtual Reality) төхөөрөмж нь хүнийг тэс өөр ертөнцөд аваачдаг бол AR шил нь одоо байгаа гадаад орчин дээр виртуал мэдээллийг нэмж, хослуулж харуулдаг. 2022 оны дөрөвдүгээр сард AR (Augmented Reality) нүдний шилнүүд өнөөдрийн ухаалаг гар утаснуудыг бүрэн орлох эхлэл тавигдана.

5.	Оюунцэцэг	ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Утасгүй холбооны инженер	3	Эм	24
6.	Мөнххүлэг	ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Электрон системийн автомажуулалт	2	Эр	19
7.	Түвшинбаяр	ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Компьютерийн ухаан	3	Эр	20

8.	Мөнхтөгөлдөр	ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Компьютерийн ухаан	2	Эр	19
9.	Чинбаатар	ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Цахилгаан холбоо	3	Эр	20

**Модератор. Та энэ мэргэжлийг яагаад сонгосон вэ? Сонгосон шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс нь юу байсан вэ?**

Сумъяабэйс: Энэ мэргэжлийг сонгоход нөлөөлсөн хүчин зүйл нь бол эцэг эх. Анх сургууль төсөхөд улсын сургуульд ор гэдэг шаардлагыг тавьсан. Тухайн үед сонгосон хүссэн мэргэжил байгаагүй байсан. Тэгээд элсэлт авч эхлэхэд ШУТИС-ийн ангиудыг сонирхоход сүлжээний технологийн анги байсан. Энэ мэргэжлийг ирээдүйтэй юм болов уу гэж бодоод сонгосон. Өмнө нь энэ мэргэжлийн талаар мэдлэг, мэдээлэл байхгүй байсан.

Уянга: Гэр бүлийнхэн маань энэ мэргэжлийг сонго гэж зөвлөсөн. Энэ мэргэжил ирээдүйтэй, төгсөөд ажлын байр олдоно, цалин өндөр байдаг учраас сонго гэсэн. Би бол өөр мэргэжлээр сурна гэж төлөвлөөд шалгалтандаа тэнцсэн байсан боловч оруулаагүй. Эхний 1,2 курст бол энэ мэргэжлийг хичээлүүд огт таалагддаггүй, сонирхдоггүй байсан. 3 курст дадлага гараад манай мэргэжил чинь ямар гоё мэргэжил вэ гэж бодож эхэлсэн. Тэгээд л таалагдаад одоо бол сураад төгсөхөд болох юм шиг санагдаж байгаа.

Алтансүвд: Манай гэрийнхэн дунд цахилгааны инженер, барилгын инженер их байдаг байсан учраас инженер болъе гэж боддог байсан. Тэгээд улсын шалгалтанд тааруу оноо аваад хүссэн 2 мэргэжлийн маань босго оноонд хүрээгүй. Тэгээд судалсан. Анх холбооны сургууль гэж байдагыг ч мэддэггүй байсан. Тэгээд холбооны сургууль дээр ирээд 9 мэргэжлийн дундаас харж байгаад мэдээллийн систем гээд ерөнхий нэртэй ангийг нь сонгое гээд гэр бүлийнхэнтэйгээ ярилцаж байгаад орсон. 1,2 курсдээ сургуульдаа тийм ч их дуртай байгаагүй. 3 курсийн зун дадлагад гараад мөн мэргэжлийн хичээлүүд орж эхлэхэд сурах боломжтой санагдаад сурч байгаа. Төгсөөд ажиллах боломжтой байгууллагуудын талаар мэдээлэл аваад энэ мэргэжлээрээ сурч төгсөе гэж бодсон. Интерактив Би Ай ХХК дадлагад гарч байсан. Манай ангийнхан бүгдээрээ энэ байгууллагад дадлагад гарсан.

Цэндсүрэн: Аав ээжийн хүссэнээр энэ сургуульд орсон. Анх СУИС юм уу Кино урлагийн дээд сургуульд зураглаачийн ангид орох хүсэлтэй байсан. МУИС-д тэнцээд бичиг баримтаа өгсөн байсан. МУИС-ийн Хэрэглээний сургуулийн хичээлийн хөтөлбөрийн харсан чинь заавал судлах хичээл дээр мэргэжлийн хичээл гэхээсээ илүүтэйгээр түүх

гэх мэт шаардлагагүй хичээлүүд их байсан болохоор ШУТИС нь дээр юм байна гэж бодоод сүүлийн ШУТИС-ийн нэмэлт элсэлтээр Мэдээллийн систем руу орсон. Манай эгч бас энэ мэргэжлээр төгссөн болохоор илүү их мэдээлэл өгсөн.

Оюунцэцэг: Би чинь хамгийн урт түүхтэй хүн. Анх 2011 онд ШУТИС-ийн телевиз, техник, технологийн ангид орж байсан. Анх мэргэжлээ өөрөө хүсэж сонгоогүй болохоор мэргэжилдээ их дургүй байсан. Хичээлдээ бараг явдаггүй байсан. Тэгсэн чинь азаар манай анги хаагдаад сургуульгүй болсон. Тэгээд 3 жилийн өмнө надаа яг арван жилээ ахиад төгсөж байгаа юм шиг сонголт надаа ирсэн. Сургуулиа бүүр солих уу энэ сургуульдаа сурах уу гэдэг сонголт ирээд гэр бүлийнхэнтэйгээ ярилцсан. Гэр бүлийнхэн өөрийнхөө хүссэн мэргэжлээрээ сур гэсэн. Би их бодсоны үндсэн дээр манай сургууль дээр юм байна гэж бодсон. Манай сургууль чинь магадлан итгэмжлэгдсэн. Миний мөрөөдөл бол нисэх рүү орж ажиллах. Мөрөөдлөө биелүүлэхийн тулд утасгүй холбооны инженерийн ангийг сонгосон.

Мөнххүлэг: Би бас анх энэ мэргэжлийг сонгох хүсэлгүй байсан. Дунд сургуулиасаа хойш нийгмийн идэвх их сайтай байсан. 12 ангид сурь байхдаа Тайвань руу явж сурах тэтгэлэг хөөцөлдөөд менежментийн чиглэлээр сурах гээд тэтгэлэг маань бүтсэн байсан. Тэгсэн манай ээж, гэр бүлийнхэн зөвшөөрөөгүй. Эхлээд Монголдоо сураад төгсөөд гадагшаа яв гээд миний төлөвлөгөө, мөрөөдөл тэр чигтээ сүйрсэн. Улсын шалгалтын оноо азаар өндөр гараад ирсэн. Тэгээд ямар мэргэжил сонгох, цаашид сурах ямар ч хүсэл байгаагүй. Хуваарь тараалтын өдөр эхний 10 хүүхэдтэй хамт орсон. Хуваарь тараадаг хүнээс Ямар ямар хуваарь байгаа юм бэ гэж асуугаад загнуулсан. Чи чинь ийм өндөр оноо авчихаад юу яриад байгаа юм бэ гээд. Тэгээд манай ээж шууд ШУТИС-ийн электрон системийн автомажуулалт гэдэг ангийг хараад энэ яах уу гэхээр за за надаа хамаагүй гээд шууд сонгосон. Эхний 1 курст бардам сэтгэлийн хүчээр хичээлдээ хичээгээд зүтгээд үзсэн. 2 курс хүртэл сонирхолгүй санагдаж байсан. Тэгээд сая өвөл мэргэжлийнхээ талаар бие даагаад судлаад үзсэн чинь боломж маш их байгаа юм гэдгийг хараад энэ чиглэлээрээ тууштай суръя гэж бодож байгаа.

Түвшинбаяр: ШУТИС-ийн хуваарь авч байхад мэргэжлүүдийн талаар танилцуулга байсан. Тэндээс харж байгаад сонгосон. Би багаасаа компьютерийн чиглэлийн хүн болъе гэж боддог байсан. Тэгээд компьютерийн ухаан гээд хиймэл оюун талдаа түлхүү судлах юм шиг санагдаад сонгосон. 7-р ангиасаа л бэлдэж эхэлсэн.

Мөнхтөгөлдөр: Надаа сурахаар төлөвлөсөн 2 мэргэжил байсан. Нэг нь архитектур. Би өөрөө зурах сонирхолтой. Архитектур руу орох гэсэн ангийн хуваарь нь дууссан байсан. Тэгээд нөгөө сонирхол буюу IT инженер болно гээд компьютерийн ухааныг сонгосон. Эцэг, эх ч гэсэн арай эрэгтэй хүүхдэд тохирох мэргэжил гээд зөвлөсөн.

Чинбаатар: Өөрийн сонирхлоор энэ мэргэжлийг сонгосон. Багаасаа л компьютерт сонирхолтой байсан. Ирээдүйтэй мэргэжил гэж бодоод сонгосон.

**Модератор: Танай сургуулийн сургалтын орчин хир вэ? Тоног төхөөрөмж, дадлагын лабораторын орчны бүрдэл, хичээлийн бус цагаар дадлага хийх боломж хир байдаг вэ?**

Сумъяабэйс: Сургалтын орчинг бол боломжийн хирээр сайн хангаж өгсөн гэж боддог. Манай тэнхим дотроо 2 ангитай хирнээ 4 лаборатори байдаг. 1 лаборатори нь багадаа 15 компьютертэй. Анги болгон проктер, зарим ангид телевизтэй. Сургуулийн орчны хувьд хотын төвөөс хол, утаа, шороо ихтэй тэр нь жаахан хэцүү санагддаг. Сургууль доторх орчинг бол хангалттай бүрдүүлж өгсөн. Хичээлийн бус цагаар орой 9 цагаас өмнө бол хариуцсан багштайгаа хамт лабораторид ажиллаж болно.

Мөнххүлэг: Хүн өөрөө суръя мэдье гэж хүсвэл сургууль бол орчин, боломжийг хангалттай бүрдүүлж өгч байгаа.

Түвшинбаяр: 12 анги төгсөж байхад сургуулийн зургийг харж байсан. Яг ороод хичээлдээ яваад ирсэн чинь лаборатори жоохон зурган дээр байснаасаа өөр байсан. Лабораторид хичээллэхэд 2 хүүхэд дундаа нэг компьютер хэрэглэдэг. Хувийн notebook-тэй хүүхдүүд өөрсдийнхөө компьютерийг хэрэглэдэг.

Мөнхтөгөлдөр: Хичээлийн хөтөлбөр, агуулга бол боломжийн санагддаг. Зарим нэг компьютер нь хуучирсан. Яг дадлага ажил хийе гэвэл ангиуд олддог юм шиг байна лээ. Зарим нэг ангиудыг түгжээд явчихдаг.

Чинбаатар: Манайд ихэвчлэн электроникийн хичээл ордог. Яг электроникийн лабораторийн хувьд жоохон хэцүү. Зарим багаж хэрэгсэл нь ажилладаггүй. Хүрэлцээ бага учраас ээлжилж дадлага ажлаа хийдэг. Лабораторийн тоног төхөөрөмжөө л сайжруулах хэрэгтэй байгаа. Зарим нэг мэргэжилд хамааралгүй сонин сонин хичээл заавал судлах хичээл гээд ороод ирдэг.

**Модератор: Та хэдийн анзаарснаар хичээлийн хөтөлбөр хир их шинэчлэгдэж байна. 1 курст үзэж байсан хичээлүүд чинь одоо 1 курсийнхэнд зааж байгаа хичээлийн хөтөлбөрийн харьцуулж харж байсан уу?**

Алтансүвд: 2 жил тутамд хичээлийн хөтөлбөр өөрчлөгддөг. 2014, 2016, 2018 гээд дандаа шинэчлэгдээд явдаг.

Мөнххүлэг: Миний бодлоор манай сургуульд оюутан өөрөө л хичээлээ хийгээд хичээгээд сурахгүй бол юу ч сурахгүй юм шиг санагддаг. Багш нар бол арван жилийн багш нар шиг хүн болгонтой тулж харьцах боломжгүй. Хүүхдүүд өөрсдөө хичээхгүй бол багш нар аясаар нь хаячихдаг. Тийм учраас сурсан ч биш сураагүй ч биш хүүхдүүд төгсөөд явчихдаг. Хүүхдүүд өөрсдөө л дуртай, сонирхолтой байж юм сурч чадна. Миний бодлоор бол хичээлийн хөтөлбөр нилээн хоцрогдсон юм шиг санагддаг. Гадаадын сургуулийн хөтөлбөртэй харьцуулахад хоцрогдсон санагдсан. Бид нарийн үзэж байгаа

хичээлийг хүмүүс youtube, google-с хайгаад үзвэл энгийн ойлгомжтой байхаар байршуулсан байдаг. Багшаас авсан мэдлэгээ youtube бусад сайтаас харж баталгаажуулж байх хэрэгтэй.

Цэндсүрэн: Багш нар бол үндэс суурийг нь тавьж өгдөг.

Түвшинбаяр: Программ хангамжийн хичээлийн хөтөлбөрт өөрчлөлт орсон байсан. Манай салбарын хувьд өөрчлөгдөөгүй. Гэхдээ шинэ мэргэжил учраас жил болгон л шинэчлээд сайжруулаад л явж байгаа.

Чинбаатар: Манай мэргэжил 1-р курст заасан хичээлээ одоо ч гэсэн заагаал явж байгаа. Нэг их шинэчилсэн юм байхгүй байгаа.

**Модератор: Хичээлийн хөтөлбөр, агуулга хир хүнд санагддаг вэ? Тухайн онолыг яаж бататгадаг вэ?**

Уянга: Доод курсын хүүхдүүдийн үзэл бодол арай өөр байх шиг байна. Курс ахих тусмаа сэдвүүд нь гүнзгийрдэг.

Алтансүвд: Бид нарыг анх 2014 онд орж байхад заадаг байсан хөтөлбөр, хичээлүүд, материалууд нь улам шинэчлэгдээд гоё болоод байгаа юм шиг санагддаг. Бид нар азгүй ч юм шиг.

Оюунцэцэг: Мэдээллийн технологи бол цаг хугацаатай уралдаж хөгжиж байгаа болохоор бид нар тэр цаг үетэй нь зэрэгцэж л суралцахгүй бол хоцрогддог. Тэр ч утгаараа мэргэжлийн хичээлийн хөтөлбөрүүдэд шинэчлэл ордог. Оюутанууд өөрсдөө хияээж сурахгүй бол хичээлд унах, сургуулиа төгсөж чадахгүй байх тохиолдол манай сургуульд их байдаг.

Түвшинбаяр: Холбоос хичээлүүдээ 2 долоо хоногт бататгаад тэгээд шууд үндсэн хичээл рүүгээ ордог.

Мөнхтөгөлдөр, Чинбаатар: Түвшинбаяртай адилхан.

Түвшинбаяр: Ер нь мэргэжлийн бүх хичээл хүнд. Багш нар нь чанга.

**Модератор: Хэлний хичээл хэдэн кредит ордог вэ? Мэргэжлийн англи хэлний хичээлийн чанар хир санагддаг вэ? Төгсөөд ажлын байран дээр гарахад хэлний мэдлэгийн хүрэлцээ хир боломжтой түвшинд бэлтгэгдсэн гэж үзэж байгаа вэ?**

Мөнххүлэг: Нийт англи хэлний хичээл 9 кредит үздэг. 3 кредит нь харилцааны англи хэл 1 курст, 3 кредит мэргэжлийн англи хэл 2 курст, 3 кредит шинжлэх ухааны технологийн англи хэл гээд тусгай зориулалтын англи хэл гэж үздэг. Манай найз МУИС-ийн Хэрэглээний сургуулийн электроникийн автоматжуулалтын ангид сурдаг. ШУТИС-ийн хичээлийн хөтөлбөрийг МУИС-ийн хичээлийн хөтөлбөртэй харьцуулаад харахаар



арай түргэвчилсэн программтай юм шиг санагдсан. Миний 1 курсийн хавар хийж байсан роботыг манай найзын анги 2 курсын намрын улиралд хийж байсан. Гэхдээ МУИС болохоор суурийн их сайн тавьж заадаг юм шиг санагдсан.

Алтансүвд: Би бас санал нэг байна. МУИС болохоор суурь мэдлэгийн сайн заадаг. Манайх болохоор нарийн мэргэжлийн тал руугаа түлхүү сайн заадаг юм шиг санагдсан.

Сумъяабэйс: 9 кредит англи хэлийг бүгд судлах ёстой.

Мөнххүлэг: Би сая нэг юм сонссон. Одоогийн 1 курсынхан төгсөхдөө заавал англи хэлний TOEFL-ийн шалгалт өгч байж төгсөнө гэсэн стандартыг хэрэгжүүлж байгаа юм байна лээ.

Алтансүвд: Манай системийн аюулгүй байдал салбарт 2+2 хөтөлбөрт хүрээнд шинэ хичээлүүд их орж эхлэж байгаа. Анх удаа энэ жилд заагдаж байгаа шинэ хичээлүүд байгаа.

Оюунцэцэг: Япон, Энэтхэг, Солонгос, Орос руу тэтгэлэгээр явж сурах боломж их байдаг. Голч оноо, судлах ёстой кредитээ үзсэн байх, хэлний мэдлэг нь тэнцэж байвал гадагшаа явж сурах боломж өндөр. Мөн анх элсэхдээ 2+2 хөтөлбөрийг сонговол 3 курсээсээ шууд явдаг. 2+2 хөтөлбөр сонгосон хүүхдүүд хичээлээ шахуу үздэг. Нийтдээ 2 жилийн хугацаанд 21-ээс 30 хүртэх кредитээ судлаад гадагшаа явдаг. Тэгээд 2 улсын дипломтой төгсдөг.

Түвшинбаяр: Нийт 6 кредит англи хэл орсон. Эхний харилцааны англи хэл дээр 10 жилд үздэг байсан хичээлүүдийг л заадаг. Бараг юм сурдаггүй. 1-р курсээс нь эхлээд шинжлэх ухааны англи хэлийг шууд оруулчихвал зүгээр юм шиг санагдсан.

Чинбаатар: Манайд 1-р курст харилцааны англи хэл 3 кредит орсон. 3-р курст мэргэжлийн англи хэл орж байгаа. Ер нь хэлний хичээлийн агуулга, хөтөлбөр хэцүү дээ.

Түвшинбаяр: Системийн аюулгүй байдлын ангийнхан гадагшаа явах боломж их байдаг. Анхнаасаа 2+2 хөтөлбөрт хамрагдах юм бол гадагшаа явах боломж ихтэй. Одоо шинжлэх ухааны англи хэл хичээлд их хэрэглэгддэг. 2017 оны элсэлтээс эхлээд TOEFL-ийн шалгалт өгч байж төгсөхөөр болж байгаа манай үеийнхнээс эхэлнэ гэсэн үг.

**Модератор: Албан байгууллагад дадлагад гарахаар багш нарын заасан хичээлийн хир сайн бататгаж чадаж байна вэ? Дадлагад гарсны давуу тал юу юу байв.**

Оюунцэцэг: Өмнө нь телевиз, техник технологид сурч байхдаа UBS телевиз дээр дадлагад гарч байсан. Дадлагад гарсны дараа өөрөө сонгож ороогүй ч гэсэн мэргэжилдээ илүү дуртай болсон, илүү ойлгож чадсан. Дадлага, практик сургууль 1 юм уу 2 курст гарвал илүү үр дүнтэй байх болов уу гэж бодож байна. 1 курс, 2 курсын хүүхдүүд учраа мэдэхгүй ямар хичээл сонгож судлахаа сайн мэдэхгүй төөрсөн хүмүүс их

явдаг. 10 жилийн багш нар шиг багш нар тулж харьцдаггүй болохоор хүүхдүүд их алддаг. Туслах багшаас очиж асуухаасаа санаа зовоод оюутанууд 1 семестерийн хичээлээ алддаг. ШУТИС амархан гээд хүүхдүүд их алддаг. ШУТИС бол амар биш. Өөрөө л хичээхгүй бол төгсөж чадахгүй тохиолдол их гардаг. Жишээ нь би 2011 онд элсээд одоо болтол төгсөж чадахгүй л явж байна. Хугацаандаа төгсөөгүйгээс болж алдаж байгаа зөндөө хүмүүс байгаа. Ялангуяа 1,2 курсын оюутануудад сайн ойлгуулж зааж өгөх хэрэгтэй.

Цэндсүрэн: ШУТИС чинь гадаад улс орны жишгээр хүүхдүүд нь хичээлээ өөрөө сонгоод явдаг. Анги байдаг ч гэсэн хүүхдүүд өөр өөр багш сонгоод явчихдаг учраас зарим хүүхдүүд бол ангийнхаа хүүхдүүдийг мэддэггүй. 1 хичээлийг заадаг 3 багш байдаг учраас багш нь хүртэл өөр болоод явчихдаг. Өөрөө хүсэж орж ирээгүй хүүхдүүд ангигүй болохоор хичээлдээ суухгүй байх, хичээлдээ унах, төгсөхгүй удах тохиолдол их гардаг. Уул нь анги үүсгээд бөөндөө хичээлээ үзээд явбал нэг нэгэндээ туслаад, хичээлээ хамт хийгээд явбал сургуулиа хаях тохиолдол багасах байх.

Мөнххүлэг: Зөвлөх багшаас их хамаарч байгаа. Зөвлөх багш нь сайн зөвлөөд өгвөл хүүхдүүд чигтээ орчихно. Энэ жилээс эхлээд энэ ангийнхан энэ хичээлийг энэ багшийг сонгоно шүү гээд заагаад өгдөг болсон байна лээ.

Алтансүвд: Дадлагад гарахад мэдээллийн систем гээд арай менежмент тал руугаа боловч код бичих сонирхолтой бол суугаад кодоо бичдэг, эсвэл менежментийн төслийн баг дотор нь ороод хамтарч ажиллаж болно. Уянга бид 2 нэг байгууллага дээр дадлагад гарч байсан. Код нэг их сайн бичдэггүй болохоор төслийн багт нь ороод ажилласан. Дадлагын байгууллагаа сонгохдоо жижиг байгууллага дээр гарвал их юм сурдаг. Том байгууллага дээр очихоор кофе, цай зөөгөөд таардаг.

Уянга: Миний бодлоор дадлагад гарч байхдаа хичээлээ сайн сурч байхгүй яв даа гэсэн бодол төрж байсан. Яг л заасан хичээл дадлагад гарахад хэрэг болж байсан.

Түвшинбаяр: Зун сургууль дээрээ дадлагад гарсан. Дадлагаар 1 курст орсон хичээлийн давтаж үзээд жоохон хүндрүүлээд бататгаад явдаг. Хичээл дээр заасан зарим нэг жижиг зүйлсийг мартчихдаг учраас дадлагат гарахаар хичээлээ эргэж санадаг давуу тал ихтэй. Компани дээр дадлагад гарахаар илүү сайн юм сурдаг. Програмыг яаж бичдэг талаар мэдэхгүй зүйл их заадаг.

Мөнхтөгөлдөр: Хичээл дээр багш нар олон хүүхдэд зэрэг юм заадаг учраас мэдэхгүй зүйлс их гардаг. Дадлагад гарахаар багш нар хүүхдүүдтэй илүү тулж ажилладаг. Хичээл ойлгоход арай амар байдаг. Хуучин хичээлээ их сэргээж санадаг ач холбогдолтой санагдсан.

Чинбаатар: Манай мэргэжлийн тухайд 3-р курсээ төгссөний дараа дадлагад гардаг. Одоогоор дадлагад арай гараагүй байна.

**Модератор: Хир хугацаанд дадлагад гардаг вэ?**

Алтансүвд: 1сарын хугацаанд дадлагад гардаг. Нийт суралцах 4 жилийн хугацаанд 1 л удаа дадлагад гардаг. Программын ангийн оюутнууд 2 удаа дадлагад гардаг.

**Модератор: Дадлагад гарсан байгууллагаас ажлын санал хир их ирдэг вэ?**

Уянга: Манай мэргэжлийн хувьд ажлын байр ихтэй. Дадлагад сайн гарсан тохиолдолд төгсөнгүүт нь ажилд шууд авах тохиолдол байдаг. Байгууллагуудад шинээр мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр ажлын байр их гарч байгаа. Энэ жил МИАТ-аас дадлагын санал ирсэн. Дадлагад сайн гарсан хүүхдүүдийг ажилд авна гэсэн.

**Модератор: 9 кредитийн англи хэл сурч байгаа гэсэн. Хэлний мэдлэг ажлын байранд гарахад бүрэн хэмжээнд хэрэглэгдэхээр бэлтгэгдэж чадсан уу?**

Уянга: Хэлний асуудал алхам тутам тулгардаг. Байгууллага дээр очоод ажиллахад хэлний мэдлэг хомс байсан. Өмнө жил төгссөн ах, эгч нар хэлээ л сайн сур гэж хэлдэг. Манай доод курсын оюутнууд, шинээр элсэж байгаа хүүхдүүд англи хэл сайтай хүүхдүүд орж байгаа. Улам л чанаржиж байгаа.

**Модератор: Хичээл зааж буй багш нарын ур чадвар хир санагддаг вэ?**

Түвшинбаяр: Ихэнх нь залуу багш нар 25-40 насныхан байдаг. Хөгшин багш нар цөөхөн. Манай багш нар ярьдаг оюутан байхдаа хичээл заадаг байж байгаад багшаар үлдсэн гээд. Залуу багш нарын чадвар сайн.

Чинбаатар: Залуу багш, хөгшин багшийн заах арга, ур чадварын хувьд чанарын ялгаа нэг их гараад байдаггүй. Бүгд л сайн.

**Модератор: Энэ мэргэжлээрээ төгсөөд ажиллах уу?**

Сумъяабэйс: Эхний ээлжинд ажил хийнэ. Санхүүгийн эрх чөлөөтэй болно. Сургалтын төлбөрөө олоод тэгээд гадагшаа явж илүү гүнзгийрүүлж сурна.

Уянга: Ажил хийнэ. Анх энэ мэргэжлийг хүүхдүүд төдийлөн дуртай, сонирхолтойдоо орж ирдэггүй. Суралцаад явж байх хугацаандаа дуртай болдог.

Алтансүвд: Төгсөөд мэргэжлээрээ ажиллана.

Цэндсүрэн: Байдлын харна. Гайгүй газрууд байвал орно. Сонсоод байхад ажилд орвол жижиг компанид ажилд орвол дээр юм шиг санагдсан. 2-3 жил хувийн компанид ажиллаад нилээн сайн дадлагажиж байгаа том компани руу орох ч юмуу гадагшаа явж сурвал зүгээр юм шиг байна лээ. Болвол гадагшаа яваад энэ мэргэжлээрээ мэргэшиж сурна.

Оюунцэцэг: Төгсөөд нисэх рүү орно гээд зорилгоо тавьсан байгаа. Яг одоо баклавын түвшинд нисэх рүү орох боломжгүй бол гадагшаа явж магистрт сурчихаад эргэж ирээд нисэх рүү орно.

Мөнххүлэг: Эхлээд бол сургуулиа төгсөөд гадагшаа явна гэж боддог байсан. Ах эгч нарын зөвлөснөөр эхлээд 2-3 жил Монголдоо ажиллаад Монголын зах зээл яг ямар мэргэжилтэй хүнийг хүсэж байгааг мэдчихээд гадагшаа явж гүнзгийрүүлж сурна.

Түвшинбаяр: Манай мэргэжлийн тухайд ажлын байр их хомс. Ганц л компани байгаа. Тэрэн дээр чадвал очиж ажиллана. Чадахгүй бол өөр ажил л хийх байхдаа. Программ хангамжийн инженер гэдэг утгаараа код бичээд суух байх гэж бодож байгаа. 5 жилийн дараа гэхэд энэ мэргэжлийн ажлын байр нэмэгдэх байх л гэж бодож байна. Ажил олдохгүй бол сүлжээний инженерээр л дахиж сурна.

Мөнхтөгөлдөр: Манай мэргэжил бол шинэ гарч ирж байгаа мэргэжил. Хамгийн анхны төгсөлт нь манай дээд курсынхан. Шинээр гарч ирсэн мэргэжил болохоор ажлын байр хэцүү л байгаа. Гадагшаа явж энэ мэргэжлээр нь ажиллана гэж бодож байгаа.

Чинбаатар: Манай мэргэжлийн тухайд ажлын байрны олдоц ихтэй. Нийт төгссөн хүүхдүүдийн 95% нь ажлын байртай байгаа. Компаниудаас байнга сургууль дээр ирж ярилцлага авах, ажлын санал тавих ажил хийгддэг. Утасны компани, нисэх, харилцаа холбооны компаниуд гээд ажлын байр ихтэй.

**Модератор: Ах эгч нараас зөвлөгөө авахаар гэхээр яг ямар ах эгч нарыг яриад байна?**

Уянга: Дээд курсын ах эгч нар, төгсөөд ажил хийж байгаа хүмүүстэй холбоотой байдаг бид нар. Ямар ямар ажлын байр гарч байна, ямар ур чадвар шаардаж байна гэдэг тал дээр бид нарт зөвлөгөө өгдөг.

Чинбаатар: Төгссөн хүмүүстэйгээ байнгын facebook группээр холбоотой байдаг. Бие даалт асуух гэх мэт зүйлс дээр тусламж авдаг. Манай ангид анх 63 хүүхэд орж байсан. Одоо 40 хүүхэдтэй. Ихэнх нь сургуулиасаа гарсан.

Мөнхтөгөлдөр: Манай дээр 1 л төгсөлт байгаа болохоор бид нар чинь 1,2-р курсынхантайгаа л их холбоотой байдаг. Анх манай ангид 43 хүүхэд орж байсан. Одоо 13-уулаа болсон. Зарим нь өөр сургууль руу шилжсэн, зарим нь мэргэжлээ сольдог. Хүүхдүүд анхнаасаа мэргэжлээ сайн судлаагүй орж ирээд хичээл хүнд санагдахаар сургуулиасаа их гардаг.

**Модератор: Та хэдийн ихэнх нь 2-3 жил ажиллачихаад гадагшаа явна гэж яриад байна. Яагаад ингэж бодож байгаа вэ?**

Сумъяабэйс: Өөрийгөө хөгжүүлнэ.

Цэндсүрэн: Гадаадад ч гэсэн энэ мэргэжлээр ажиллах боломж өндөр

Мөнххүлэг: Цалин гадаадад арай өндөр байдаг. Тийм учраас Монголдоо ажлын туршлагатай болчихоод гадаадад очиж ажиллавал илүү өндөр цалин авна. Одоо манай сургуулийн багш нар бас гадаад руу их явдаг болсон. Манай сургуулийн ихэнх нь залуу багш нар. Багш гадагшаа явж сурж ирчихээд буцаад сургуульдаа ажилладаг.

Манай ангид анх 95 хүүхэд орж байсан. Одоо бол 45 хүүхэд байгаа. Эхний семестерт суугаад сургуулиа хаядаг, өөр анги руу шилждэг. Анх сургуульд ороод элсэлт төгсөлтийн тоог харж байсан. Анх 70 хүүхэд элссэн бол яг төгсөхдөө 10 орчим хүүхэд л төгсдөг.

**Модератор: Өөрийн сурч байгаа сургуулиа бусад энэ чиглэлээр оюутан бэлтгэдэг сургуультай харьцуулж үзэж байсан уу?**

Уянга: Харьцуулж үзэж байгаа. Монголдоо цор ганц л шилдэг сургууль гэж боддог.

Алтансүвд: МУИС-тай л харьцуулж үзэж байсан. Бусад сургуулийн талаар судлаагүй.

Мөнххүлэг: Манай сургууль 5 тэнхимтэй. 9 мэргэжилтэй. 2014 онд манай сургууль, КТМС 2 нэгдсэн.

Мөнхтөгөлдөр: Би Хүрээ дээд сургуулийн хичээлийг харьцуулж үзсэн. Манай сургууль хамаагүй дээр санагдсан. Хүрээ онол л заадаг, практик ажил бага хийлгэдэг юм шиг санагдсан. Манай найз Хүрээ дээд сургуульд сурдаг. Нэг удаа хичээлд нь сууж үзсэн. Манайд 2-р курст заасан юмыг Хүрээгийн 3-р курсын оюутнуудад заагаад байсан. Мэддэг ойлгомжтой юмыг их тайлбарлаад байгаа нь сонин санагддаг.

**Хүрээ мэдээлэл, холбооны технологийн дээд сургуулийн оюутануудтай хийсэн фокус бүлгийн ярилцлагын транскрипшн**

Байршил: Тусгаар тогтнолын ордны 9 давхарын номын сан

Хугацаа: 0:40

Модератор: Стратеги Академи ТББ-ын судалгааны секторын эрхлэгч Б.Бадамгарав

Оролцсон бүрэлдэхүүн:

№	Овог нэр	Сургууль	Анги	Курс	Хүйс	Нас
1	А.Цэнд-Аюуш	Хүрээ мэдээлэл, холбооны технологийн дээд сургууль	Эмнэлэгийн тоног төхөөрөмжийн инженер	4	Эм	20

2.	Гэрэлмаа	Хүрээ мэдээлэл, холбооны технологийн дээд сургууль	Эмнэлэгийн тоног төхөөрөмжийн инженер	4	Эм	20
3.	Н.Цэнд-Аюуш	Хүрээ мэдээлэл, холбооны технологийн дээд сургууль	Эмнэлэгийн тоног төхөөрөмжийн инженер	4	Эм	21
4.	Лувсандорж	Хүрээ мэдээлэл, холбооны технологийн дээд сургууль	Эмнэлэгийн тоног төхөөрөмжийн инженер	4	Эр	22
5.	Оюунбат	Хүрээ мэдээлэл, холбооны технологийн дээд сургууль	Эмнэлэгийн тоног төхөөрөмжийн инженер	4	Эр	25

**Модератор: Та энэ мэргэжлийг яагаад сонгосон вэ? Сонгосон шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс нь юу байсан вэ?**

А.Цэнд-Аюуш: Техник технологи хөгжихийн хэрээр эмнэлэгт инженерүүд дутмаг байдаг учраас эрэлт хэрэгцээтэй мэргэжил гэж бодоод сонгосон. Эцэг эхтэйгээ ярилцаад, өөрөө бас сонирхож байсан учраас сонгосон.

Гэрэлмаа: Миний хувьд солонгос хэлтэй сургууль гэж сонсоод давуу талтай юм болов уу гэж бодоод сонгосон. Энэ мэргэжлийг тэгээд гэр бүлийнхэнтэйгээ зөвлөлдөж байгаад сонгосон.

Н.Цэнд-Аюуш: Анх хуваарь ирэхэд тэтгэлэг өгнө гээд тэгээд гэрийнхэнтэйгээ ярилцаад сонгосон. Эмнэлэгийн байгууллагатай арай ойр юм болов уу гэж бодоод сонгосон. Эмэгтэй хүүхдэд арай дөхөм мэргэжил юм болов уу гэж бодсон.

Лувсандорж: 10 жил төгсөхөд эрэлт хэрэгцээтэй байгаа 10 мэргэжлийг харсан. Тэгээд манай мэргэжил нилээн дээгүүр байхаар нь сонгосон. Хүрээ дээд сургуульд орвол тэтгэлэг өгнө гэсэн. Тэгээд аав ээжтэйгээ ярилцаж байгаа сонгосон.

Оюунбат: Би өөрөө судлаад өөрийнхөө хүслийн дагуу мэргэжлээ сонгосон байгаа. Манай ангийхан бүгд орон нутгаас ирсэн хүүхдүүд. Хүрээ дээд сургуулийн арван жилийг төгсөж орсон хүүхэд байхгүй.

**Модератор: Танай сургуулийн сургалтын орчин хир вэ? Тоног төхөөрөмж, дадлагын лабораторын орчны бүрдэл, хичээлийн бус цагаар дадлага хийх боломж хир байдаг вэ?**

А.Цэнд-Аюуш: Манай мэргэжлийн тухайд гэвэл хичээлийн агуулга, хөтөлбөр муу, хангалтгүй санагддаг. Программ, электроник талдаа л гайгүй юм заадаг. Онол бараг заадаггүй. Манай сургууль хамтран ажилладаг байгууллага, эмнэлэг байдаггүй. Өөрсдөө дадлагын газраа олж хийдэг учраас хүндрэлтэй байдаг.

Гэрэлмаа: Адилхан бодолтой байна. Манай мэргэжлээр дагнасан үндсэн багш гэж байдаггүй. Цагийн багш нар ирж хичээл заадаг. Тэнхимийн эрхлэгч нь электроник тал руугаа түлхүү мэргэшсэн хүн байдаг учраас мэргэжлийн хичээл бараг ороод байдаггүй. Тэнхимийн эрхлэгч маань солонгос хүн.

Лувсандорж: Ер нь бол адилхан. Мэргэжилдээ дуртай болох шалтгаан нь бид нар өөрсдөө дадлага хийдэг. Дадлага хийж байх явцдаа л мэргэжил, хичээлийнхээ учрыг олдог. Дадлагад гарч байж л ойлгож мэргэжилдээ арай дуртай болдог.

Оюунбат: Хөтөлбөрийн хувьд таалагддаггүй. Бид нарт дан онол биш практик дадлага ажил, лаборатори хэрэгтэй байдаг. Тэгж байж илүү сайн мэргэших байх.

Н.Цэнд-Аюуш: Манай мэргэжлийн хувьд дадлагын лаборатори гэж байхгүй. Электроникийн чиглэлээр лаборатори байгаа. Манай сургууль 16 тэнхимтэй. 16 мэргэжлээр оюутнууд бэлдэж төгсгөдөг.

Гэрэлмаа: Манай сургууль инженер дээр суурилсан сургууль учраас анагаахын талын мэдлэг бараг байхгүй.

**Модератор: Танай тэнхимд үндсэн хэдэн багш байдаг вэ?**

Оюунбат: Үндсэн 1 л багш байдаг. Тэр нь арай электроник тал руугаа мэргэшсэн. Бусад нь цагийн багш нар байдаг.

**Модератор: Танай үндсэн багш нарын хэд нь Солонгос багш нар байдаг вэ?**

Гэрэлмаа: 50 хувь нь солонгос багш нар байдаг.

**Модератор: Солонгос багш нарын хичээлд суухад хэлний мэдлэг шаардагдана. Солонгос хэлийг хэдэн кредит судалдаг вэ?**

А.Цэнд-Аюуш: Бид нарт мэргэжлийн гадаад хэлний хичээл ордоггүй. Анхан шатны мэдлэг олгох л хэлний хичээл ордог. Манай мэргэжлийн хичээлийг Солонгос багш ордог. Тэр хичээл орчуулагатай явагддаг. Тэр орчуулагч нь тэр мэргэжлийн хүн биш болохоор сайн орчуулж чаддаггүй.

Гэрэлмаа: Орчуулагч нь мэргэжлийн хүн биш учраас хичээлээ бүрэн дүүрэн ойлгодоггүй. Мэргэжлийн хүнээр орчуулга хийлгэвэл уул нь бид нарт арай ойлгомжтой байна.

Н.Цэнд-Аюуш: Яг час хийсэн орчуулга хийдэггүй. Жишээ нь гадаад үг байлаа гэж бодоход англиар л хэлдэг. Тайлбарлаж өгдөггүй нь хэцүү байдаг. Бүрэн дүүрэн монголоор ярьдаггүй гадаад хэл хольж яриад байдаг.

Лувсандорж: Солонгос хэлийг нийт 12 кредит үздэг. Эхний 6 кредит нь анхан шат 1, сүүлийн 6 кредит нь анхан шат 2 гэж үздэг. Үсэг заана, уншуулна, бичүүлнэ.

**Модератор: Англи хэлний хичээлийг хэдэн кредит үзсэн вэ?**

Лувсандорж: Англи хэлийг 12 кредит үздэг. Бас л анхан шат 1,2-ийн түвшинд л үздэг. Мэргэжлийн англи хэл заадаггүй.

Гэрэлмаа: Ер нь хэлний хичээл ч гэсэн жоохон муу, чанаргүй. Суурь англи хэлний мэдлэгтэй хүүхдүүд гайгүй ойлгодог. Мэргэжлийн нэр томъёо ороод ирэхээр тэрийг орчуулж чаддаггүй.

Лувсандорж: Хэл дээр дутагдал их байгаа. Жишээ нь unit гэдэг үгийг чинь нэгдсэн гэж орчуулна ш дээ манай мэргэжлийн нэр томъёонд ороод ирэхээр төхөөрөмж гэж орчуулагддаг.

**Модератор: Дадлага ажил, семинарын хичээл хир их ордог вэ?**

Гэрэлмаа: Манайд онол нэг их ордоггүй. Практик дээр заасан зүйлийн бататгах боломжгүй. Эмнэлэг дээр дадлагад гарахаараа л жоохон юм сурч авдаг. Бусад мэргэжлүүд болох электроникийн инженер, компьютерийн инженер, тал руугаа л манай сургууль сайн бэлтгэж чаддаг.

Хүнсний технологийн анги бас сайн. Дадлага, практикаа сургуулийн гал тогоонд бас солонгос руу явж дадлагаждаг.

**Модератор: Эмнэлэгт дадлагад гарсны давуу тал юу байсан вэ? Зааж байгаа хичээл нь практик дээр хир их хэрэглэгдэж байсан вэ?**

А.Цэнд-Аюуш: Хичээлийг бол бататгаж чадаагүй. Дадлагад гараад мэргэжлийн багаж төхөөрөмжтэйгээ л илүү танилцсан байх.

Гэрэлмаа: Манай сургууль дээр бол нэг ч тоног төхөөрөмжийг биетээр заагаагүй. Бид нар өөрсдөө л ном, интернетээс судалдаг байсан. Багш нар бие даалтаар л тэр тоног төхөөрөмжийг судал гээд өгчихдөг байсан. Тэр бие даалтаар л судалсан зүйл нь дадлагад гарахад хэрэг болсон. Эмнэлэг дээр дадлагад тоног төхөөрөмжөө мэдэхгүй, ажиллах зарчмыг нь мэдэхгүй тохиолдол гарч байсан. Хүн өөрөө хичээгээд сэргэлэн



байгаад асууж тодруулаад явбал хүн юм зааж өгдөг. Өөрөө хичээхгүй бол дадлагын газрынхан төдийлөн юм заагаад байдаггүй. Манай сургууль дадлагын гэрээтэй газар байхгүй өөрсдөө дадлага хийе гээд гуйгаад очдог болохоор сургуулийн зүгээс манай оюутнуудад иймэрхүү зарчмаар ийм юм заах сурах гэсэн юм байдаггүй.

Н.Цэнд-Аюуш: Онолын хэсгийг нь ерөнхийд нь хэлчихдэг. Гэхдээ гарт барьж үзээгүй болохоор ажиллуулж чадахгүй асуудал гардаг. Дадлагад гарахаараа тэр тоног төхөөрөмжөө бодит байдлаар хардаг.

Лувсандорж: 2-р курсдээ лабораторийн тоног төхөөрөмжийн талаар үзэж байсан. Ажиллах зарчим, наад захын мэдэх ёстой зүйлсийг нь заасан. Тэрийгээ дадлагад ажиллуулаад бататгаад явсан. Дадлага хийх хугацаанд өөрийгөө дайчлаад хичээгээд явбал юм сурна. Миний дадлагад гарсан байгууллагаас одоо ажлын санал ирсэн байгаа.

Оюунбат: Миний хувьд ч гэсэн адилхан.

**Модератор: Ямар ямар байгууллагад дадлагад гарсан бэ?**

А.Цэнд-Аюуш: Гэрэлмаа бид хоёр үйлдвэрлэлийн дадлагаа цэргийн төв эмнэлэгт гарч байсан. Танилцах дадлагаа халдвар судлалын үндэсний төв дээр гарч байсан. Танилцах дадлага нь хоёр долоо хоног, үйлдвэрлэлийн дадлага нь гурван долоо хоног гардаг.

Н.Цэнд-Аюуш: Миний хувьд үйлдвэрлэлийн дадлага нь гэмтэл согогын үндэсний төвд, танилцах дадлага нь хавдар судлалын үндэсний төв дээр хийсэн. Үйлдвэрлэлийн дадлагад гараад их юм сурсан.

Лувсандорж: Танилцах дадлага нь 3-р төрөх дээр, үйлдвэрлэлийн дадлага нь Мед импекс компани дээр гарсан.

Оюунбат: Танилцах дадлага нь 2-р төрөх дээр, үйлдвэрлэлийн дадлага нь Мед импекс компани дээр гарсан. Манайх электроник тал руугаа түлхүү сургалт ордог болохоор компьютертэй ажиллахад хялбар байдаг.

**Модератор: Энэ мэргэжлээр танай сургууль хэдэн оноос бэлдэж эхэлсэн бэ?**

Гэрэлмаа: Анх энэ мэргэжлээр 2009 оноос элсэлт аваад анхны төгсөлт нь 2013 онд төгссөн. Манай анги 15 хүүхэдтэй.

Оюунбат: Манайд түлхүү компьютерийн хичээл ордог. Мэргэжилд хэрэгтэй программ дээр их ажиллуулдаг.

**Модератор: Та хэд бусад сургуулийн хичээлийн хөтөлбөр болон агуулга, орчны талаар харьцуулж үзсэн үү?**

Лувсандорж: Үзээгүй.

Н.Цэнд-Аюуш: Этүгэн дээд сургуультай харьцуулж үзэж байсан. Анагаах тал руугаа арай илүү бэлддэг юм шиг санагдсан. Сайн сургууль юм шиг санагдсан. ШУТИС манай сургууль 2 электрон тал руугаа, АШУИС, Этүгэн хоёр болохоор анагаах тал руугаа сайн бэлддэг юм шиг санагддаг.

**Модератор: Солонгос руу оюутан солилцоогоор явах боломж хир их гардаг вэ?**

Н.Цэнд-Аюуш: Сургуулиас бол оюутнууд явуулдаг. Манай мэргэжлийн тухайд гэвэл явуулдаггүй. Явбал электроникийн талын мэргэжлээр сурч байгаа оюутнууд л явдаг. Солонгост манай мэргэжлээр сургадаг сургууль байдаггүй.

Гэрэлмаа: Өнгөрсөн жил манай доод курсын нэг хүүхэд Солонгос явсан.

**Модератор: Танай сургууль нийт хэдэн багштай вэ?**

Гэрэлмаа: Яг тооцоолж үзэж байгаагүй юм байна. Манай сургуулийн тэнхимийн бүх эрхлэгч нь нэг нэг Солонгос хүн байдаг. Тэнхим бүрт 1-ээс 2 багш байдаг. Дээрээс нь цагийн багш нар нэмэгдээд нэг тэнхимд нь 5 орчим багш нар байдаг. Тэнхимийн эрхлэгч гол мэргэжлийн гэсэн бүх хичээлийг ордог

**Модератор: Цагийн багш нар нь ямар хүмүүс байдаг вэ?**

Оюунбат: Эмнэлэгт ажиллаж байгаа инженерүүд, тэтгэвэртээ гарсан батлан хамгаалахын багш нар гэх мэт хүмүүс байдаг. Цагийн багш нарыг сонгон шалгаруулалтаар авдаг гэсэн.

Гэрэлмаа: Магистраас дээш цолтой. Мэргэжлээрээ удаан ажилласан багш нарыг ихэвчлэн авдаг.

**Модератор: Төгсөөд энэ мэргэжлээрээ цаашид ажиллана гэж төлөвлөж байгаа юу?**

А.Цэнд-Аюуш: Энэ мэргэжлээрээ ажиллана гэж бодож байгаа. Эхлээд албан байгууллагад орж ажиллаж үзчихээд мэргэжлээ дээшлүүлээд магистрт сурна гэж бодож байгаа. Гадагшаа явж сурна. Хятад руу явна гэж бодож байгаа.

Гэрэлмаа: Төгсөөд энэ мэргэжлээрээ ажиллана гэж бодож байгаа.

Н.Цэнд-Аюуш: Миний хувьд бас ажиллана. Уг нь шууд мэргэжлээ дээшлүүлээд сурах хүсэлтэй байгаа хэдий ч сурах боломж хараахан бүрдэхгүй байгаа.

Лувсандорж: Төгсөөд мэргэжлээрээ ажиллана.

Оюунбат: Төгсөөд ажиллана гэж бодож байгаа. Одоо ч гэсэн ажиллаж байгаа.

**Модератор: Танай мэргэжлийн тухайд ажлын байрны олдоц, хүрэлцээ хир их байдаг вэ?**

Лувсандорж: Сургуулиа төгсөөгүй байхад ажлын санал ирдэг. Жилд манай мэргэжлээр 100 хүүхэд л төгсдөг. Энэ мэргэжлээр 4 сургууль л мэргэжилтэн бэлтгэж байгаа. Нөгөө гурван сургууль техникийн чиглэлээр түлхүү бэлддэг, манай сургууль инженер тал руугаа түлхүү бэлддэг. Саяхан ажлын санал ирсэн. Ирэх гурав дахь өдрөөс ажиллаж эхэлнэ.

Оюунбат: Би 12 сараас эхлээд ажилд орсон. Ажлын байран дээр гарахаар зарим нэг тоног төхөөрөмжөө бол ажиллуулж чаддаг. Зарим нэгийг нь чадахгүй тэгээд л асуугаад сураад явж байгаа.

### **Модератор: Танай сургуулийн давуу тал юу вэ?**

Оюунбат: Төгсөж буй оюутнуудад нь ажлын санал их ирдэг. 4-р курсэд байхад нь ажлын санал ирээд аль хэдий нь ажилтай болсон хүүхдүүд их байдаг.

Гэрэлмаа: Манай сургууль жил бүрийн 5 сард төгсөж байгаа хүүхдүүдийнхээ дунд эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг. 5 сар гэхэд сургуулиа төгссөн байдаг. Тэгээд аж ахуй нэгжүүд рүү манайд ийм мэргэжлээр дүнгийн ийм өндөр голчтой хүүхдүүд төгссөн гээд мэдээлэл, урилга явуулдаг. Тэр эрдэм шинжилгээний хурал дээр аж ахуй нэгжүүдээс хүмүүс ирж суудаг. Тэгээд зарим байгууллага нь ажилд авдаг. Тоног төхөөрөмж оруулж ирдэг компани, аж ахуй нэгж, эмнэлэгийн байгууллагуудаас түлхүү хүмүүс ирдэг.

А.Цэнд-Аюуш: Манай сургуулийн нэр хүнд гайгүй байдаг. Хувийн эмнэлэгүүдэд хүүхдүүд их ажилд ордог.

### ***Цаашид сайжруулах зүйлс***

А.Цэнд-Аюуш: Цаашид бүр сайжруулахын тулд лабораторитой болох шаардлагатай байгаа. Тэгээд тэр лабораторид заах багш нь болж өгвөл Монгол багш байвал илүү юм сурна. Мэргэжлийн хичээлүүдийг Монгол багш заавал эсвэл орчуулагчаа сайжруулах шаардлагатай байгаа.

Гэрэлмаа: Зарим нэг гол хичээлүүдийг ордоггүй. Яг мэргэжилтэй холбоотой хичээлүүдийг орж өгвөл сайн болох байх.

Н.Цэнд-Аюуш: Манай сургууль жил ирэх тусам чанаржиж байгаа. Хавар намартаа оюутнуудаас санал асуулга байнга авдаг. Манай тэнхимийн эрхлэгч ч гэсэн хичээлээ ойлгоод гайгүй заадаг болсон.

Лувсандорж: Лабораторитой болох хэрэгтэй байгаа. Мэргэжлийн англи хэлний хичээл ордог бол илүү үр дүнтэй.

Оюунбат: Англи хэлний хичээлийг мэргэжлийн түвшинд шаардлагатай байгаа. Хятадаас сүүлийн үед тоног төхөөрөмж их ирдэг болсон учраас цаашид ч гэсэн Хятад хэлний хичээлийг заах шаардлага үүсэх л байх.

**Модератор: Сургалтын төлбөрийн тэтгэлгийг ямар болзолтой олгодог вэ?**

Гэрэлмаа: Анх 12-р анги төгсөхөд нь 4 жилийн хугацаанд 100 хувийн тэтгэлэг гэх мэт тэтгэлэгтэй байдаг. Тэгээд эхний семистрт гол оноо нь 3,5-аас дээш байх юм бол тэтгэлэг өгнө. 3,5-аас дээш оноо авч чадахгүй бол тэтгэлэгт хамрагдаж чадахгүй төлбөрөө төлөөд дараагийн семистрт голч оноогоо дээшлүүлбэл тэтгэлэг олгоно гэх зарчимаар явдаг. Голч нь 3,5-аас дээш голчтой байж л тэтгэлэг авна.

**Модератор: Та хэдийн анзаарснаар хичээлийн хөтөлбөр хир их шинэчлэгдэж байна. 1 курст үзэж байсан хичээлүүд чинь одоо 1 курсийнхэнд зааж байгаа хичээлийн хөтөлбөрийн харьцуулж харж байсан уу?**

Бүгд: Хичээлийн хөтөлбөр агуулга жил ирэх тусам шинэчлэгдээд явагдаж байгаа.

**МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан, Инженерчлэлийн сургуулийн оюутануудтай хийсэн фокус бүлгийн ярилцлагын транскрипшн**

Байршил: Тусгаар тогтнолын ордны 9 давхарын номын сан

Хугацаа: 0:45

Модератор: Стратеги Академи ТББ-ын судалгааны секторын эрхлэгч Б.Бадамгарав

Оролцсон бүрэлдэхүүн:

№	Овог нэр	Сургууль	Анги	Курс	Хүйс	Нас
1	Буянхишиг	МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан, Инженерчлэлийн сургууль	Холбооны инженер	4	Эм	21
2.	Отгонсүрэн	МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан, Инженерчлэлийн сургууль	Холбооны инженер	4	Эм	21
3.	Золзаяа	МУИС-ийн Хэрэглээний шинжлэх	Холбооны	4	Эм	21

		ухаан, Инженерчлэлийн сургууль	инженер			
4.	Нямдаваа	МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан, Инженерчлэлийн сургууль	Холбооны инженер	4	Эр	22
5.	Билгүүн	МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан, Инженерчлэлийн сургууль	Холбооны инженер	4	Эр	22

**Модератор. Та энэ мэргэжлийг яагаад сонгосон вэ? Сонгосон шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс нь юу байсан вэ?**

Буянхишиг: Яг сонирхож сонгоогүй. Холбооны инженер гэсэн нэр нь гоё санагдаад сонгосон. Тэгээд МУИС-д орж ирээд мэргэжилтэй нь танилцаад сонгож байсан. Арван жилд байхдаа математикдаа гайгүй байсан болохороо шалгалтандаа тэнцээд ороод ирсэн. Эцэг эхийн нөлөө байгаагүй. Өөрөө шийдээд л сургуулиа сонгосон. Анх сургууль төгсөхөд л мэргэжлийн талаар ямар ч ойлголтогүй байсан. Холбооны инженер гэж юуг хэлээд байгааг нь огт мэдэхгүй байсан. Тэгээд хүмүүсээс асуусан чинь mobicom, unitel гэх мэт үүрэн телефонд ажилд орох боломжтой гэхээр нь за за сонгочихье гээд л сонгосон. Арван жил төгсөж байхад мэргэжлүүдийн тайлбар, ойлголтын талаар ямар ч мэдээлэл өгдөггүй байсан.

Отгонсүрэн: Аав ээж хоёр МУИС-д ор гэсэн. Нэр хүнд сайтай сургууль гээд. Тэгээд холбооны инженер бол ажлын байр олдоцтой, хөрвөх чадвартай мэргэжил юм шиг санагдаад орсон. Өөрөө нэг их хүсэж ороогүй.

Золзаяа: Анх мэргэжил сонгохдоо холбооны инженер мэргэжлийн танилцуулгыг уншаад хөрвөх боломжтой, ажлын байр олдох боломж өндөр юм шиг санагдаад тэгээд сонгосон.

Нямдаваа: Анх МУИС-д аав ор гэсэн. Анх электроникийн инженерийн ангид орсон байсан. Хөтөлбөр сонгох үед аав электроникийн инженерээр төгсөөд ажлын байр бага байх юм байна гээд холбооны анги руу оруулсан. Анх сургуульд орохдоо мэргэжлийнхээ

талаар ямарч ойлголтгүй орсон. Мэргэжлийнхээ хичээлүүдийг үзээд эхэлсэн чинь мэргэжилдээ дуртай болоод юу болохоо жаахан гадарлаад ирсэн.

Билгүүн: Манай хамаатны ах энэ мэргэжлээр сурч төгссөн. Тэр ахынхаа зөвлөсөн зөвлөгөөү үндэслэж сонгосон. Миний сонирхол өөрөө IT, мэдээллийн технологи тал руугаа байсан учраас өөрийн сонирхлоор сургуульдаа орсон.

**Модератор: Танай сургуулийн сургалтын орчин хир вэ? Тоног төхөөрөмж, дадлагын лабораторын орчны бүрдэл, хичээлийн бус цагаар дадлага хийх боломж хир байдаг вэ?**

Буянхишиг: Лаборатори бол яах уу дээ л байдаг. Манайх чинь 2 курст 50 хүүхэд орж ирсэн гэсэн. 3-р курс нь 40 орчим хүүхэд. 4-р курс нь 15 хүүхэд байдаг. Энэ олон хүүхдүүд чөлөөт цагаараа ангидаа ирж суугаад хичээлээ хийе гэхээр хичээлтэй байдаг. Илүү анги танхим, лаборатори байдаггүй. Номын санд очоод хичээлээ хийе гэхээр бид нарын хэрэглэдэг багаж хэрэгсэл, материал байдаггүй. Интернетийн хурд нь бид нарын хэрэглэдэг программ дээр гологддог. Хичээлийн анги танхимаас гадна сууж хичээлээ хийх анги хэрэгтэй байгаа. Сургалтын хувьд бид нар чинь ерөөсөө дадлагад гардаггүй. Дадлагад гардаггүй болохоор сул тал их байдаг. Бид нарын хичээлдээ хэрэглээд байгаа багаж хэрэгслүүд бол зөвхөн сургалтын орчинд зориулагдсан багаж хэрэгсэл байдаг. Ажил дээр гарангуут шал өөр тоног төхөөрөмжүүд байдаг учраас бид нар эрхтэн танилцах боломж байдаггүй. Дан онол үзээд практик жоохон хомс юм шиг санагддаг.

Отгонсүрэн: Яг мэргэжлийн хичээлүүдийн онолыг үзчихээд практик дээр бататгаад явдаг. Лаборатори дээр туршиж үздэг хэдий ч яг амьдрал дээр яаж ажиллахыг нь туршиж үзмээр л санагддаг.

Золзаяа: Манай сургуулийн хувьд холбооны инженерийн ангийн ганцхан лаборатори байдаг. Тэр лабораторид бөөндөө суугаад хичээл хийхэд хүндрэлтэй.

Нямдаваа: Ер нь бол санал адилхан байна.

Билгүүн: Лабораторийн хүрэлцээ муу. Хоёр хоёроороо ээлжилж ордог учраас цаг алддаг, уддаг асуудал гардаг.

**Модератор: Хичээлийн бус цагаар дадлага ажил хийх боломж хир их гардаг вэ?**

Отгонсүрэн: Ер нь бол боломж байхгүй. Энэ семистрт гэхэд тэр ангид 4 хичээл орно. 4 хичээл бүгдээрээ тэр лабораторид ордог. 1 лаборатори гэхэд 3-аас 4 групптэй байдаг. Зарим нэг багш нар, лаборант багш нартайгаа ярилцаад хичээлд нь саад болохгүйгээр хааяа орж хэмжилт хийдэг. Түүнээс бол хичээллэх боломж хүрэлцээ байхгүй. Оюутан болгон өөрийн гэсэн notebook-тэй явахгүй бол сурах нөхцөл бол хүнд.

**Модератор: Англи хэлний хичээлийг нийт хэдэн кредит үзэж байна вэ?**

Золзаяа: Нийтдээ 6 кредит үздэг. Анхан дунд, ахисан дунд гэж хоёр хуваагддаг. Тэр нь дотроо ярих, бичих, сонсох гэж хуваагдаж заадаг.

Буянхишиг: Тухайн оюутнаас хамаарна. Хэлний 6 кредит дотор чинь ганцхан англи хэл гэлтгүй Япон хэл, Солонгос хэл гэх мэт бусад хичээлүүд сонгохоор байж байдаг. Тэр хэлнүүдээсээ л сонгож авдаг. МУИС-ийн хувьд англи хэлний ахисан дунд түвшнийг давсан байх ёстой гэж шаардлагыг тавьдаг.

Модератор: Мэргэжлийн англи хэл үздэггүй юм уу?

Билгүүн: Ер нь бол үздэг байсан. Одоо бол үзэхээ больсон. 2013 оноос өмнө мэргэжлийн англи хэлийг заадаг байсан. 2014 оноос хичээлийг хасаад хаячихсан.

Отгонсүрэн: Бид нар 2014 оны шинэчилсэн хөтөлбөрөөр хичээл явагддаг. Тэр дотор нь мэргэжлийн хэлийг хасчихсан.

**Модератор: Мэргэжлийн хэлний хичээл орохгүй болохоор программ дээр ажиллахад хир их хүндрэл гардаг вэ?**

Буянхишиг: Гардаг. Хувь хүн өөрсдөө л хувиараа хэл сурдаг.

Нямдаваа: Манай мэргэжлийн онол нь дандаа англи хэл дээр байдаг. Ном үүрч явна гэсэн ойлголт байхгүй. Дандаа интернетээс хичээлийн материалаа pdf файлаар татаж авч үздэг. Багш нарын өгдөг материал ч гэсэн англи хэл дээр байдаг. Өөрсдөө л хэлээ сурахгүй бол хэцүү дээ.

Буянхишиг: Хичнээн англи хэлтэй байлаа ч гэсэн мэргэжлийн үг хэллэг, нэр томъёо ороод ирэхээр хүндрэл гардаг. Цаашид уул нь мэргэжлийн англи хэл орох шаардлагатай л гэж боддог.

**Модератор: Танай сургууль аж ахуй нэгж дээр очиж дадлагад гардаггүй гэсэн үү?**

Золзаяа: Гардаггүй. Холбооны анги л дадлагад гардаггүй. Бусад анги зарим нэг өөр мэргэжлийнхэн дадлагад гардаг.

Билгүүн: 2014 онд хөтөлбөр шинэчлэгдэхээс өмнө дадлагад гардаг байсан. Хөтөлбөр шинэчлэгдээд бас дадлагад гарахаа больсон.

Нямдаваа: Боловсролын яамнаас хөтөлбөрт шинэчлэл хийх болоод тэгээд зарим нэг хичээлүүдийг хассан. Гадаадын их дээд сургуулийн жижигт очих гээл шинэчлэл хийгээд байх шиг байгаа юм.

Буянхишиг: Дадлагад гарахаар нөгөө газрууд нь оюутнуудад нэг их юм зааж өгдөггүй учраас төслийн ажил бичүүлдэг болсон. Төслийн ажил хийж байна гэдэг чинь оюутан өөрөө бие даагаад нэг зүйлийг судлаад явбал арай илүү үлдэцтэй байх.

Отгонсүрэн: Уг нь дадлагад гараад үзсэн бол хичээлээ илүү ойлгох байсан байх. Одоо мэргэжил сурталчлах аян болоод бид нарыг ахлах курсийн оюутнууд гээд зогсоодог. Тэгээд хүүхдүүд ирээд яг төгсөж гараад юу хийх вэ? Ямар ямар төхөөрөмж дээр ажиллах вэ гээд асуухаар өөрсдөө харж мэдээгүй хүмүүс болохоор хариулахад хүндрэлтэй байдаг. Ямар худлаа ярилтайн биш.

Билгүүн: Бид нараас хүүхдүүд асуухаар бид нар тайлбарлаж хэлж чаддаггүй. Бид нарт харсан үзсэн юм байхгүй болохоор юу гэж хэлэхээ мэддэггүй.

**Модератор: Та хэдийн анзаарснаар хичээлийн хөтөлбөр хир их шинэчлэгдэж байна. 1 курст үзэж байсан хичээлүүд чинь одоо 1 курсийнхэнд зааж байгаа хичээлийн хөтөлбөрийн харьцуулж харж байсан уу?**

Буянхишиг: Бид нар чинь одоо бүгд 2014 оны төлөвлөгөөгөөр явж байгаа болохоор хичээлийн хөтөлбөр бүгд адилхан байгаа. Бид нар 2014 оны төлөвлөгөөний хоёр дахь төгсөлт.

Отгонсүрэн: Хичээл заадаг багш нар нь дандаа 40-өөс дээш насны хүмүүс байдаг. Лабораторийн багш нар бол дандаа залуу багш нар байдаг. Лекцээсээ илүүтэйгээр лаборатори дээрээ илүү юм сурч авдаг. Залуу багш нартайгаа ярилцаад, юм асуухад ч гэсэн харьцахад арай амар байдаг.

**Модератор: Та хэд бусад сургуулийн хичээлийн хөтөлбөр болон агуулга, орчны талаар харьцуулж үзсэн үү?**

Буянхишиг: ШУТИС-ийн холбооны сургууль бол манайхаас илүү юм байна лээ. Үзэж байгаа хичээлүүд нь илүү задраад мэргэжлийн тал руугаа түлхүү заадаг юм шиг санагдсан. Чиглэл чиглэлээрээ нарийн задарсан болохоор нарийн мэргэшээд явчихдаг. Практик ажил хийлгэхдээ ШУТИС арай сайн юм шиг санагдсан.

Отгонсүрэн: Тэмцээнд орохоороо ШУТИС-ийнхнийг харахаар бид нараас шал өөр байдаг. Бид нарийн үзээгүй байгаа хичээлүүдийг аль хэдий нь үзчихсэн. Зарим нэг хичээлийн агуулыг асуухаар бид нараас арай илүү байгаа нь мэдрэгдээд байдаг. Манайх жишээ нь холбоо гэгчхээд сүлжээний хичээл үзэж байна. Химийн хичээл хүртэл үзэж байгаа. Мэргэжлийн биш хамаагүй хичээл үзээд байгаа нь зөв ч юм уу буруу ч юмуу гэж боддог.

Буянхишиг: ШУТИС-ийн холбоо чинь бүхэл бүтэн сургууль шүү дээ. Манайх яах уу нэг сургуулийн нэг тэнхимийн л анги юм чинь манайхаас илүү л байна л даа. Манай тэнхимийнхэн хоорондоо холбоо их сайтай. Дээд, доод курс гэлтгүй хоорондоо хичээлээ асуух, нэгэндээ зааж өгөх асуудал гардаг. Манай сургуулийн орчны л хувьд жоохон хэцүү.



Золзаяа: ШУТИС лаборатори сайтай. Мэдлэгээ бататгах тал дээр илүү дээр байх. Манайх бол төгсөлт дипломын чанарын хувьд сайн гэж бодож байна. Манай найз ШУТИС-ийн холбооны ангид сурдаг. Очоод танилцаад үзэхээр оюутнууд нь өөрсдийнхөө мэргэжлийн чиглэлийг хөгжүүлээд клуб байгуулаад клубд нь тусдаа өрөө гаргаар өгчихсөн байсан. Тэр клубдээ цуглаад мэдэхийг хүссэн зүйлээ өөр хоорондоо хуваалцаад, хамтарч хичээлээ хийж суудаг нь их таалагдсан.

Нямдаваа: Би эерэг талын ярья л даа. ШУТИС бол нэг нэг чиглэлээр мэргэшүүлээд явж байгаа. Манай бол холбооны хичээл, электроникийн хичээл, сүлжээний хичээл код бичих гэх мэт олон талын мэдлэгийг өгч байгаа. Сургууль дээр онолын л мэдлэг авна. Ажил дээр гараад ажиллахад бүх салбарын талаар манайхан бага ч гэсэн мэдлэгтэй болсон байна. заавал холбооны инженер гэлтгүй электроник ч юм уу сүлжээ тал руу хөрвөж ажиллах давуу талтай.

Билгүүн: Миний санал бол нэг байна. ШУТИС дээр хичээлийн бус цагаар дадлага хийх боломжтой. Сан дурын клубууд ажиллаж байна. Бид нарын тухайд төгсөхдөө олон талын мэдлэгтэй болж төгсөж гарч байгаа. Олон талын мэдлэгтэй байна гэдэг бол ирээдүйд хэрэг болно.

Өөр хувийн сургуультай харьцуулж үзээгүй. ШУТИС, МУИС 2 л чадварлаг хүмүүс бэлддэг гэж боддог.

**Модератор: Төгсөөд энэ мэргэжлээрээ цаашид ажиллана гэж төлөвлөж байгаа юу?**

Билгүүн: Төгсөөд энэ мэргэжлийнхээ давуу ажиллана. Тэгээд гүнзгийрүүлээд магистрт сурна гэж бодож байгаа.

Буянхишиг: Электроникийн чиглэлээр ажиллая гэж бодож байгаа. Сая нэг сонгон шалгаруулалт орсон. Гадагшаа явж сурна. Электроникийн чиглэлээр гадагшаа сургуульд явах шалгалт өгсөн. Одоо тэгээд явах гээд англи хэлээ сайжруулаад байж байгаа.

Отгонсүрэн: Би төгсөөд мэргэжлийн давуу ажиллана гэж бодож байгаа.

Золзаяа: Би төгсөөд мобикомд ажиллана гэж бодож байгаа. Өнгөрсөн зуны амралтаараа мобикомд оператор хийж үзсэн. Мобиком залуучуудыг их дэмжиж ажилладаг юм шиг санагдсан. Инженерүүд нь ихэвчлэн шинэхэн төгссөн залуу хүмүүс байдаг.

Нямдаваа: Төгсөөд мэргэжлийнхээ дагуу ажлаад ямарч гэсэн ойлголттой болно. Тэгээд цаашдаа юу хийхээ шийднэ. Монголд холбооны чиглэлээр сайн биш. Япон, Америк хоёр холбоо талдаа сайн. Болж өгвөл гадагшаа явж ажиллана гэж боддог. Энэд бол холбоо чиглэлээр хийгээд байх юм байхгүй. Бааз станц хянаад л сууж байна. Сүлжээ юм уу электроник тал руугаа арай илүү ажил олдоно, сонирхолтой.

**Модератор: Золзаяа зун мэргэжлээрээ ажил хийхэд хир санагдсан вэ? Хичээл дээр заадаг зүйлс хир их хэрэг болсон бэ?**

Золзаяа: Компьютер дээр ажиллахад л давуу талтай байсан. Бусад зүйлсийг нь бол шинээр сурч мэдэж авсан.

Билгүүн: Би бас зун Skytel дээр ажил хийсэн. Багшийн заасан онол ажил дээр юу ч хэрэг болоогүй. Практик ажил нэг их хийдэггүй учраас ажил дээр гарахаар компьютерийн мэдлэг л хэрэг болсон.

Буянхишиг: Бид нар дээд талын төгсөлтийнхөө хүмүүсийг хараад байхаар эмэгтэй нь мониторинг хийгээд эрэгтэй нь засвар үйлчилгээний тал руугаа түлхүү ажилладаг юм шиг санагдсан.

**Модератор: Ажлын байрны олдоц хир байдаг вэ?**

Буянхишиг: Гайгүй байдаг юм шиг байна лээ.

Отгонсүрэн: Үүрэн телефонууд ихсээд л байвал манай ажлын байр нэмэгдээл байна гэсэн үг. Үүрэн телефоноос гадна телевизүүд байна. харилцаа холбоогүй компани гэж байхгүй ш дээ. Банк рүү хүртэл орох боломжтой.

**Модератор: Гадагшаа оюутан солилцоогоор явах боломж хир их байдаг вэ?**

Билгүүн: Явуулдаг гэсэн. Манай мэргэжлийн тухайд бол байхгүй. Явсан тохиолдолд холбооны инженер байхад сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр явсан. Тэгээд буцаж ирээд үзсэн хичээлээ дүйцүүлээд төгсөж болох уу гэхээр хоёр улсын хичээлийн программ өөр гээд дахиад хичээлээ судалдаг. Тэр хүн гадагшаа яваад хэл л сураад ирж байгаа байх. Хичээлийн программ өөр байхад оюутан солилцоо гээд явуулж байгаа нь утгагүй санагддаг.

**Модератор: Энэ мэргэжлээр суралцаад явахад сургуулийн зүгээс цаашид засаж сайжруулах ямар ямар зүйлүүд ажиглагдсан вэ? Орчин, хичээлийн агуулга, хөтөлбөрийн хувьд**

Нямдаваа: Миний бодлоор сургууль гэхээсээ илүүтэйгээр 100% тэр хүн юм суръя гэвэл өөрөөс нь л шалтгаална. Өөрөө л хүсэл тэмүүлэл зорилготой байвал хэрэгтэй зүйлс нь олдоол байна.

Билгүүн: Ерөнхий суурийн хичээлүүд байгаад байдаг. Тэр хичээлүүдийг багасгах хэрэгтэй юм шиг санагдсан. Тэр хичээлүүд дээр хувь хүний төлөвшлийн талаар ихэвчлэн заадаг. Тэр нь их цаг аваад байгаа болохоор мэргэжлийн хичээлийн цаг багасаад байдаг. Энэ тал дээр анхаарах хэрэгтэй байх.

Нямдаваа: Надаа лав ерөнхий суурь хичээлүүд хэрэгтэй санагдсан. Би Монголын түүх, Философи, Менежментийн үндэс гэсэн хичээлүүдийг үзсэн. Энэ 3-аас жоохон юм ойлгож авсан. Огт хаяж болохгүй.

Золзаяа: Дадлагад гаргах хэрэгтэй байгаа. Ажлынхаа орчинтой танилцаад, юм мэдчихээд ажлын байран дээр гарвал бид нарт хэрэгтэй.

Отгонсүрэн: Бараг адилхан бодолтой байна. Анги танхим нэмэх, хэрэглэгдэх багаж материал илүү байвал практик хийхэд хэрэгтэй. Өөр дутагдалтай зүйл байхгүй дээ. Өөрөө л хичээх хэрэгтэй. Бид нарын сурч байгаа зүйл хүний дор орохгүй гэдгийг мэдэж байгаа.

Буянхишиг: Сүлжээ чиглэлийн хичээлийг түлхүү үзвэл зүгээр байх. Бид нар төгсөхөд диплом дээр сүлжээний технологи гэж бичигдэнэ. Бид нарын дээд төгсөлтийнхөн 4,5-аар төгссөн. Тэгээд ярилцлаганд орохоор сүлжээний технологи гэхээр бүгдээрээ компьютер гэж ойлгоод байдаг. Тийм учраас сүлжээ талынхаа хичээлийг түлхүү оруулбал зүгээр байх.

Билгүүн: Нэр их солигдсон. Холбооны технологи гэж байж байгаа сүлжээний технологи болгосон. Тэр нь яагаад солигдоод байгаа юм бэ гэхээр Боловсролын яамнаас соль гээд өнгөрсөн зун мэргэжлийн нэрийг сольсон. Боловсролын сайд солигдохтой холбоотойгоор манай мэргэжлийн нэр солигдоод байгаа. Бид нар холбооны инженер гэж явж ирчихээд сүлжээний инженер гэж төгсөхөөр чинь сонин ш дээ.

Отгонсүрэн: Ээж аав хүртэл гайхаад асуугаад байгаа. 4 жил холбоо, холбоо гэж явчихаад төгсөхдөө сүлжээ гэхээр чинь гайхана биз дээ. Манай аав, ээж чи чинь анх ангиа сонгохдоо буруу сонгосон юм биш үү гэсэн. Нэр солигдсон учрийг тайлбарлахаар ойлгохгүй байгаа.

Буянхишиг: Зөвхөн нэг хүний эрх ашгийн төлөө мэргэжлийн нэршлийг солиод байж болохгүй. Бид нар холбоо тал руугаа түлхүү үзсэн хирнээ одоо сүлжээгээ төгсөнө гэхээр хэцүү л байна. Бид нарын өмнөх жилийнхэн юу ч мэдээгүй байхад нь диплом дээр сүлжээний технологи гээд бичигдээд гараад ирсэн гэсэн.

Золзаяа: Манай сургууль хөтөлбөрөө байнга шинэчлээд байгаа нь хэцүү. Нэгэнт л анх оруулахдаа холбооны технологи гэж оруулсан бол тэр чигээр нь төгсгөөд анх элсэлт авч байгаа ангидаа сүлжээний технологийн анги гэж шинээр гаргах хэрэгтэй.

*Нэр томъёоны хувьд л шинэчлэл хийгдэж байгаа. Хичээлийн агуулга бол нэг их өөрчлөлт ороогүй.*

**ХХМТ-ийн салбарын төлөөлөл болгон сонгосон ААНБ-ын хүний нөөцийн мэргэжилтнүүдтэй ярилцсан ярилцлага.**

“Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарийн хүний нөөцийн судалгаа” ярилцлагын транскрипшн-1

Огноо: 2018.12.07

Аудио файлын нэр: voice\_expert\_2018.12.07\_001

Ярилцлага үргэлжилсэн хугацаа: 00:28:16

Модератор: Стратеги Академийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Батдэлгэр

Ярилцлага хийсэн газар: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Мэдээлэл Технологийн Парк

Модератор: Танд энэ өдрийн мэнд хүргэе. Манай байгууллага нь “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн судалгаа”-г хийж гүйцэтгэж байна. Энэ судалгааны хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагуудаас хүний нөөцийн талаарх судалгааг авч байна. Уг судалгааны мэдээллийг зөвхөн эрдэм шинжилгээний зорилгоор ашиглах бөгөөд судалгаанд оролцсон хувь хүний нэрийг нийтлэхгүй юм.

Оролцогч: За ойлголоо.

Модератор: Танай байгууллагын харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр хэдэн хүн ажилладаг вэ?

Оролцогч: 30

Модератор: Харилцаа холбоо, мэдээллийн технологийн мэргэжилтэй боловсон хүчин хүрэлцээтэй байдаг уу?

Оролцогч: Дутагдалтай байдаг. Мэдээллийн технологийн инженер /IT engineer/ юмуу программ хангамжийн инженер, сүлжээний инженер дутагдалтай байгаа.

Модератор: Дутагдалтай байгаа шалтгаан нь юу вэ?

Оролцогч: Ер нь бол энэ чиглэлийн мэргэжилээр төгсөгчид хангалттай их биш байна. Төгсөгчдийн мэдлэг, мэдээлэл хангалтгүй байна. Дээрээс нь манай цалин бас гологдоод байдаг байх аа.

Модератор: Тэгвэл боловсон хүчин дутагдалтай байгаа шалтгааныг цалинтай холбож ойлгож болох уу?

Оролцогч: Үгүй, үгүй. Ер нь бол зар тавихад ажил орохыг хүсэгчдийн анкет бага ирдэг. Бид нар энэ чиглэлээр мэргэжил олгож байгаа багш нартай холбоод асууж үзсэн. Чадвартай, сайн суралцаж байгаа оюутнууд нь дадлагаар том том компаниудад

ажиллачихдаг. Тэгээд шууд төгсөөд тэндээ ажилд орчихдог. Тийм болохоор шууд төгсөөд ажилгүй байдаг төгсөгч бага гэж бодож байна. Зар тавиад үзэхэд анкет ер нь нэлээн бага ирсэн. Ер нь л ганц хоёроос хэтрээгүй шүү. Программ хангамж, сүлжээний инженер гээд зар өгч байсан. Цалин бага гээд ажилд орох нь бага болсон юм уу гэж хараад байгаа.

Модератор: Ажлын байрны зараа ямар хэлбэрээр тавьдаг вэ?

Оролцогч: вэб сайтаараа дамжуулаад, biznetwork, facebook-ээр заруудаа байршуулдаг.

Модератор: Ажлын байран дээр анкетаа ирүүлж байсан хүмүүсийн анкет шаардлага хангаж байсан уу?

Оролцогч: Яг 100% хангасан оролцогч бол байгаагүй. Цаашдаа сургаад авах боломжтой гэсэн хүмүүсээ ажилд авдаг.

Модератор: Шинээр ажилд орж байгаа хүмүүсээ бэлтгэж авдаг гэсэн үг үү?

Оролцогч: Тийм. Ер нь манайх туршилтийн хугацаа 3 сар гэж аваад тэр хугацаандаа ямархуу ажиллаж байна, хандлага нь ямархуу байна гэдгийг харж байгаад л шийддэг. Яг шинээр төгсөж ирж байгаа залуучуудыг бол шаардлагатай тоног төхөөрөмж дээр ажиллуулж сургахын тулд хуучин ажиллаж байгаа мэргэжилтэнүүдээ дагалдуулж сургадаг. Бусдаар бол хуучин ажиллаж байсан ажлын туршлагатай хүмүүсийг бол шууд ажлын байран дээр нь аваад туршилтын хугацаанд нь ажиллуулаад тэнцсэн тохиолдолд жинхэлдэг байгаа.

Модератор: Ажилтнуудаа мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулдаг уу?

Оролцогч: Ажилтнууд өөрийнхөө хүсэлтээр магистр, докторын зэрэг ч юм уу сургалтанд явахыг хүсвэл бид нар дэмжиж цаг гаргаж өгдөг. Мэргэжил дээшлүүлэх санаачлага аль ч талаасаа гардаг. Дийлэнхидээ манай ажилтанууд санаачилга гаргаад мэдлэг, мэргэжилээ дээшлүүлмээр байна гэсэн хүсэлт гаргадаг. Манай байгууллагаас бол олон улсын хамтын ажиллагаатай байгууллагууд руу сургадаг. Тухайлбал БНСУ, Энэтхэг улс руу богино хугацаатай сертификаттай сургалтанд хамруулдаг. Сая гэхэд л манай 3 ажилтан 11 хоногийн сертификаттай сургалтанд БНСУ руу яваад ирсэн байгаа.

Модератор: Монгол Улсдаа ихэвчлэн ямар сургуульд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж байгаа вэ?

Оролцогч: Удирдлагын Академид нэг хүн маань бизнесийн удирдлагаар төгссөн. Монгол Улсын Их Сургууль бас нэг хүн төгссөн. Манай ажилтанууд ихэвчлэн IT чиглэлийн мэргэжилтэй учраас давхар бизнесийн удирдлага, захиргаа удирдлагын

чиглэлээр илүү суралцах хүсэлтэй байдаг. 1,5-2 жилийн хугацаатай байдаг. Төлбөрийн хувьд 3-4 сая байгаа байгаа.

Мэргэжлийн чиглэлээр бол гадаад руу богино хугацааны сургалтанд илүү хамруулж байна.

Модератор: Аль улс руу түлхүү сургадаг вэ?

Оролцогч: Солонгос руу л явна даа. Энэтхэг рүү бас явдаг.

Модератор: Гадаад явж сурах сургалтын хугацаа ямар байдаг вэ?

Оролцогч: 3 сар хүртэлх хугацаатай явдаг. Тэгээд цаанаасаа тэтгэлэгтээ явдаг.

Модератор: Цаанаасаа гэхээр тухайн улсын засгийн газрын тэтгэлэгээр явах уу?

Оролцогч: Тийм

Модератор: Монголдоо мэргэжил дээшлүүлж байгаа хүмүүс маань байгууллагын зардлаар сурах уу?

Оролцогч: Үгүй. Тал хувийг нь байгууллага, тал хувийг нь ажилтан өөрөө төлдөг. Ер нь сургалтын хөнгөлөлт дотоод журманд заасныхаа дагуу хөнгөлөлт үзүүлээд явдаг. Байгууллагаас төлбөр төлж сургасан ажилчид маань ядаж 3 жил байгууллагадаа ажиллах нөхцөлтэй ч юмуу сургадаг байгаа.

Модератор: Танай ажилтнуудад гадаадад төгссөн боловсон хүчин байдаг уу?

Оролцогч: Байхгүй. Харин гадаадад мэргэжил дээшлүүлсэн хэд хэдэн хүн байгаа.

Модератор: Монголд бэлтгэгдсэн болон гадаадад бэлтгэгдсэн боловсон хүчний ялгаа ямар байдаг вэ?

Оролцогч: Гадаад хэл эзэмшсэн байдлаар голдуу ялгаа гарна л даа. Гэхдээ манайд бол яг тийм гадаадын их дээд сургууль төгсөөд ажилд орсон хүн байхгүй байна. мэргэжил дээшлүүлээд ирсэн хүмүүс бол байна.

Модератор: Мэргэжил дээшлүүлээд ирсэн хүмүүсийн чадвар хэр өөрчлөгдсөн байдаг бол

Оролцогч: Өөрчлөгдөнө шүү. Юмыг бас арай өөр өнцгөөр харна. Тэгээд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх санаа, санаачилга гаргасан тийм л байдлаар ирнэ дээ.

Модератор: Танай байгууллагад ажил горилогчдын ажлын байранд тэнцэхгүй байгаа нийтлэг шалтгаан?

Оролцогч: Ер нь юу гэж хэлмээр юм бэ дээ? Сонгон шалгаруулалтад оролцох оролцогчийн тоо цөөн. Тэгээд бас манай цалин гологддог байх гэж боддог.

Модератор: Цалингийн асуудал бас их яригдаж байна. Дундаж цалин хэд байдаг вэ? /ямар төрлийн нэмэгдлүүд авдаг вэ? /

Оролцогч: Манай дундаж цалин чинь 600-700 мянга ш дээ.

Модератор: Мэдээллийн технологийн салбарынхан арай өндөр цалин авдаггүй юмуу?

Оролцогч: Бусад хувийн салбарын харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарынхан илүү өндөр цалин авч байгаа. Тэгэхээр чинь манай цалинг голоод ажилд орох хүсэлтэй хүмүүсийн тоо бага байдаг. Яахав их дээд сургууль төгсөгчдөөс ажилд авна, тэгээд зар тавиад ирсэн хүмүүсээс л хүний нөөцөө бүрдүүлнэ дээ. Салбартаа олон жил ажилласан туршлагатай хүнийг бол удирдах албан тушаалд урьж ажиллуулдаг.

Модератор: Сургалт хөгжлийн үйл ажиллагааны давтамж хэр байдаг вэ?

Оролцогч: Манайх ер нь тогтмол хийдэг байсан. Энэ жил арай багасаад байгаа.

Модератор: Бага гэхээр юу гэж ойлгох уу?

Оролцогч: Жилдээ хоёр удаа. Өмнө нь бол сардаа нэг удаа, заримдаа улиралд нэг удаа ч юмуу хийдэг байсан. /яагаад тоо нь багассан тодруулах/

Модератор: Мэргэжлийн сургалтын төвөөр дамжуулж сургалт авдаг уу?

Оролцогч: авна. Хувь хүний хөгжлийн Ганнибел төв, лектор төв, Хувь хүний Институт зэрэг сургалтын байгууллагуудаас сургалт авдаг. Нэг өдрийн ч юмуу, цагаар сургалт авдаг.

Модератор: Төлбөр нь хэд гэх үү?

Оролцогч: 3 цагийн сургалт 500,000 болно.

Модератор: Ажилчдын ажлыг ямар аргаа үнэлдэг вэ?

Оролцогч: Ажил хийж гүйцэтгэх дотоод журам гэж байдаг. Тэр нь одоо төлөвлөгөө, тайлангын гүйцэтгэлээ оноо баллаар дүгнээд үнэлдэг. Бусад үнэлгээ гэдэг нь цаг баримтлах, бусад зохион байгуулалтын арга хэмжээнд оролцож байгаа байдлыг нь үнэлгээний 5% ч юмуу тооцдог.

Модератор: Ажилчдын ажлыг урамшуулах тогтолцоо хэр байдаг вэ?

Оролцогч: Яг тухай бүрт нь урамшуулах бол байдаггүй. Жилийн эцэст шинэ жилээр урамшуулдаг. Урамшуулал хангалттай гэж хэлж чадахгүй.

Модератор: Шинэ жилээр яаж урамшуулдаг вэ?

Оролцогч: Салбарын шагналд тодорхойлдог, бас байгууллагын шилдэг ажилтан, шилдэг хэлтэс, алба шалгаруулдаг.

Модератор: Ажилтан албан тушаал ахих боломж хэр байдаг вэ?

Оролцогч: Албан тушаал ахих боломж тийм сайн бишээ. Учир нь тийм олон ажилтан байхгүй, том бүтэц биш болохоор тийм албан тушаал ахиад явна гэсэн ойлголт бага.

Модератор: Ажлын байрны шалгуур үзүүлэлт ямар байдаг вэ?

Оролцогч: Тухайн албан тушаалаасаа хамаараад өөр өөр байна л даа. Нийтлэг шаардлагууд бол байна.

Модератор: Ажилтнууд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаж чадаж байна уу?

Оролцогч: Сүүлийн үеийн компьютер, техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байдаг. /Энэ асуултыг ажилтан, мэргэжилтнээс асуух /

Модератор: Ажлын ачаалал хэр байдаг вэ? /хортой нөхцөл эсэх/

Оролцогч: Хэвийн ачаалалтай байдаг.

Модератор: Энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж буй сургуулиуд цаашдаа юун дээр анхаарвал зүгээр вэ?

Оролцогч: Энэ чиглэлээр төгссөн оюутнууд мэргэжилээрээ ажиллахгүй байгаа нь ажиглагддаг.

Модератор: Яагаад? Шалтгаан нь юу юм бол?

Оролцогч: Нэгдүгээрт мэргэжлээ сайн ойлгохгүй, мэдэхгүй төгсөж байгаа оюутнууд байна. хоёрдугаарт, цалин мөнгө бас их хардаг байх гэж боддог. Мэргэжилдээ дур сонирхол багатай, итгэл үнэмшилгүй байна гэж боддог.

Модератор: Засгийн газар, бодлого боловсруулах түвшинд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг бэлтгэхэд ямар ажил хийгээсэй гэж Та бодож байна вэ?

Оролцогч: Энэ салбарт томоохон хөрөнгө оруулалт, бодлогын дэмжлэг хэрэгтэй байна. Манай улсад мэдээллийн технологийн салбарыг гол авч үзэхгүй байна. Манай байгууллага дээр гэхэд инкубатор гээд бойжоод гарахад эд нарт өгөх дэмжлэг тусламж гэж ерөөсөө байхгүй байгаа учраас цаашаага тэлэх, хөгжих боломж бага байдаг. Манай байгууллага дээр засгийн газраас дэмжлэг ирдэггүй шд ээ. энэ чиглэлийн удирдлагаа Мэргэжлийн хүмүүсээр тавих нь бас их зүйтэй гэж бодож байна. Бүхий л зүйл цахим



болоод автомат болж байгаа энэ үед гол ажлыг нь манайхаас бойжиж байгаа инкубатор, компаниуд л авч явах болохоор Монгол улсын хөгжил бол энэ салбартай салшгүй холбоотой л гэж бодож байна. манайх бол төлөвлөгөөндөө оруулсан байгаа. Цаасгүй технологи хөгжүүлнэ гэсэн байгаа. Манайд цаасаар ирсэн бүх материалаа цахим хэлбэрт оруулах ажил хийгдээд явж байгаа.

**Модератор:** Танай байгууллагын дээд түвшний байгууллага нь юу вэ?

**Оролцогч:** Төрийн өмчийн Хороонд харьяалагдаж байгаа. Хуучин манайх ХХМТГ-ын харьяалагдаж байсан.

**Модератор:** Танай санхүүжилт ямар байдаг вэ?

**Оролцогч:** Манайх өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг байгууллага. Бусдаар бол ямар нэгэн дэмжлэг, тусалцаа бол байхгүй ш дээ.

**Модератор:** За баярлалаа. Ярилцлага маань энэ хүрээд өндөрлөж байна.

## **“Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарийн хүний нөөцийн судалгаа” ярилцлагын транскрипшн-2**

**Огноо:** 2018.12.07

**Аудио файлын нэр:** voice\_expert\_2018.12.07\_003

**Ярилцлага үргэлжилсэн хугацаа:** 00:14:52

**Модератор:** Стратеги Академийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Батдэлгэр

**Ярилцлага хийсэн газар:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн байр

**Модератор:** Танд энэ өдрийн мэнд хүргэе. Манай байгууллага нь “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн судалгаа”-г хийж гүйцэтгэж байна. Энэ судалгааны хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагуудаас хүний нөөцийн талаарх судалгааг авч байна. Та санал бодлоо чөлөөтэй илэрхийлээрэй. Танай байгууллага хичнээн ажилтантай вэ?

**Оролцогч:** 1360 орчим байхаа. Боловсон хүчин бол хангалттай байдаг.

**Модератор:** Ажилтан сонгон шалгаруулах зарыг ямар шугамаар зарладаг вэ?

Оролцогч: Зар мэдээ сонин, ШУТИС-ийн Холбоо Мэдээллийн Сургуультай хамтран ажилладаг.

Модератор: Шинээр ажилд орж буй хүмүүс ажлын байран дээрээ шууд ажлаад явж чаддаг уу?

Оролцогч: Ер нь бол шууд ажиллаж чадахгүй. 1-3 сар дагалдуулж сургана даа. Тэгээд цаашдаа ажлын байрны сургалт болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулаад явдаг. Ажлын байрны сургалтаа манай инженер, техникийн алба өөрсдөө хийдэг мөн сургалтын төвүүдээр дамжуулаад бас сургалт авдаг.

Модератор: Гадаад руу сургадаг уу?

Оролцогч: Сургана. Энэтхэг болон БНХАУ руу тэтгэлэгээр сургадаг. Сургалтын хугацааны хувьд 6-9сар байдаг. Монголдоо бол их дээд сургуульд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулна. Төлбөрийн хувьд шаардлагатай хүмүүсийнхээ төлбөрийг төлөөд явна. Зарим нь хувиараа ч сурах нь бий. Гадаадад курст суугаад, мэргэжил дээшлүүлээд ирсэн хүмүүс арай илүү байдаг л даа. Ядаж үзэж харсан юм нь хүртэл арай өөр. Хэлний мэдлэг гэдэг маш том зүйл байдаг.

Модератор: Энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа сургуулиудыг юун дээр анхаараасай гэж та бодож байна вэ?

Оролцогч: Дадлагыг маш сайн чанартай хийлгэх хэрэгтэй гэж боддог. Онол бол байна. Гэхдээ практик бол нөгөө тал нь учраас онол практик хосолсон сургалт явуулах хэрэгтэй гэж бодож байна. онолоо мэдээд байдаг хэрнээ ажил дээр гараад тэрийгээ ашиглаж чадахгүй байдал маш их байна.

Модератор: Дундаж цалингийн хэмжээ хэд байдаг вэ?

Оролцогч: 700,000-850,000 орчим нэмэлт урамшуулал бас байдаг. ажилчдын ажлын гүйцэтгэлийг дүгнэх дотоод журам гэж байдаг. Тэр журмын дагуу ажилчдынхаа ажлын гүйцэтгэлийг үнэлдэг. Ажлын хэвийн ачаалалтай байдаг.

Модератор: Төрөөс энэ салбарын хүний нөөцийг бүрдүүлэхэд ямар бодлого авч хэрэгжүүлээсэй гэж та бодож байна вэ?

Оролцогч: Энэ чиглэлээр сурч байгаа оюутнуудад тэтгэлэг олгох, гадаад улс руу сургах боломжоор хангах шаардлагатай байна. Оны эцэс болчихоод зав муутай байгаад байна. Уучлаарай.

Модератор: Ярилцсанд баярлалаа.

**“ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН  
СУДАЛГАА” ЯРИЛЦЛАГЫН ТРАНСКРИПШН-3**

**Огноо:** 2018.12.17

**Аудио файлын нэр:** voice\_expert\_2018.12.17\_001

**Ярилцлага үргэлжилсэн хугацаа:** 02:08:16

**Модератор:** Стратеги Академийн захирал Г.Наранбаяр

**Ярилцлага хийсэн газар:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, НЗДТГ-ын байр

**Модератор:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Манай байгууллага нь “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн судалгаа”-г хийж гүйцэтгэж байна. Энэ судалгааны хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагуудаас хүний нөөцийн талаарх судалгааг авч байна. Уг судалгааны мэдээллийг зөвхөн эрдэм шинжилгээний зорилгоор ашиглах юм. Манай байгууллага нь нийгэм, эдийн засгийн судалгаа хийдэг. 63 жилийн түүхтэй, ууган байгууллага юм. Засгийн газраас цахим засгийн газар, цахим эрүүл мэнд гээд хөтөлбөр зарлачихсан байдаг. Гэтэл энэ нь хэрэгжих боломжтой эсэх тооцоо судалгаа дутмаг байна. Тэгээд энэ чиглэлээр боловсрол олгож буй сургуулиудын талаар мэдээлэл авах, энэ чиглэлийн боловсон хүчний хүрэлцээ хэр байдаг, хувийн хэвшилд ажиллаж байгаа боловсон хүчний чадавхи, давтан сургадаг эсэх, Монгол улсын дотоод их дээд сургуулийн хүчин чадал ямар байгаа юм, цаашдаа энэ чиглэл яаж хөгжих ёстой юм гэдэг талаар та бүхэнтэйгээ ярилцана.

**П.Эрдэнэжаргал:** Сургуулиа төгсөөд шинээр ажилд орж байгаа залуучууд ер нь бол ажлаа сайн мэдэхгүй л дээ. Сургаж л авна даа. Ер нь бол сургууль төгссөн залуучуудыг авах дуртай. Гэхдээ сургах зайлшгүй шаардлага гардаг. Яг юу хийх ёстой вэ гэдэг чиг үүргийг заавал зааж сургах болдог. Программ хангамжийн чиглэлээр төгсөж байгаа хүмүүс их ховор байдаг. Мэдээлэл технологийн салбарт хамгийн хүндрэлтэй байгаа зүйл нь программистийн эрэлт хэрэгцээ байгаа гэж бодож байна. Тухайлбал, программист зөвхөн мэдээллийн технологийн салбарт гэхгүйгээр банкинд хэрэг болж байна, энгийн нэг худалдааны байгууллагад хэрэг болж байна, эмнэлэгт хэрэг болж байна гээд бүх салбарт программист гэдэг орон зай маш хэрэгтэй болж байна. тиймээс программистийн эрэлт хэрэгцээ маш өндөр байдаг. IT-ийн компаниудын уулзалт болоход гол ярьж байгаа зүйл нь программистийг яаж олох вэ? гэдэг дээр гол яриа өрнөдөг. Сургуулиуд энэ чиглэлээр мэргэжилтэн төгсгөж байгаа хэдий ч сайн төгсөгчид маань ажил дээр гарахаасаа илүү старт-ап байгууллагыг сонирхоод яваад өгдөг. Тэгэхээр манайх үлдэж байгаа төгсөгчдөөс сонгох гэхээр шаардлага хангах төгсөгч бага байдаг. Зарим нь хангахгүй байна. Тэгээд бас программистууд гадаад улс орны их дээд сургуульд элсэх, гадаад улс орон руу явах боломжийг илүү хайдаг. Тэр ч үүднээс

гадаадын хөрөнгө оруулалттай компанид илүү ажилд орох сонирхолтой байдаг. Тэр нь ч бас манайхаас хавьгүй өндөр цалин, хангамж, боломжийг санал болгодог учраас тийм компани руугаа явах нь элбэг байна. Бид нарын зүгээс бол монголд барьж үлдэх хэрэгтэй бүхий л арга хэмжээг авч байна. Мэргэжилгүй байсан ч гэсэн ямар нэг программчлалын хэл мэддэг бол шууд ажилд авья гэдэг байдал руу ороод байна. Шинээр төгсөгчдийн мэдлэг чадвар хангалтгүй гэдэг дээр бол сайн хэлж мэдэхгүй байна. Миний бодлоор бол төгсөгчид улам илүү чадвартай төгсөж байгаа гэж боддог. Ялангуяа сүүлд төгсөж байгаа 1995 оноос хойших үеийнхэний англи хэлний мэдлэг аягүй сайн юм билээ. Англи хэлийг их сургуулиасаа юу, дунд сургуульдаа сайн сурсан уу алийг нь хэлж мэдэхгүй ч их сайн англи хэлтэй болсон байна. Тэр нь маш том давуу тал болдог. Өмнөх үеийнхнээ бодвол илүү санаа бодлоо нээлттэй хэлдэг болсон. Төгсөгчдийг харахад IT гэлтгүй Excel дээр ажиллаж чадахгүй байдаг. Энийг сайн ойлгохгүй байгаа, уг нь бол хэрэглээний программыг заагаад байдаг. Хамгийн энгийн, хамгийн их хэрэглэгддэг excel дээр ажиллаж чадахгүй болохоор бас их хэцүү ч юм шиг. Ийм ганц нэг хүндрэлүүд бол байгаа бусдаар бол гаагүй дээ.

**Модератор:** Программист бэлддэг сургууль нь тийм цөөхөн юм уу?

**П.Эрдэнэжаргал:** Үгүй, олон ш дээ.

**Д.Мөнхзул:** Би бол харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарт олон жил ажилласан. Сүүлийн 2-3 жил энэ чиглэлээр багшаар ажиллаж байна л даа. Ингээд ажиглаад байхад бодлогын түвшинд ямар арга хэмжээ авч байна гэдэг зүйл дээр ирдэг. Цэцэрлэг, сургууль, их дээд сургуульд шат шатанд нь бодлого явах ёстой гэж боддог. Цэцэрлэгийн хүүхдүүд, сургуулийн хүүхдүүдэд өнөөдөр компьютерийн хичээл орохгүй биш орж байгаа. Цэцэрлэг, сургуулийн бага ангид хүүхдүүд гар утсан дээр тоглоод компьютерийн анхан шатны мэдлэг олоод авч байгаа. Дунд сургуульд программ хичээл дээр юу заах вэ, ямар төвшинд бэлтгэгдээд төгсөх юм, их дээд сургуульд ямар төвшинд заагаад төгсөх юм, ажлын байрууд ямар шаардлага тавих юм гэдэг нь тодорхой байх хэрэгтэй. Би компьютерийн хэрэглээ гэдэг хичээлийг ордог. 10 жилээс орж ирж байгаа хүүхдүүдийн тал хувь нь компьютер гэж юу вэ гэдэгээ мэддэг, тодорхой хэмжээнд хэрэглээний программ дээр анхан шатны ойлголттой орж ирдэг. Тал хувь нь болохоор хулганаа ч барьж чадахгүй, хэрэглээний программын талаар мэдлэггүй хүүхдүүд орж ирж байгаа юм. Аль алинд нь мэдээлэл зүй гэдэг хичээл орсон байдаг. Та нар мэдээлэл зүйн хичээл дээр юу үзсэн юм бэ гэхээр тал нь болохоор энэ дэлгэц, энэ хулгана, энэ процессор гэдгийг заагаад өнгөрдөг. Сургуульд нэг ийм танхим бол байдаг. Гэхдээ компьютер дээр сууж үзээгүй гэдэг. Аа харин тал нь болохоор гэртээ компьютертээ, эсвэл хичээлдээ илүү сонирхолтой учраас сурсан байдаг. айл өрхийн санхүүгийн байдлаас бас хамаараад байх шиг байгаа юм. Программистийн чиглэлээр манайд элсэж байгаа хүүхдүүд өөрийгөө би бол компьютертээ сайн учраас программист болноо гэж орж ирдэг. Харамсалтай нь хичээлдээ сайн биш, тоглоомондоо гаршчихсан байдаг.

бараг донтолтын хэмжээнд оччихсон. Компьютерийн ангид орж ирж байгаа хүүхдүүдийн тал хувь нь донтолттой байна. Компьютерийн хичээл дээр хүүхдүүд фэйсбүүк, тоглоом тоглож байдаг. Хичээл орохын тулд сүлжээг хаах боломж байхгүй. Хэрэглээний программыг заах гэхээр ерөөсөө сонирхдоггүй, утсан дээрээ тоглоомоо тоглодог. Тэгээд утсаа далд цүнхэндээ хий гээд диктатурын байдал гаргахад өөдөөс ардчилал ярьдаг. Өөрсдийгөө компьютерт сайн гэж бодоод орж ирсэн хүүхдүүд яг мэргэжлийн дагуу хичээлүүд ороод ирэхээр төөрөлдөөд, мэргэжилдээ сонирхолгүй болчихдог. Нэгдүгээр курст 20 хүүхэд элслээ гэхэд төгсөж байгаа нь 10 хүрэхгүй хүүхэд байх жишээний. /бусад сургуульд ямар байдаг. хэдэн хүүхэд элсээд хичнээн хүүхэд төгсдөг вэ? дата /4 жилийн хугацаанд хасагдаад байна ш дээ. Яагаад гэхээр тухайн мэргэжлээ сайн ойлгож мэдэхгүй ороод ирсэн байдаг, программ бичнэ гэдэг тийм амар ажил биш л дээ. Маш их хэмжээний тэвчээр, маш их логик сэтгэлгээ шаарддаг. Тэгээд үндсэндээ тэрийгээ давж чадахгүй нь сургуулиа хаядаг.

**Модератор:** дунд сургуульд физик, математик, байгалийн шинжлэлийн хичээлийн цаг бага, багшлах боловсон хүчин тааруу болчихсон. МУИС-ийн физик-математикийн ангид орох хүүхэд байдаггүй. Их дээд сургуульд хэрэглээний программ, мэдээллийн технологийн хичээл хэтэрхий high чиглэлийн юм заадаг юм уу. энэ талаар мэдээлэл өгөөч.

**Д.Мөнхзул:** Хамгийн эхлээд оюутнуудаа компьютертээ харьцаж сургая. Программ гэж юу юм, техник хангамж гэж юу юм гэдэг талаас нь заана. Дээр нь хэрэглээний үндсэн программ болох word, excel, power point-оо заана. Заахдаа бид нар бие даалтыг нь шивүүлдэг, excel дээр хүснэгт бүтээлгэж тооцоолон бодох арга заадаг. Power point –оор бол мэдээж пресэнтаци, илтгэл бэлдүүлж ажиллуулж сургадаг. Нэгдүгээр курст бол ингээд хэрэглээний программууд дээр ажиллаж сурдаг. Харин 2 дугаар курст болохоор илүү мэргэжлийн чиглэлээсээ хамаараад нарийн мэргэжлийн хичээл ороод явна. Компьютерийн ухаан, мэдээллийн технологийн ангийн хүүхдүүд болохоор программын үндсэн хэл си, java, лайнокс гээд хичээлүүд ороод явдаг. Энэ хичээл дээр л утасны хялбар апп бичих вэ?, хаалга онгойлгох энгийн программ бичих вэ? гэдэг анхан шатны мэдлэгээ аваад харин программистуудын ангид болохоор өндөр түвшний программ бичих бүх хичээлээ үзээд явдаг. Дунд сургууль төгсөж буй сурагчдын мэргэжил сонголт, мэргэжлийн чиг баримжаа олгох тал дээр маш сайн анхаарах хэрэгтэй. Юугаа ч мэдэхгүй ороод ирсэн хүүхдүүд сургуулиа төгсөхгүй дундаас нь хаяна. Чадваргүй боловсон хүчин болдог.

**Модератор:** Мэдээлэл технологийн чиглэлийн хамгийн эрэлттэй мэргэжлийн жагсаалт гарсан байна лээ. Ирээдүйд сүлжээний эмч, дата анализ гэх мэт мэргэжлүүд эрэлттэй байна гэсэн тооцоо гарчээ. Энэ чиглэлээр манайх мэргэжилтэн бэлтгэдэг эсэх, энэ чиглэлийн боловсрол олгож байгаа дэлхийн жишигийн талаар судалж үзсэн үү?

**Д.Мөнхзул:** тодорхой түвшинд явж байна. Одоо чинь нөгөө аж үйлдвэрийн 4-р хувьсгал тоон технологи дээр суурилсан хөгжил явагдана гэж үзэж байгаа. Энэ дээр юу вэ гэхээр их дата буюу big data, энэтэй уялдаад асар их хэмжээний мэдээлэл орж ирж байгаа энэ их мэдээлэлд яаж анализ хийх үү, эндээсээ яаж хэрэгтэй мэдээллээ ялгаж цаашдын үйл ажиллагаанд ашиглах уу гээд дата анализ гэдэг юм маань явагдаж байна. хоёрдугаарт зүйлсийн интернэт буюу бидний эргэн тойронд байгаа бүхий л зүйлийг интернэтэд холбох энэ чиглэл рүү явж байна. Дээрээс нь хиймэл оюун ухаан гэсэн энэ 2 зүйл дээр дэлхийн мэдээллийн технологийн чиг хандлага явж байна. Тэгэхээр манай сургуулийн хувьд энийгээ дагаад аюулгүй байдал маань өндөр тавигдаж эхэлнэ. Системийн хувьд, техник тоног төхөөрөмжийн хувьд, сүлжээний хувьд аюулгүй байдлаа хэрхэн хангах ёстой вэ? гадны халдлагаас яаж хамгаалах юм гэдэг асуудал байдаг. Нөгөө талаас мэдээллийн аюулгүй байдал гэдэг асуудал байдаг. Бидэнд байгаа энэ их мэдээллээ яаж хамгаалах юм, яаж алдахгүй байх юм гэдэг асуудал яригддаг. Манай сургуулийн хувьд бол мэдээллийн аюулгүй байдал, системийн аюулгүй байдал гэдэг чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байна. Мөн программист, software engineer, computer science чиглэлээр багш нараа бэлтгэж байгаа. Манай гол хүндрэл бол багшлах боловсон хүчиний дутагдалтай байдал. Манай сургууль БНСУ-ын хөрөнгө оруулалттай сургууль учраас солонгосоос багш нар ирээд тодорхой хэмжээнд заадаг. Гэхдээ л бид нар энэ жил системийн аюулгүй байдал талдаа багш авах гээд олж чадсангүй. Асар их хэмжээгээр мэргэжилтэн бэлтгээд байгаа юм шиг хэрнээ маш их ажиллах хүчин дутагдалтай салбар бол мэдээллийн технологийн салбар болоод байна. гаагүй суралцаж байгаа оюутнууд нь 3-4-р курсээс эхлүүлээд байгууллага дээр дадлага хийгээд программистуудыг дагалдаад хөгжөөд шууд ажилд ороод явчихдаг. Нэлээд хөгжөөд ирэхээрээ зэрэг старт-ап компани байгуулаад явчихдаг. Нөгөө нэг хэсэг нь болохоор гадагшаагаа магистрт яваад тэндээ /гадаадад/ үлдчихээд байдаг. тэгэхээр хамгийн гол нь нэгдсэн бодлоготой байхгүй бол боловсон хүчний хэрэгцээ шаардлага аль аль талдаа дутагдалтай байгаад байна. Тухайлбал, дунд сургууль төгсөгчдөөс их дээд сургуульд ордог босго оноог хүртэл өөрчилмөөр байна. Улсын сургуулиуд босго оноогоо доогуур тавингуут хувийн сургуулиуд яах юм бэ? цаашаа оршин тогтохын тулд бага оноотой хүүхдүүдийг авч сургахаас өөр аргагүй. Энэ салбарт хичнээн хэмжээний боловсон хүчин хэрэгтэй байгаа талаар ажил олгогчийн эрэлт хэрэгцээний судалгаа маш дутмаг байна. ажлын байрны шаардлага, сургалтын хөтөлбөр, агуулга зөрөх тохиолдол бас гардаг. Манайх солонгост оюутан солилцоогоор хүүхэд явуулдаг, солилцоогоор яваад ирсэн хүүхэд шал өөр болоод ирдэг. Цаашаа өсөх эрмэлзэл, харьцаа хандлага хамаагүй өөр болсон байдаг.

**М.Мөнхцэцэг:** манай байгууллагад дата анализ, data science чиглэлийн боловсон хүчин хэрэгтэй байгаа юм. энэ чиглэлээр хүн авъя гэхээр монголд энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа сургууль байхгүй бид нар математикаас нэг үзнэ, статистикаас үзнэ, ШУТИС-ээс харна, ХААИС-ийг харсан. Боломжтой гэсэн бүх сургуулиас дата анализ чиглэлийн мэргэжилтэн хайж үзсэн. Ингээд хамгийн дөхдөг нь математик программ суурьтай хүмүүс байдаг. яг хоёуланг нь эзэмшсэн хүн хайхаар олдож өгдөггүй. Ийм

мэргэжил нь байхгүй болохоор мэдээж хэрэг. Одоо хэр нь манайд энэ чиглэлээр төгсөж байгаа мэргэжилтэн байхгүй. Харин гадаадад энэ чиглэлээр төгсгөөд байдаг. Монголд хайхаар ерөөсөө олддоггүй. Хэрвээ бодлого байсан бол бид нар аж үйлдвэрийн 4-р хувьсгал, биг дата гээд явж байгаа бол энэ чиглэлийн боловсон хүчнийг аль хэдийн бэлтгэж эхэлсэн байх ёстой. Ядаж хувийн сургуулиуд нь биш юмаа гэхэд улсын сургуулиуд нь аль хэдийн мэргэжилтэн бэлтгээд эхэлчихсэн баймаар байгаа юм. Одоо бэлтгэж эхлээгүй байна гэхээр хэзээ элсэлтээ авч эхлэх үү, элссэн суралцагч нь хэзээ төгсөх үү гээд наад зах нь 4-5 жил болно гэхээр бид нар дэлхийн хөгжлөөс маш их хоцрогдоно. Тэрийг л бодлого гэх байх гэж бодож байна.

**Д.Мөнхзул:** энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэе анги нэе гэхээр багшлах боловсон хүчин байхгүй. Тэгэхээр улсаас бодлогоор дэмжих зайлшгүй шаардлага байна. Сургуулиуд бол зах зээл дээр ийм мэргэжил эрэлттэй байна гээд нэг анги нээгээд явдаг. Төрөөс тэр талаас ямар бодлого баримталж байгаа юм, ямар мэргэжилтэн хэрэгцээтэй байгаа юм, ажил олгогчийн зүгээс ямар шаардлага тавьж байгаа талаар тодорхой бодлого байхгүй байна. Дотооддоо бэлтгэх юмуу, гадаадад сургах юмуу гэдэг нь бас тодорхой байх хэрэгтэй. Дотооддоо боловсон хүчин бэлтгэхийн тулд гадаадад сургаж багш бэлтгэх хэрэгтэй болно. Тэр багш нар нь ирээд оюутнуудаа сургадаг хэлбэрээр явах ёстой гэж бодож байна. Тэгээд хувийн их дээд сургуулиудад мэдээлэл хүртэх, авах боломж харьцангуй хаалттай байдаг.

**Модератор:** Засгийн газраас ямар дэмжлэг үзүүлбэл зүгээр вэ?

**Т.Отгонжаргал:** Засгийн газар дотоод болон гадаадад санамж бичиг байгуулаад оюутан сургадаг ш дээ. Миний хувьд гэхэд 2002 онд дэд бүтцийн яамны захиалгаар хот төлөвлөгч мэргэжлээр явсан. Тэгээд хот төлөвлөгчөөр сураад төгсөөд ирсэн чинь яам маань татан буугдсан байсан. Тэгэхээр юу гэх гээд байна вэ гэхээр тогтсон нэг бодлогын баримт бичиг, хөтөлбөр хэрэгтэй болжээ. Нэг засгийн газар солигдоод ч юмуу, нэг дарга нь солигдоод өмнө нь хийж хэрэгжүүлж байсан бүх зүйлээ үгүйсгэдэг, нураадаг байж болохгүй. Төр засагт хэн ч гарсан бай, бодлогыг үргэлжлүүлээд явах тийм зүйл манайд дутагдаад байна. бодит жишээ нь би өөрөө болж байна. 2020-2030 он гэхэд бид нар хаана хүрсэн байх ёстой юм, ямар үр дүнд хүрсэн байх ёстой юм. энэ чиглэлийн яам, агентлагаас нь эрэлт хэрэгцээтэй байгаа боловсон хүчний тоог гаргаад их дээд сургуультайгаа холбоотой ажиллах ёстой гэж харж байна. Төлөвлөгөө, бодлогын баримт бичиг гэхээр ерөөсөө тодорхой зүйл байдаггүй. Хэзээ, яаж, хэрхэн гэдэг асуултанд хариулагдах зүйл байдаггүй. Зөвхөн тунхаг, уриа ч юм шиг хэдэн зүйл бичээд орхичихдог байдлаасаа салах хэрэгтэй байна. Тухайлбал, УБЕГ-аас саяхан цахим архивын ажил зарласан байгаа юм. тэр нь дээр монголын IT-аас ороогүй Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр гаднаас зөвлөхүүд аваад ажиллуулсан. Дараа нь тэр ажлаа үргэлжлүүлээд явах гэсэн чинь тэр ажлыг нь хийж чаддаг боловсон хүчин байхгүй. Тэгээд тэр ажил нь унаж байгаа байхгүй юу. Цахим архивтай боллоо гээд л

байдаг 2019 оны бичиг баримтаа архивлая гэхээр хийж чадах хүн байхгүй, дахиад л баахан мөнгө төлөх хэрэг гардаг. Нэг байгууллагад л ийм зүйл үүсч байна гэхээр ийм байдалтай газар хичнээн байгааг мэдэх аргагүй байна.

**Модератор:** За баярлалаа. Дараагийн хэсэгтээ орёе. Төгсөгчдийн ажлын байрны орчин нөхцөл, сүлжээний хүчин чадал, компьютерийн хүчин чадал ч юмуу ямархуу байдаг вэ?

**Б.Монголжингоо:** Их дээд сургуульд багш нар мэдлэгийн 30-40%-ийг өгдөг. Үлдсэн нь оюутны өөрийн хүчин чармайлтаас шалтгаалдаг. Оюутнууд программ хангамж дээр хичнээн код бичээд, хичнээн сүлжээ дээр ажиллаад байгаа хэдий ч тоног төхөөрөмжийн асуудал яригддаг. Бид нар дадлага бодит тоног төхөөрөмж дээр хийж чаддаггүй. Хийсвэр виртуалаар хийдэг. Төгсөж гараад төхөөрөмж дээрээ ажилаад үзэнгүүд өмнө нь харж байгаагүй, ажиллаж байгаагүй тоног төхөөрөмж дээр очихоор 1-2 жил зайлшгүй дагалдах шаардлага гардаг. Сургууль дээр тоног төхөөрөмж байна. гэхдээ тэр нь бас л яг үзүүлэнгийн маягийн байдаг. Хэн ч тэр нь дээр ажилдаггүй, тэр төхөөрөмжийг асаадаггүй, зөвхөн шалгалтын үед ч юмуу шаардлагатай тохиолдолд ашигладаг. Тийм болохоор сургалт явагдаж байгаа орчин илүү бодит, ажлын байран дээр гараад шаардагдах чадварыг суулгахад зориулагдсан байх ёстой гэж бодож байна. мөн энэ чиглэлээр сургуульд элсэж байгаа оюутнуудын тоо олон ч гэсэн төгсөж байгаа тоо нь аягүй цөөхөн ш дээ. Тэгээд тэр дундаасаа илүү чадвартай, шууд ажиллах чадвартай нь хэд байх вэ гэдэг асуудлууд байдаг.

**Д.Мөнхзул:** Улсын их дээд сургууль дадлагад гаргахад асуудал багатай. Ямар ч газар хүлээгээд авчихдаг. Гэтэл хувийн сургуулийн хувьд хэцүү л байдаг. ихэвчлэн өөрсдийнхөө танил тал, найз нөхдөөр дамжуулж оюутнуудаа дадлагад гаргадаг. Зарим хүүхдүүд нь өөрсдөө дадлага хийх газраа олдог. Ийм байдалтай байдаг. гэтэл энд агентлагаас ч юмуу салбарын сургуулиуд болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдийг холбож өгөх, аж ахуй нэгжид дадлага хийлгэх үүрэг хариуцлага оногдуулах ч юмуу зохицуулалт хэрэгтэй гэж бодож байна. харилцаа холбооны компаниуд голдуу ШУТИС-тай холбоотой ажилладаг. Диплом хамгаалалтын үеэр нь гаагүй хүүхдүүдээ шууд ажилд авчихдаг. Мөн дадлагад гарсан хүүхдүүдээ төгсөнгүүт нь ажилд авдаг. Гэтэл хувийн дээд сургуульд энэ байдал байхгүй байгаад байна.

**Модератор:** Баярлалаа. Шинээр төгсөгчидийг аж ахуй нэгжүүд сургаж ажилд авдаг гэсэн. Тэгэхээр их дээд сургуульд сурчихсан хүүхдүүдийг дахиад сургадаг гэхээр гайхаад байна л даа.

**П.Эрдэнэжаргал:** Яахав сургана гэхээр албан ёсны сургалт биш л дээ. Дадлагажуулах, ажилд сургах үүднээс тухайн чиглэлийн мэргэжилтнийг дагалдуулан сургах үйл явцыг ойлгож болно.



**Ө.Гантулга:** Энэ тал дээр надад нэг санал байна. Энэ салбараар төгсөгчдийн мэдлэгийн төвшин нэлээд бага байдаг. Гол багш нь юу байдаг вэ гэхээр интернэт өөрөө болчихдог. Хичнээн өндөр голч дүнтэй төгсөөд ирсэн ч гэсэн хэлний мэдлэг хангалтгүй байдаг. Дэлхийн хэл буюу англи хэлийг маш сайн сурах нь энэ салбарт маш чухалд тооцогдоно гэж би хардаг. Хэлийг бага, дунд сургуульд нь сайн эзэмшүүлээд гаргачих юм бол оюутнууд багшаас онолын мэдлэгээ аваад гол мэдээллээ интернэтээс авчих бүрэн боломжтой. Манайд ажилд орохоор материалаа өгсөн хүмүүсээс би бол англи хэлний яриа болон текстээр шалгалт авдаг. Ихэнхи нь унадаг. Онолын юм бол нэг их харахгүй дээ. Хамгийн том үзүүлэлт бол хэл байдаг. мэдээж хятад, орос гэхгүй англи хэлээр шалгалт авдаг. Тэгээд 70-80%-тай байх юм бол болж байна гэж үзээд ажилд авдаг. Яагаад хэл шаардаад байна вэ? гэхээр бид нарын хийх ёстой юм ерөөсөө л интернэтэд англи хэл дээр бэлэн байж байдаг. чиглэлийг нь гаргаад өгчихнө, мэдээллээ интернэтээс л олох болно. Тэгэхээр бидэнд хэлгүй хүн ямар ч шаардлагагүй болчихож байгаа юм. Хэлэх гээд байгаа гол санаа бол маш сайн хэлтэй байх нь энэ чиглэлээр ажиллах боломжийг бүрэн олгоно. Миний хувьд гэхэд би бол мэргэжлийн программист юмуу сүлжээний инженер биш гэхдээ мэдээллээ интернэтээр олж аваад энэ салбарт хөрвөж ажиллаж чадаж байна. их дээд сургуульд онол гээд л байдаг. гэтэл бодит практик дээр асуудлыг онол шийдэж чадахгүй байна. Онолоо мэдээд байдаг ямар ч асуудал шийдвэрлэх чадваргүй байдаг.

**М.Мөнхцэцэг:** Манайх ч мөн адил шинээр төгссөн залуучуудыг дагалдуулан сургаж авдаг. Хүнтэй ингэж харьцах ёстой юм байна, ингэж ажиллах ёстой юм байна, хэлээ сайжруулах ёстой юм байна гээд энгийнээс эхлээд бүх зүйлээ сураад явдаг. Тэгээд ажилаа мэдээд дадлагажаад ирэхээр нь гадаад, дотооддоо мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах зэргээр чадавхижуулаад явдаг. Ингэж байж чадварлаг сайн мэргэжилтэн болгож авдаг. Энэ үйл явцыг сургаж байна гэж ойлгож байгаа.

**Модератор:** Монголд мэдээллийн технологийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх албан ёсны байгууллага байгаа юу?

**Ө.Гантулга:** Дэлхийн хэмжээнд бэлдэх байгууллага бол байхгүй ш дээ. Одоо хэлтэй бол онлайн сургалт гэж байгаа. Онлайнгаар сураад дипломоо аваад явах боломж нээлттэй болсон. Гол нь хэлний асуудал л байдаг.

**Д.Мөнхзул:** Дунд сургуулиа төгсөөд их дээд сургуульд орох хүсэлтэй хүүхдүүдийн тоо маш их байдаг. мэргэжил сурталчилах өдөрлөг зохион байгуулаад харж байхад энэ мэргэжилийг сонирхож байгаа хүүхдүүдээс асуусан. Чи яагаад энэ мэргэжлийг сонгох болов оо гэхээр хүн болгон энэ мэргэжлийг сонгож байна, ирээдүйд эрэлт хэрэгцээ ихтэй, төгсөөд ажлын байр хангалттай, өндөр цалинтай гэж хариулдаг. Нэг хэсэг нь болохоор миний өгсөн шалгалтаас хамгийн өндөр оноотой нь энэ байгаа юм. тэгэхээр би энэ чиглэлээр сурах ёстой юм байна аа гэдэг. Бас нэг хэсэг нь манай ээж аав намайг энэ чиглэлээр сур гэсэн хариултууд орж ирдэг. Гэтэл хүүхдүүд маань 10 жилдээ энэ

мэргэжил яг яадаг мэргэжил юм бэ, би яагаад энийг сонгох ёстой вэ гэдэг ойлголтгүй орж ирж байна. тэгэхээр эндээс мэргэжлийн нэр хүнд, төгсөгчдийн байдал, ажил эрхлэлт, боловсон хүчний чадавхи ямар байх нь тодорхойлогдоод байна. дунд сургуульд мэргэжил сонголтын талаар мэдээлэл дутмаг байна, дээд боловсролтой л болж байвал юу ч байсан хамаагүй гэдэг байдлаар хандсан хандлага байгаад байна. тиймээс жил бүр эрэлт хэрэгцээтэй мэргэжлийн жагсаалт гаргаад дунд сургуулиудаар мэргэжил сонголтын сургалт зохион байгуулах ажил хийгдэх нь зүйтэй гэж харж байна.

**Модератор:** Харилцаа холбооны чиглэлээр МСҮТ, коллеж гэж байдаг уу?

**Д.Мөнхзул:** Бараг байхгүй байхаа. Шинэ монгол технологийн коллеж гэж байдаг. яг харилцаа холбоо, мэдээллийн технологиор боловсрол олгодог эсэхийг нь сайн мэдэхгүй байна.

**Б.Батбаатар:** Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг 4-5 жилийн давтамжтай манай Хөдөлмөр Нийгэм хамгааллын Институт хийж байна. Өөрөөр хэлбэл ажлын байранд хэрхэн яаж зуучлагдаж байгаа юм. Төгсөгчдийн өмнө тулгарч байгаа хүндрэлтэй асуудлуудыг илрүүлэхэд манай байгууллага ажиллаж байна. ингэснээр бодлого боловсруулах түвшинд танилцуулах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг зохицуулахад том хувь нэмэр болно гэж үзэж байгаа. Ажил олгогчдын гол тавьдаг шаардлага нь ур чадвар, багаар ажиллах чадвар, харилцаа хандлага, гадаад хэл, математик сэтгэлгээ зэрэг хувь хүний хөгжлийн асуудал хамгийн эхэнд тавигдаж байна. үүнийг сургуулиуд маань тухайн оюутанд суулгаж өгч чадаж байна уу гэдэг асуудал байна. Өнөөдөр мэдээллийн технологийн мэргэжил гэдэг бол монголын нийгэмд өрсөлдөх чадвар маш их байгаа. Гагцхүү энэ ажилд тэнцэх мэргэжилтэн бэлтгэх асуудал нэгдүгээрт тавигдах ёстой болоод байна.

**Модератор:** Хөгжингүй орнууд мэдээллийн технологийн салбар тогтвортой байхын тулд нийт боловсон хүчний 2-оос доошгүй хувь байх ёстой гэдэг бол Монгол улсын хувьд нийт ажиллах хүчний 0.8 хувьтай байна гэсэн судалгаа байна. энэ тал дээр та бүхэн ямар бодолтой байна.

**Т.Отгонжаргал:** Тэгэхээр энэ чиглэлд яалт ч үгүй төрийн бодлого, зохицуулалт хэрэгтэй байна. Энэ чиглэлд хичнээн боловсон хүчин байгаа юм, ямар чиглэлийн мэргэжилтэн дутагдалтай байгаа юм гэсэн тооцоо судалгааг харьяа яам, агентлагууд гаргаж байх ёстой. Хэрвээ тэр мэргэжлээр нь хүн сурахгүй байгаа бол тэтгэлэг, татаас өгөх ч юмуу ийм байдлаар зохицуулалт хийгээд явах эрх нь төрд байна. Хэрвээ Монгол улс цаашдаа байна гэж үзэх юм бол харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар луу хүссэн хүсээгүй холбогдох учраас ингэж л зангидаж авч явах хэрэгтэй. Тэгээд мөн багш нар дээр анализ хийх хэрэгтэй. Багш үнэхээр мэдлэг олгож чадаж байна уу, үгүй юу, хоёр цаг үнэхээр оюутнуудад юу зааж байна, эсвэл зүгээр цаг нөхцөөж байгаад гарч байна уу. өнөөдөр ганц консфектээ 4 жил уншиж байна уу, эсвэл шинэчлэгдэж байна уу

гэдэг дээр хүртэл анализ хийх хэрэгтэй болж байна. Засгийн газрын бодлогоор энэ чиглэлээр оюутнуудыг тэтгэлэгээр явуулах хэрэгтэй байна. Яагаад гэвэл боловсон хүчин гэдэг бол өөрөө Монголын ирээдүй. Тэр хүмүүс л монголыг авч явна.

**Модератор:** Хувийн байгууллагууд шаардлагатай судалгааг гаргаж өгдөг үү?

**М.Мөнхцэцэг:** Манайхаас бол янз бүрийн судалгаа аваад л байдаг. Улсын хэмжээнд ямар чиглэлийн мэргэжилтэн дутмаг байгааг тодорхойлоод тухайн чиглэлийн элсэлтийг илүү дэмжих, нийлүүлэлт их байгаа мэргэжлийн элсэлтийн тоог багасгах ч юмуу зохицуулалт хэрэгтэй гэж харж байгаа.

**Б.Батбаатар:** Их дээд сургууль төгсөгчдийн 60 хувь нь нийгэм, хүмүүнлэг, бизнесийн удирдлага, багш мэргэжлээр төгсөгчид байна. тэгээд дээр нь хувийн сургууль төгсөгчдийн 10 төгсөгч тутмын 4 нь бизнесийн удирдлага, багш, нийгэм, хүмүүнлэгийн салбарын төгсөгч байна гэсэн судалгаа байна. Тэгэхээр эндээс юу харагдаж байна вэ ямар ч төлөвлөлт, тооцоо судалгаа байхгүй зүгээр л сургаад л хоосон дипломтой ажилгүйчүүдийн эгнээг бий болгоод байдаг. гэтэл цаана нь хэрэгтэй салбартаа ажиллах хүч, чадвартай боловсон хүчин олдохгүй, байхгүй байх жишээний. Мөн багшийн чадвар маш их хоцрогдсон. Багш өнөөдөр хэн болж хувирсан бэ гэхээр цалин горилогч болж хувирсан. Оюутнууддаа гологдсон багш нар маш их байна.

**Д.Баяржаргал:** Оюутан, залуучуудын хувьд юу ажиглагддаг вэ гэхээр тухайн цагтаа “бүүм” болсон мэргэжлээр илүү сурах хүсэлтэй байдаг. нэг хэсэг уул уурхай гэж байсан бол одоо барилгын мэргэжлийг 1-т сонгодог болсон. Харин 3-рт мэдээллийн технологийн салбар орж ирж байгаа. Тэгэхээр бид нарын гол зорилго нь манай салбарыг хүүхдүүд 1-рт сонгодог болгох явдал юм. Энэ салбарын үнэлэмжийг өсгөх, зөвөөр ойлгуулах, мэргэжил таниулах зэрэг үйл ажиллагаа хийгээд эхлэх юм бол энэ салбарыг сонгох хүүхдүүдийн тоо нэмэгдэнэ. Гуравдугаарт сонгогдож байна гэдэг нь бас л маш сайн суралцагчаа алдаж байна гэсэн үг юм. Энэ чиглэлд англи хэлээс гадна нөгөө талд нь математик, мэдээлэл зүй заавал байх ёстой. Шат шатны боловсролын байгууллагын чанар, багш нарын ур чадварт маш сайн анхаарахгүй бол их дээд сургуульд юу ч мэдэхгүй хүүхэд орж ирж байна гэдэг зүйл маш их яригддаг.

**П.Эрдэнэжаргал:** Манай салбарт хамгийн эрэлттэй байдаг программистуудын цалин хамгийн өндөр байдаг. Энд ажиллах хүн олдохгүй байгаа нөхцөлд олсон хүнээ гадагшаа алдахгүй байхын тулд өндөр цалин, хангамжийг санал болгодог. Дэлхий даяар программистуудын эрэлт маш өндөр болчихсон. туршлагатай мундаг программист олох маш хэцүү. Үүнийг бодлогоор зохицуулж өгөхгүй бол Монголдоо сайхан амьдарья гээд л байдаг хувийн хэвслүүд хамгийн өндөр цалингаа өгч байгаа хэдий ч гадаад улстай харьцуулахад маш бага байдаг. тэгэхээр ядаж амьдрах бусад нөхцлүүд нь сайн байж тэд нар үлддэг ч юмуу ямар нэгэн байдлаар зохицуулалт зайлшгүй хэрэгтэй байна. Гадаадад мэргэжил дээшлүүлж ирээд заавал 3-5 ажиллах ёстой ч гэдэг юмуу бодлогоор

уяж өгөхгүй болохоор нөхдүүд гадагшаа явлаа гээд буцаж ирдэггүй. Монголд болохоор хэл сайн мэдэхгүй, дундаж хэлтэй хүмүүс л ажиллаад байгаа байхгүй юу. Мундаг сайн хэлтэй устай, чадвартай хүмүүс нь явчихсан манай хувийн хэвшлийнхэнд ийм зүйл байнга тохиолдож байна. Нэг талдаа бэлдсэн хүмүүсээ алдчихдаг, нөгөө талдаа шинээр хүн авья гэхээр шаардлага хангадаггүй. Эрэлт аймаар өндөр болчоод нийлүүлэлт хаана ч байхгүй байдаг. бараг л энэтхэгээс ажиллах хүч авах уу яах уу гээд бөөн яриа болж байгаа юм.

**Д.Мөнхзул:** Нээрээ энэ боловсролын тогтолцоон дээрээ анхаарахгүй бол болохгүй болчихжээ. Дунд сургууль төгсөөд ирж байгаа хүүхдүүд хичээл заахаар ойлгодоггүй. Дунд сургуулийн мэдээлэлзүйн хичээлийн агуулга ямар байдаг, багш нарын чадвар ямар байгаа вэ? гэдэг асуудал яригдах ёстой болчихоод байна. их дээд сургууль нь босго оноогоо 450 байснаа 400 болгочихсон. Босго оноо бага байх тусам л чанаргүй, мэдлэггүй байдал руу яваад байна.

**О.Бат-амгалан:** БСШУЯ-ны 404-р тоот тушаалаар тухайн их дээд сургуулийн эрдмийн зөвлөл ямар чиглэлээр ямар оноогоор элсэгч авахаа шийддэг болчихсон.

**Б.Батбаатар:** дунд сургуулийн мэргэжил сонголт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт сүүлийн үед их хийгдэх болсон. Одоо хүүхдүүдээс мэргэжлээ сонгосон уу гээд асуухаар 70-80хувь нь сонгосон гэж хариулдаг. Яг ямар мэргэжил сонгочихов, ийм мэргэжилтэй хүн юу хийдэг вэ гэдэг талаар маш тодорхой мэдээлэл өгөх хэрэгтэй. Мэргэжил сонголтыг илүү бодит болгомоор байна. Хөдөлмөрийн бирж дээр хамгийн их байдаг зар нь хамгаалагч, тогооч, үсчин, гоо сайхан гэсэн хэдэн түгээмэл зар л байдаг. бусад тэр хэрэгцээтэй хүмүүс нь хаачсан юм, нөгөө олон дипломтой хүмүүс нь хаана байгаая гэдэг асуудал гардаг.

**Модератор:** математик суурьтай хүүхдүүд нь инженер, уул уурхай чиглэл рүү явчихдаг. Хэлтэй хүүхдүүд нь олон улсын харилцаа, эдийн засаг гээд явчихдаг. Энэ хүүхдүүдийг яаж мэдээллийн технологийн мэргэжлийг сонгуулах вэ?

**Г.Батнасан:** Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын инженерүүд, программистууд яагаад хэрэгтэй байдаг, энэ салбарын ач холбогдлыг маш сайн ойлгуулах, энэ мэргэжлийг сурталчилах, энэ мэргэжлийн давуу талыг таниулах хэрэгтэй. Агентлагаас энэ салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудад ямар мэргэжилтэн дутагдалтай байна вэ гэдэг талаар судалгаа гаргаад их дээд сургуулиудтай хамтран ажиллах хэрэгтэй. Ийм байдлаар эрэлтэд нийцсэн мэргэжилтэн бэлтгэх шаардлагатай байна. Манай байгууллага гэхэд сурган байгууллага болчихож байгаа юм. ажилд ороод дадлагажаад, ажлаа мэдээд ирэхээр нэг бол хувийн байгууллага руу явна, нөгөө бол их дээд сургуульд сурлаа гээд гадаад руу яваад өгдөг. Зүгээр л туршилтын байгууллага болж байна. цалин мөнгөө голоод ажиллах орчноо голоод туршлагатай, мэдлэгтэй залуучууд маань яваад өгдөг. Бид нар тэр хүмүүсээ алдмааргүй

байдаг. тэгэхээр энд тодорхой хэмжээний төрийн дэмжлэг хэрэгтэй байгаа юм. Монгол улсын мэдээлэл технологийн салбарын ирээдүйг ХХМТГ тодорхойлж байх ёстой.

**Д.Мөнхзул:** Суурь боловсролыг маш сайн тавьж өгөх ёстой юм байна. энэ чиглэлээр сурах гэж байгаа хүүхэд заавал мэдээлэл зүйн хичээл үзсэн. Бага ч гэсэн ойлголттой болсон байх явдал маш чухал болоод байна. их дээд сургуульд орж ирсэн хүүхдийг хүмүүжүүлнэ, хүчээр сургана гэдэг зүйл байдаггүй юм байна. чадварлаг хүүхдүүд нь тэтгэлэгээр явчаад байна, эцэг эх нь боломжтой хүүхдүүд бас гадаад руу явж байна. дундаж нь улсын сургуульд орж байна, тэрнээс доогуур нь хувийн сургуульд орж байна.

